

## **ӨМЧИЙН БҮХ ХЭЛБЭРИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ХӨТЛӨГДӨХ БҮРТГЭЛИЙН МАЯГТЫН ХӨТЛӨХ ЗААВАР**

Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагууд нь статистикийн бүртгэлийн маягыг хөтлөхөд энэхүү зааврыг баримтлана. Эрүүл мэндийн байгууллагад өдөр тутам хийгдэж байгаа эмчийн үзлэг, оношлогоо, шинжилгээ, эмчилгээ, сувилгаа зэрэг аливаа ажил үйлчилгээг зориулалтын маягт дээр тэмдэглэсэн бүртгэлийг эмнэлгийн анхан шатны баримт гэнэ. Эдгээр маягт нь нэг талаас шинжилгээ судалгаа болон албан хэргийн үнэт баримт нөгөө талаас болсон, хийсэн процессыг тухайн үйлчилгээний үед нь тэмдэглэсэн цаг хугацааны тэмдэглэл, түүхийн баримт бичиг болдог. Мөн эмнэлгийн ямар ч үзлэг, эмчилгээ, үйлчилгээ нь зөвхөн анагаах ухааны зохих мэргэжил эзэмшсэн хүмүүст хууль ёсоор зөвшөөрөгдөж, тэдэнд олгогдсон эрх хэмжээний дагуу хийгддэг учраас үнэн зөв хөтлөгдсөн эмнэлгийн бүртгэлийн маягтууд нь мэргэжлийн ба хуулийн чухал баримт болдог. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа, хүн амын эрүүл мэндийг хамгаалах ажилд үнэлэлт өгөх, нэгтгэн дүгнэх, мэдээлэх, төлөвлөлтийн аливаа асуудалд эмнэлгийн анхан шатны баримтууд үндсэн тулгуур материал болдог. Иймээс эмч, эмнэлгийн ажилтан бүхэн эмнэлгийн анхан шатны маягт, тооцооны баримтуудыг үнэн зөв хөтлөхөд чухал ач холбогдол өгч, тэдгээрийг хөтлөхдөө туйлын анхааралтай хандаж мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх нь тэдний үндсэн үүрэгт ажлын бүрэлдэхүүн байх ёстой.

Эмнэлгийн баримт бичгийг нямбай зөв хөтлөх нь зөвхөн гаргацтай гоё бичихийг хэлэх бус уг баримт бичигт хариулах ёстой бүх асуултыг бүрэн гүйцэд бөглөж, асуугаагүй боловч заавал тэмдэглэх шаардлагатай зүйлд зориулан зай гаргасан хэсэгт холбогдох тэмдэглэл хийсэн байвал зохино.

Бүртгэлийн маягыг хөтлөх ерөнхий зарчим ижилхэн боловч маягт болгон өөрийн зорилго асуусан асуумжаараа өвөрмөц ялгаатай. Гэвч тэр бүхэнд тодорхой асуудлыг яаж хариулж бичихийг нэг бүрчлэн тайлбарлах боломжгүй учир зарим онцлог маягтуудыг эмнэлгийн үйлчилгээний аль хэсэгт хөтөлж юу юуг тусгаж хэрхэн нөхөж бичих талаар анхаарах зарим зүйлсийг маягтын ерөнхий дугаар, тухайн маягтын дотор заасан хэсэг бүлэг, буюу мөрийн дугаарын дагуу тайлбарлах нь зүйтэй.

Бүртгэлийн маягт хөтлөхдөө хар өнгийн бал, бэх, эсвэл нэг өнгийн балаар маягтад засвар оруулсан, балласан, дарж зурсан, засваргүй, бичлэг дарах засах, шингэн хэрэглээгүй, товчилсон үг хэрэглэхгүй, бүтнээр ойлгомжтой бичиж эцэст үнэн зөв бичигдсэн эсэхийг нягтлан шалгасан байх зэрэг ерөнхий шаардлагыг баримтлах шаардлагатай.

### **Өрх, сумын эрүүл мэндийн төв болон амбулаторит хөтлөгдөх бүртгэлийн маягтуудын хөтлөх заавар**

- 1. Маягтын нэр:** ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДЭВТЭР  
**Маягтын дугаар:** ӨЭ-1.А

**Ойлголт, тодорхойлолт:** Энэхүү дэвтэр нь эх, хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийн байдлыг дэмжих, үнэлэх зориулалттай бүртгэл юм. Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр бол жирэмсэн эмэгтэй болон хүүхдийн эрүүл мэнд, өсөлт ба хөгжлийг бүртгэх үндсэн баримт болно.

**Нөхөх заавар:** Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн улаан хүрээтэй хуудсуудад Эрүүл мэндийн ажилтан, цэнхэр хүрээтэй хуудсуудад Эцэг, эх, асран хамгаалагч тэмдэглэл хөтөлж бөглөнө.

Уг дэвтэр нь жирэмсэн эх болон хүүхдийн эрүүл мэндийн байдал, өсөлт хөгжлийг бүртгэх үндсэн баримт бөгөөд жирэмсэн эх өөрийн эрүүл мэндийн талаарх мэдээллийг уншиж танилцан эхийн заавал мэдэж байх зүйлс, ямар тохиолдолд хэнд хандан зөвлөгөө авах, хүүхдийг нярай үеэс нь эхлэн насны онцлогт тохируулан хэрхэн асрах, яаж хооллох тухай зөвлөмжүүд орсон тул жирэмсэн эх болон хүүхдийг асран хамгаалж буй хэнч гэсэн хэрэглэн мэдээлэл авах боломжтой.

Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эцэг эх, асран халамжлагч нар хамтран “Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг ашиглан хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжил, хөгжлийн үе шат, гэрийн таатай байдал, аюулгүй орчин, гэр бүлийн гишүүдийн сэтгэл зүйн байдлыг үнэлж хянана. Ингэснээр хүүхдийн өвчлөл, биеийн өсөлт хоцрогдол, хоол тэжээлийн цочмог дутлыг илрүүлэх, осол гэмтлээс сэргийлэх ач холбогдолтой бөгөөд эрүүл мэнд, хөгжлийг дэмжих суурь болдог. Мөн тухайн хүүхдийн гэр бүлд шаардлагатай зөвлөмжийг өгч дэмжиж туслах боломжийг бүрдүүлнэ.

Энэхүү зааврыг өрх, сумын эрүүл мэндийн төвүүд өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж, хүүхэд бүрийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийг дэмжих нь Тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад тодорхой хувь нэмэр болох юм.

### **Эрүүл мэндийн байгууллага**

Эрүүл мэндийн байгууллага нь “Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг хэрэглэх сургалтад холбогдох эмч, мэргэжилтнүүдийг заавал хамруулна. Сургалтад хамрагдсан өрх, сум, амаржих газрын эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь бусаддаа “Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг хэрхэн ашиглах талаар зааж өгөх нь чухал бөгөөд дэвтрийг олгохдоо эцэг эх, асран халамжлагч нарт дэвтэр ашиглах, хөтлөх, хадгалах талаар зөв мэдээллийг өгнө.

Эх, хүүхдэд тусламж үзүүлдэг эрүүл мэндийн бүх байгууллагад “Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийн хангалттай нөөцтэй байж эцэг эхчүүдэд тасралтгүй хангах шаардлагатай.

### **“Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг хэзээ олгох бэ?**

- Жирэмсэн эмэгтэй анх удаа хяналтад ороход
- Нэг хүртэлх настай хүүхдэд уг дэвтэр байхгүй бол
- Эцэг эх дэвтрийг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд харьяа өрхийн эрүүл мэндийн байгууллага олгож шаардлагатай мэдээллийг нөхөж бөглөж өгнө.

### **“Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг олгохдоо эмнэлгийн мэргэжилтэн дараах зүйлүүдийг эцэг эх, асран халамжлагч нарт тайлбарлан ойлгуулах үүрэгтэй:**

- Жирэмсний хяналтад үзүүлэх, амаржих газар төрөхөөр очих, хүүхдээ гэрийн эргэлтийн хяналтанд үзүүлэх, дархлаажуултанд хамрагдах болон эрүүл мэндийн байгууллагад очихдоо дэвтрээ заавал авч ирэх,
- Уг дэвтэр нь хүүхдийн төрсөн үеэс эхлэн эрүүл мэндийн байдал, өсөлт хөгжилтийн түүх болон үлддэг тул дэвтрээ цэвэр нямбай хөтөлж хадгалахыг ээж болон гэр бүлийн гишүүдэд сайтар ойлгуулах,

- Дэвтэрээ хаях, гээхээс болгоомжлох талаар анхааруулах,
- “Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийн агуулгын талаар сайтар тайлбарлаж, эхнэр нөхөр хамтдаа уншиж ашиглахын чухлыг ойлгуулах,
- “Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг үнэн зөв яаж хөтлөх талаар эцэг эхчүүдэд сургалт хийх.

### **Эмнэлгийн мэргэжилтэн хүүхдийн эрүүл мэндийн талаарх мэдээллийг хаана тэмдэглэх вэ?**

“Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр” нь 2 хэсэгтэй.

- Эцэг эх, асрамжлагч дэвтэрийн ХӨХ хуудсыг ашиглана. Энэ хуудас бол эцэг эх, асрамжлагчийн хуудас гэдгийг эмнэлгийн мэргэжилтэн маш сайн мэдэх ёстой.
- Энэ хуудсанд 5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, асаргаа, өсөлт хөгжил, хүүхдийн хөгжил, гэр бүлийн сэтгэл зүйн байдал, гэрийн таатай орчин, аюулгүй байдлын талаар эцэг эх өөрсдөө үнэлэн, тухайн хүүхдийн насанд тохирсон гэрийн эргэлтийн өмнөх асуумжийн хуудаст тэмдэглэнэ.

Гэр бүлд эрүүл мэнд, сэтгэл зүйн талаар асуудал гарвал хаана хандах, хаанаас тусламж авах талаар эцэг эх, гэр бүлийн гишүүдийн зайлшгүй мэдвэл зохих мэдээлэл зөвлөгөө зөвлөмж байгаа.

Уг дэвтрийн хөх хуудсанд байгаа эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөөний талаар эцэг эхчүүдэд маш сайн ойлгуулан хэрхэн үнэн зөв хөтлөхийг зааж ойлгосныг шалгана. Эх хүүхдээ дагуулж ЭМБ-д ирэх үед, эрүүл мэндийн ажилтан гэрээр эргэлт хийхдээ дэвтэр дэх тэмдэглэгээг бүрэн, үнэн зөв хөтөлсөн эсэхийг шалгах ба хэрэв ээж нь сайн ойлгоогүй бол яаж тэмдэглэхийг дахин зааж зөвлөнө. Эхний сараас дэвтрээ ашиглаж сурвал цаашид тогтмол тэмдэглэх дадал зуршилтай болно.

Эмнэлгийн мэргэжилтэн эх болон хүүхдийн эрүүл мэндийн талаарх мэдээллийг зөвхөн УЛААН хуудсыг ашиглан тэмдэглэл хөтлөнө. Энэ хуудсанд жирэмсний бүхий л хугацаа, төрөх үе ба төрсний дараах 6 долоо хоног дахь эхийн эрүүл мэндийг эх өөрөө болон эмнэлгийн мэргэжилтэн хянана. Энэ хэсэг нь жирэмсэн эмэгтэй өөрийнхөө болон хэвлий дэх хүүхдийнхээ эрүүл мэндэд хэрхэн анхаарах заавар юм.

**Жирэмсэн үеийн эрүүл мэндийн хяналт:** Эх жирэмсний эхний 3 сард жирэмсэн болсноо мэдмэгц аль болох эрт Өрхийн ЭМТ-д очиж хяналтад орох нь чухал юм. Анхан шатны эмнэлгийн мэргэжилтэн баг, өрх, сумынхаа жирэмсэн эмэгтэйг хяналтад аль болох эрт оруулах талаар идэвхтэй ажиллах хэрэгтэй.

Жирэмсэн эмэгтэй жирэмсний хугацаанд 6-аас доошгүй удаа хяналтад үзүүлсэн байх ёстой. Эрсдэлтэй жирэмсэн болон эрүүл мэндийн асуудалтай эхчүүдийг 8-аас доошгүй удаа үзнэ.

- Үзлэгээр жирэмсэн эхэд жирэмсэн үеийн оношилгоо, зөвлөгөө, ийлдсийн шинжилгээ, ургийн хэвийн бус байдлыг илрүүлэх болон БЗДХ-ын шинжилгээ, эхээс урагт ХДХВ-ын халдвар дамжих эрсдлийн талаар зөвлөгөө өгнө. Энд жирэмсний хяналт, төмрийн бэлдмэл уух, хоол хүнс болон жирэмсний хугацаанд биед илрэх хэвийн болон эмгэг өөрчлөлтүүдийн талаарх мэдээллүүдийг оруулсан. Эдгээр заавар зөвлөгөө нь нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний заавар удирдамжуудыг мөрдлөг болгосон болно.

**Хоол тэжээлийн талаар:** жирэмсэн эмэгтэйчүүдэд ердийн иддэг хоолны давтамжаа нэмэгдүүлэх, хэрвээ хоолны асуудалтай бол дараах зөвлөмжийг өг. Өдөрт бага хэмжээтэй

өөртөө тохирсон хоол сонгож идэх ба унтахын өмнө их идэхгүй байх, шинэ жимс, сүү, цагаан идээ, загас, кальциар баялаг хоол хүнс хэрэглэнэ.

**Жирэмсэн эмэгтэйн ажил ба ажлын байр:** Ажил хийдэг эмэгтэйчүүд амаржихаас 2 сарын өмнө жирэмсний амралтаа авах хэрэгтэй. Амаржихын өмнөх амралт эх, ургийн аюулгүй байдалд маш чухал гэдгийг тайлбарлаж зөвлөх хэрэгтэй. Эмэгтэй хүнд жирэмсний үе, төрөх, төрсний дараах бүхий л үед гэр бүлд дэмжлэг асар чухал байдаг талаар ойлгуулах.

Эмэгтэйг жирэмсний хяналтад үзүүлэхэд нь нөхөртэйгээ ирэхийг зөвлөж хоёуланд нь дэвтрийг хэрхэн ашиглах талаар тайлбарлана.

**Төрсний дараах эрүүл мэнд:** Төрсний дараах эхийн эрүүл мэндийн хяналтийг төрсний дараах гэрийн эргэлтийн төлөвлөгөөний дагуу 24-72 цагийн дотор хянана.

### Тав хүртэлх хүүхдийн эрүүл мэндийн хяналт

**Хүүхдийн хяналт:** Эмнэлгийн мэргэжилтэн хүүхдийг эхийн хэвлийд бүрэлдэх үеэс эхлээд 6 нас хүртэлх өсөлт хөгжил, хоол тэжээл, хүүхдийн хөгжил, эрүүл мэндийн байдлыг хянаж үнэлэн, дэвтэрт тэмдэглэнэ. Эмнэлгийн мэргэжилтэн **эрүүл** хүүхдийг Эрүүл мэндийн сайдын баталсан гэрийн эргэлтийн төлөвлөгөөний дагуу 1 хүртэлх сартай хүүхдийг сард 4 удаа, 2 сартай хүүхдийг сард 2 удаа, 3 сартайгаас 1 нас хүртэл сар тутам, 1-2 настай хүүхдийг улиралд нэг удаа гэрээр эргэнэ.

**Санамж:** Гэрийн эргэлтийг заавал гэрт очиж хийнэ.

Гэрийн эргэлт бол эрүүл хүүхдийн хяналт гэдгийг сана. Эмнэлгийн мэргэжилтэн гэрийн эргэлтээр хүүхдийн биеийн байдал, хоол тэжээл, өсөлт хөгжил, хүүхдийн хөгжил, гэрийн таатай орчин, аюулгүй байдал, эцэг эх, ах, эгчийн сэтгэл санааны байдал, шинэ хүүхэддээ хэрхэн дасах зэрэг олон зүйлийг хянаж үнэлэн тохирсон зөвлөгөө, мэдээлэл өгөх юм. Эмнэлгийн мэргэжилтэн гэрийн эргэлт болон эрүүл мэндийн байгууллагад хүүхдийг ирэх үед нь эрүүл мэндийн байдлыг тухайн насанд тохирсон гэрийн эргэлтийн үнэлгээний хуудсаар хянаж, эрүүл мэндийн талаар “5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-т тэмдэглэнэ. Хэрвээ хүүхэд гэрийн эргэлтийн үед өвчтэй байвал ХӨЦМ-ийн дагуу үнэлж эмчилгээг шийднэ.

**Анхаар:** ХӨЦМ-ийн дагуу үнэлэх боломжгүй бол Өвчний карт нээн тэмдэглэл хөтлөн эмчилгээний асуудлыг шийд. “5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр” бол эрүүл хүүхдийн хяналтын дэвтэр **өвчний карт биш гэдгийг сана.**

### Нэг хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн хяналт

**Нярайн эрүүл мэндийн хяналт:** Амаржих газраас гэртээ гарсаны дараах 24-72 цагийн дотор гэрийн эргэлт хийж, нярайд эрүүл мэндийн үнэлгээ хийнэ. Энэ бол гэрийн анхны эргэлт юм. Анхны гэрийн эргэлтийг эмч, сувилагч хамт хийнэ. Анхны эргэлтээр эх, нярайн эрүүл мэндийг хамт хянана. Эргэлтээр төрсний дараах 24-72 цагийн гэрийн эргэлтийн өмнөх асуумж, эрүүл мэндийн ажилтанд зориулсан эргэлтийн үнэлгээний дагуу нярайн эрүүл мэндийн байдлыг үнэлж, эцэг эхэд өгөх зөвлөмжийг ашиглан зөвлөгөө өгнө.

**Эцэг эхэд зориулсан гэрийн эргэлтийн өмнөх асуумжийн хуудас хөтлөх заавар**

Гэрийн эргэлтийн өмнөх асуумжийн хуудас 3 хэсэгтэй.

1. Та хүүхдийнхээ эрүүл мэндийн талаар мэдэхийг хүсч байгаа мэдээллээ эмнэлгийн мэргэжилтэн гэрийн эргэлтээр ирэх үед эцэг эхийн зүгээс асуух асуулт болон зөвлөгөө авах зүйлээ тэмдэглэх юм. Үүнд:
  - Эхийн сэтгэл санааны байдал, хүүхэддээ дасах, хооллох, аюулгүй байдал, гэр бүлийн талаар асуух асуултын өмнөх  энэ нүдэнд  тэмдгээр тэмдэглэнэ.
2. Таны хүүхдийн тухай асуумжийн тийм, үгүй, мэдэхгүй гэсэн хариултын өмнөх  энэ нүдэнд  тэмдгээр тэмдэглэнэ.
3. Хүүхдийн хөгжлийн тухай асуумжийн тийм үгүй гэсэн хариултын өмнөх  энэ нүдэнд  тэмдгээр тэмдэглэнэ.

### **Эрүүл мэндийн ажилтанд зориулсан гэрийн эргэлтийн үнэлгээний хуудас хөтлөх заавар**

1. Паспортын хэсгийг эцэг эхээс асууж үнэлнэ. Эцэг эх хүүхдийн нэр, харилцах хэлийг сонгож тэмдэглэнэ. Гэрийн эргэлтээр очсон он сар өдрийг тэмдэглэнэ.

Өсөлтийг хэмжиж тэмдэглэнэ: Хүүхдийн биеийн жинг хэмжин, килограммаар бичнэ. Жишээ нь: хүүхдийн жин 3 кг 700 гр байвал 3.7 кг гэж бичнэ.

Хүүхдийн биеийн уртыг хэмжин тэмдэглэнэ: Уртын хэмжээг сантиметрээр бичнэ. Жишээ нь: хүүхдийн өндөр 1 метр 12 см байвал 112 см гэж бичнэ.

Хүүхдийн жин, уртын харьцааг тодорхойлно: Биеийн жинг урт/өндөрт нь харьцуулсан харьцааг хэлнэ. Энэ үзүүлэлтээр туранхай, илүүдэл жин, таргалалтыг илрүүлэх ач холбогдолтой. Мөн хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутлыг тодорхойлдог.

2. Төрөх үеийн түүхийг эцэг эхээс асуултын дагуу асууж тэмдэглэнэ. Тийм буюу шаардлагатай гэсэн хариултын өмнөх  энэ нүдэнд  тэмдгээр тэмдэглэнэ. Үгүй бол онгорхой байна.
3. Нийгэм гэр бүлийн байдал: Үүнийг үнэлэхдээ гэрийн эргэлтийн өмнөх асуумжийг заавал харна. Гэр бүлийн гишүүд шинэ хүүхэддээ дасаж байгаа болон ажил сургуульдаа орох талаар эцэг эхтэй ярилцаж тэмдэглэнэ. Эцэг эхэд сэтгэл гутралын шинж тэмдэг илэрсэн бол  энэ нүдэнд  тэмдгээр тэмдэглэнэ.
4. Хүүхдийн хоол тэжээл ба ерөнхий байдал тийм, хэвийн хамрагдсан гэсэн хариултын өмнөх  энэ нүдэнд  тэмдгээр тэмдэглэнэ. Үгүй бол онгорхой байна.
5. Бодит үзлэг: Эмнэлгийн мэргэжилтэн бодит үзлэгийг ЗААВАЛ хийнэ. Үзлэг хийхдээ хүүхдийн эх болон гэр бүлийн гишүүдийг хамт байлцуулна. Хүүхэд эрүүл бол “Эрүүл” гэсэн хариултын өмнөх  энэ нүдэнд  тэмдгээр тэмдэглэнэ. Өвчтэй бол өөрчлөлт илэрсэн хэсэгт тэмдэглэнэ.
6. Үнэлгээний хэсэгт хүүхэд эрүүл бол “Эрүүл” гэсэн хариултын өмнөх  энэ нүдэнд  тэмдгээр тэмдэглэнэ. Өвчтэй бол ХӨЦМ-ийн дагуу үнэлэн ангилал, бусад өвчин илэрвэл тухайн өвчний онош, өсөлт хөгжлийн хоцрогдолтой бол тураал, туранхай, өсөлтийн хоцрогдол болон хоол тэжээлийн дутагдалтай эсэхийг тэмдэглэнэ.
7. Зөвлөгөө мэдээлэл хэсэгт гэрийн эргэлтээр эмнэлгийн мэргэжилтэн өгсөн зөвлөгөөгөө мэдээллээ  нүдэнд  тэмдгээр тэмдэглэнэ. Зөвлөгөө өгөхдөө 5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр дээрх эцэг эхэд өгөх хүүхдийн насанд тохирох зөвлөмжийн талаар ярилцах, тараах материал өгч болно. Нярайг хөхүүлэх, хуурайлах, угаах, гэрийн аюулгүй таатай орчин, хүүхдэд илрэх аюултай шинжүүдийн талаар зөвлөгөө өгнө. Энэ үед хүүхдийг эхийн сүүгээр дагнан хооллохын чухлыг гэр бүлд ойлгуулж, эхэд шим тэжээллэг хоол идүүлж давтамжийг нэмэгдүүлэх, тайван байлгах талаар зөвлөнө. Гэрийн эргэлтийн өмнөх хуудсыг хэрхэн бөглөх талаар зөвлө.

8. Цаашид авах арга хэмжээний хэсэгт тухайн гэрийн эргэлтийн үнэлгээний байдалд дүгнэлт хийн тухайн үед авсан болон цаашид авах арга хэмжээний талаар тэмдэглэнэ.
9. Гэрийн эргэлтээр очсон эмч, сувилагч нэрээ тод бичиж гарын үсгээ зурна. Мөн эцэг эхийн аль нэгний гарын үсгийг авч баталгаажуулна.
10. Мөн хүүхдээ иргэний бүртгэлд бүртгүүлж, төрсний гэрчилгээ авахыг гэр бүлд нь сануулаарай.

### Нэг наснаас тав хүртэлх насны хүүхдийн хяналт

Хүүхдийг нэг нас хүртэл гэрээр болон ӨЭМТ-д ирүүлэн сар бүр үзлэг хийж, дараах хүснэгтэд тэмдэглэнэ.

## ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ

(Эрүүл мэндийн үзлэгийг

20 ..... оны ..... сарын ..... нд хүүхэд ..... сар ..... өдөртэй байхад хийв)

Толгойн тойрог: ..... см	Цус багадалт +/-	Хооллолт: <input type="checkbox"/> Сайн <input type="checkbox"/> Хооллолтын бэрхшээлтэй																				
		Хажуугийн зурагт цоорсон эсвэл хэвийн бус шүдийг “X” гэж тэмдэглэнэ үү.																				
<table border="1"> <tr> <td>E</td><td>D</td><td>C</td><td>B</td><td>A</td><td>A</td><td>B</td><td>C</td><td>D</td><td>E</td> </tr> <tr> <td>E</td><td>D</td><td>C</td><td>B</td><td>A</td><td>A</td><td>B</td><td>C</td><td>D</td><td>E</td> </tr> </table>		E	D	C	B	A	A	B	C	D	E	E	D	C	B	A	A	B	C	D	E	Шүд: <input type="checkbox"/> эрүүл / <input type="checkbox"/> эмчилгээ шаардлагатай (шүдний тоо ..... )
E	D	C	B	A	A	B	C	D	E													
E	D	C	B	A	A	B	C	D	E													
		Шүдний ариун цэврийн байдал: <input type="checkbox"/> Сайн <input type="checkbox"/> Дунд <input type="checkbox"/> Муу																				
		Буйл/ завьж: <input type="checkbox"/> Хэвийн <input type="checkbox"/> хэвийн бус																				
Ерөнхий эрүүл мэндийн байдал: <input type="checkbox"/> Эрүүл / <input type="checkbox"/> тогтмол хяналт шаардлагатай																						
Вакцин: ..... он ..... сар ..... өдөр																						
Эрүүл мэндийн байгууллага эсвэл эмчийн нэр:																						

### Заавар:

1. Эмнэлгийн мэргэжилтний хүүхдэд эрүүл мэндийн үзлэг хийсэн он сар өдрийг тэмдэглэнэ.
2. Толгойн тойргийг туузан метрээр хэмжиж см-ийг тэмдэглэнэ.
3. Цус багадалттай бол (+) цус багадалтгүй бол (-) гэж тэмдэглэнэ.
4. Хооллолтын бэрхшээлтэй бол  нүдэнд (√) зөвлөх тэмдгээр тэмдэглэнэ.
5. Шүдний эрүүл мэндийг үнэлнэ. Үүнд:
  - Цооролттой шүд бол 

E	X
---	---

 “X” гэж тэмдэглэнэ.
  - Шүдний эрүүл болон эмчлэх шаардлагатай шүдний тоог бичнэ.
  - Шүдний ариун цэврийг Сайн, Дунд, Муу үнэлгээн дээр  нүдэнд (√) зөвлөх тэмдгээр тэмдэглэнэ.
  - Буйл, завьжийг хэвийн, хэвийн бус үнэлгээгээр  нүдэнд (√) зөвлөх тэмдгээр тэмдэглэнэ.

- Ерөнхий биеийн байдал эрүүл бол □ нүдэнд (√) зөвлөх тэмдгээр тэмдэглэнэ.
- Вакцин хийсэн өдрийн он сар өдрийг тэмдэглэнэ.
- Үзлэг хийсэн эмч нэрээ гаргацтай тодорхой бичнэ.

### Хүүхдийн өсөлт ба хоол тэжээлийн хөгжлөрт хамрагдсан талаар тэмдэглэл

Одоогийн нас (сараар)	Өсөлтийн үнэлгээнд хамрагдсан хугацаа (өдөр/сар/он)	Хэмжилт (Тоог бичээд дараа нь өсөлтийн хүснэгтүүд дээр цэгээр тэмдэглэнэ)					Аминдэм, ОН бичил тэжээлийн хангалт			Хөгжлийн үнэлгээ (+, -)	Өвчлөл (А, С, А1, С1, Б)	Хүүхэд хамгаалал (+, -)	Үнэлгээнд ямар хэлбэрээр хамрагдсан, ажиглалт	
		Жин (кг)	Урт, өндөр (см)	Бугалганы тойрог	Өсөлтийн үнэлгээ	2 хөлийн хаван (+, -)	Д аминдэм (+, -)	А аминдэм (+, -)	ОНБТ					
14 сар														
16 сар														
18 сар														

Хүснэгтэд тэмдэглэгээ хийхдээ эцэг эх, асран халамжлагчийг аль болох оролцуулах нь чухал.

1. Хоол тэжээл, өсөлт хөгжил, хөгжлийн үнэлгээ хийлгүүлж буй хүүхдийн одоогийн нас сараар.
2. Үзлэг хийсэн он сар эрүүл мэндийн ажилтан хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжил, хоол тэжээл, хөгжлийг үнэлж хянахаар гэрээр нь очсон эсвэл хүүхэд эцэг эхийн хамт ЭМТ-д ирсэн он сар өдөр.
3. Хэмжилт:
  - Өсөлтийн хяналтад хамрагдаж буй хүүхдийн биеийн жинг хэмжиж, жинг килограммаар бичнэ. Жишээ нь: хүүхдийн жин 4 кг 700 гр байвал 4.7 кг гэж бичнэ.
  - Өсөлтийн хяналтад хамрагдаж буй хүүхдийн биеийн урт эсвэл өндрийг хэмжиж хэмжээг сантиметрээр бичнэ. Жишээ нь: хүүхдийн өндөр 1 метр 12 см байвал 112 см гэж бичнэ.
  - Хүүхдийн хоёр хөлд хаван байгаа эсэхийг тодруулж бичнэ. Бүртгэлийн цонхонд хаван байгаа бол (+), байхгүй бол (-) гэж тэмдэглэнэ.
4. Амин дэм бичил бодисын хангалт:
  - А аминдэм уусан эсэх: Тухайн сард А аминдэм уусан 6-59 сартай хүүхдийн мэдээлэл (100,000-200,000 ОУН А аминдэмийг жил бүрийн 5 болон 11 дүгээр саруудад 6-59 сартай хүүхдүүдэд кампаничлан уулгадаг. Энэ нүдэнд А аминдэм уусан бол (+), уугаагүй бол (-) гэж тэмдэглэнэ.
  - Д аминдэм уусан эсэх: Тухайн сард Д аминдэм уусан 0-36 сартай хүүхдийн мэдээлэл (50000 ОУН Д2 аминдэмийг урьдчилан сэргийлэх тунгаар сар бүр). Өндөр тунт Д2 аминдэм хүрэлцээгүй тохиолдолд Д3 аминдэмийг эмчийн зааврын

дагуу дуслаар уух ба энэ тохиолдлыг мөн Д аминдэмийг уусан хэмээн бүртгэнэ. Энэ нүдэнд Д аминдэм уусан бол (+), уугаагүй бол (-) гэж тэмдэглэнэ.

- Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл (ОНБТ) авсан эсэх: Бүртгэлийн цонхонд ОНБТ уусан бол (+), уугаагүй бол (-) тэмдэг бичнэ.

5. Хооллолтын байдал (Д,Т,Х,Н):

0-6 сартай хүүхдийн хувьд Д, Т, Х, Н үсгийн аль нэг тэмдэглэгдэнэ. Үүнд:

**Д** – Эхийн сүүгээр дагнан хооллож (Эхийн хөхний сүүнээс өөр бусад шингэн, ус, цай, шүүс зэргийг огт авахгүй байхыг хэлнэ) байгаа,

**Т** – Эхийн сүү орлуулагчаар дагнан хооллож байгаа,

**Х**- Эхийн сүүний зэрэгцээ эхийн сүү орлуулагчаар хооллож байгаа буюу холимог хооллолт,

**Н** - 6 сар хүрэхээс өмнө нэмэгдэл хоолонд орсон

6. Хөгжлийн үнэлгээ:

5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хөх хуудасны “МИНИЙ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ ..... САРТАЙДАА” хэсэг дэх хүүхдийн хөгжлийн үзүүлэлтүүдийг тийм/үгүй гэсэн тэмдэглэгээг дугуйлж зурах талаар гэр бүлийн гишүүд эцэг эхэд зааж өгч ЭМТ-д үзүүлэхээр ирэхдээ тэмдэглэж ирэхийг анхааруулна. Асуумжийн дагуу бөглөж, (+) гэж тэмдэглэх ба бөглөөгүй бол (-) гэж тэмдэглэнэ. Тухайн насны хөгжлийн үзүүлэлтүүдийг хийж чадаж байгаа эсэхийг шалгаж, аль нэгийг нь эсвэл хэсэг бүлгийг нь хийж чадахгүй (Хөгжлийн хоцрогдолтой) хүүхдийг дэвтэрт тэмдэглэж дараагийн сар хүртэл хянана. Хүүхдийн хөгжлийн энэхүү үзүүлэлтүүд нь тус дэвтрийн маш чухал хэсэг бөгөөд хүүхдийн танин мэдэхүй, оюуны хөгжлийг зөв үнэлж, дүгнэснээр хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт таньж, хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлэх чухал хэрэгсэл болно.

7. Өвчлөлийн байдал:

Тухайн сард ямар нэг өвчнөөр өвчилсөн бол А, А1, С, С1, Б үсгийн аль нэгийг тэмдэглэгдэнэ.

**А** Тухайн сард амьсгалын цочмог халдвараар өвчилсөн (Тухайн сард хүүхэд хэдэн удаа өвчилснийг тооцохгүй).

**А1** Тухайн сард амьсгалын цочмог халдвараар өвчилж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан хүүхэд (Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэдэгт өвчний улмаас эмнэлэг, эмчид хандах, эм бичүүлж эмийн сангаас авч хэрэглэснийг хэлнэ. Тухайн сард хүүхэд хэдэн удаа өвчилснийг тооцохгүй).

**С** Тухайн сард суулгалтаар өвчилсөн (тухайн сард хүүхэд хэдэн удаа өвдсөнийг тооцохгүй).

**С1** Тухайн сард суулгалтаар өвчилж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан хүүхэд (Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ гэдэгт суулгалтын улмаас эмнэлэг, эмчид хандах, эм бичүүлж эмийн сангаас авч хэрэглэснийг хэлнэ. (Тухайн сард хүүхэд хэдэн удаа өвдсөнийг тооцохгүй).

**Б** Тухайн сард хүүхдийн эрүүл мэнд, өсөлт, бойжилтод ороход нөлөөлөхүйц өвчнөөр өвчилсөн бол Б гэж тэмдэглэнэ (цочмог халдварт өвчин орно).

8. Хүүхэд хамгаалал:

- Хүүхдийг үзэх, жинлэх явцад хувцсыг нь тайлахдаа хүүхдийн биед илэрч буй ямар нэг гэмтлийн шинж байвал гэмтлийн зэргийг харгалзахгүйгээр (+) гэж тэмдэглэнэ. Гэмтэлгүй бол (-) гэж тэмдэглэнэ.
- 5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр дэх эцэг, эхэд зориулсан асаргаа сувилгааны талаарх зөвлөмжийг эцэг эхээс асууж, лавлан, ойлгоогүй зүйлийг дахин хэлж тайлбарлана.
- Эцэг эх, асран халамжлагчаас хүүхдээ өсгөж бойжуулахад ямар бэрхшээл байгаа болон хүүхдийнхээ талаар сэтгэл зовнисон асуудал байгаа эсэхийг асууж, зөвлөлдөх нь маш чухал.
- Гэр бүлийн гишүүд “5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг тогтмол ашиглаж, хүүхдийнхээ өсөлт хөгжил, эрүүл мэндийг хянаж байх нь хүүхдийн эсэн мэнд өсөж бойжих үндэс юм.
- Дээрх хүснэгтийг бөглөхдөө хүүхдийнхээ дэргэд байж тэмдэглэх ба жин урт өндрийг тэмдэглэхийн өмнө уг дэвтрийн арын хуудас дахь өсөлтийн хүснэгтэд цэглэн тэмдэглэгээ хийнэ.

### **Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч хүүхдийн эрүүл мэндийн дүгнэлтийг дараах насанд хийнэ**

Нярай хүүхдийг төрсний дараах 7 хоногт амаржих газрын нярайн эмч болон өрхийн эмч “Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-т байгаа нярайн эрүүл мэндийн хуудас бөглөн, эрүүл мэндийн байдалд дүгнэлт хийж, 1 хувийг амаржих газрын нярайн түүхийн хамт хадгална.

Хүүхдийг нэг нас хүрэхэд өрхийн эмч хүүхдийн эрүүл мэндийн байдалд дүгнэлт гарган “Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-т 2 хувь дүгнэлт бичиж, нэг хувийг ЭМТ дээрээ хадгална.

Хүүхдийг 18 сартай, 36 сартайд иж бүрэн үзлэгт хамруулна. Иж бүрэн үзлэгийг өрх, сумын ЭМТ нэгдсэн журмаар төлөвлөгөө гарган зохион байгуулна.

Таван нас хүрэхэд өрхийн эмч хүүхдийн эрүүл мэндийн байдалд дахин дүгнэлт гаргана.

### **Дархлаажуулалт**

Өрх сумын эмч, ээлжит үзлэгийн үед дархлаажуулалтад хугацаандаа хамрагдсан эсэхийг шалгаж “Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-т тэмдэглэх ба хамрагдаагүй бол хэрхэн дархлаажуулалтад орохыг зөвлөх болон дархлаажуулалтын ач холбогдлыг эцэг эхэд тайлбарлаж өгнө.

## ЗААВАЛ ХИЙХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТОВЛОЛ

Товлол	Сэргийлэх арга	Хийх вакцин (✓)	Эмчийн үзлэгийн тэмдэглэл	Хийсэн огноо, цаг, минут	Вакцин аторын нэр
Төрсний дараа 24 цагийн дотор	Сүрьеэ	<input type="checkbox"/>			
	В вируст гепатит 0 тун	<input type="checkbox"/>			
	Халдварт саа 0 тун	<input type="checkbox"/>			
2 сартайд	Халдварт саа I тун	<input type="checkbox"/>			
	Таван (Сахуу, хөхүүл ханиад, татран, В вируст гепатит, хемофилюс инфлюенза В) вакцин I тун	<input type="checkbox"/>			
	Пневмококкийн эсрэг вакцин I тун	<input type="checkbox"/>			
3 сартайд	Халдварт саа II тун	<input type="checkbox"/>			
	Таван (Сахуу, хөхүүл ханиад, татран, В вируст гепатит, хемофилюс инфлюенза В) вакцин II тун	<input type="checkbox"/>			
4 сартайд	Халдварт саа III тун	<input type="checkbox"/>			
	Таван (Сахуу, хөхүүл ханиад, татран, В вируст гепатит, хемофилюс инфлюенза В) вакцин III тун	<input type="checkbox"/>			
	Пневмококкийн эсрэг вакцин II тун	<input type="checkbox"/>			
5 сартайд	Халдварт саа IV тун	<input type="checkbox"/>			
9 сартайд	Улаанбурхан, гахай хавдар, улаанууд I тун	<input type="checkbox"/>			
	Пневмококкийн эсрэг вакцин III тун	<input type="checkbox"/>			
1нас 2 сартайд	А вируст гепатит I тун	<input type="checkbox"/>			
2 настайд	Улаанбурхан, гахай хавдар, улаанууд II тун	<input type="checkbox"/>			
	А вируст гепатит II тун	<input type="checkbox"/>			
7 настайд	Сахуу, татран I тун	<input type="checkbox"/>			
15 настайд	Сахуу, татран II тун	<input type="checkbox"/>			
Бусад вакцин (Бичих)					


Дархлаажуулалтын товлолын дагуу эрүүл мэндийн үзлэг хийж, тэмдэглэхдээ хүүхдэд эрүүл мэндийн үзлэг хийсэн эмч нэрээ гаргацтай бичиж, үзлэг хийсэн он сар өдрийг бичнэ. Дархлаажуулалтын товлолын дагуу хүүхдийн товлосон насанд заавал хийх вакцины нэрний ард байгаа □ нүдэнд (√) зөвлөх тэмдгээр тэмдэглэн, вакцин хийсэн огноо цаг минутыг заавал бичнэ. Вакцинатор нэрээ гаргацтай бичнэ.

### Хүүхдэд хэмжилт хийх

Хүүхэд бүрийн өсөлт, хөгжил тухайн хүүхдийн биеийн онцлогоос хамаарч янз бүр байдаг. Хүүхдийн биеийн байдал, өсөлт, хөгжлийг төрсний дараах эхний 2 сарын дотор 6 удаа, түүнээс хойш сар бүр гэрийн идэвхтэй эргэлт, амбулаторийн үзлэг, дархлаажуулалтын үед тогтмол үнэлж, хянаснаар хүүхдийн биеийн өсөлтийн хоцрогдол, хоол тэжээлийн цочмог дутлыг илрүүлэх ач холбогдолтой.

0-5 хүртэлх насны хүүхдийн өсөлт, хөгжлийг:

- Урт/өндөр–нас
- Жин–нас
- Жин - урт/өндөр
- БЖИ (биеийн жингийн индекс) – нас гэсэн дөрвөн үзүүлэлтээр үнэлнэ. Урт/өндрийг см-аар, жинг кг-аар илэрхийлдэг.



**Зураг. Хүүхдийн өсөлтийг үнэлэх хүснэгт**

Хүүхдийн биеийн урт/өндөр-насны үзүүлэлт нь: 2 хүртэлх насны хүүхдэд уртыг, 2-оос дээш насны хүүхдэд өндрийг хэмжиж, насанд нь харьцуулсан харьцааг хэлнэ. Энэ үзүүлэлтээр хүүхдийн "өсөлт хоцролт", намханыг тодорхойлно. Хүүхэд хэт өндөр байх нь ховор тохиолдох бөгөөд энэ нь дотоод шүүрлийн эмгэг байж болзошгүйг илтгэнэ.

Хүүхдийн биеийн жин-насны үзүүлэлт нь хүүхдийн биеийн жинг насанд нь харьцуулсан харьцааг хэлнэ. Энэ үзүүлэлтээр "тураал"-ыг илрүүлдэг. Энэ үзүүлэлтээр илүүдэл жин, таргалалтыг үнэлэхгүй.


Хүүхдийн жин-урт/өндрийн үзүүлэлт нь биеийн жинг урт/өндөрт нь харьцуулсан харьцааг хэлнэ. Энэ үзүүлэлтээр "туранхай"-г илрүүлдэг. Энэ үзүүлэлтээр илүүдэл жин, таргалалтыг илрүүлэх ач холбогдолтой. Энэ үзүүлэлт дээр хүүхдийн хоёр хөлийн хаванг заавал шалгаж тэмдэглэнэ. Энэ нь хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутлыг тодорхойлдог.

"Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр" дэх өсөлтийн хүснэгтэнд хүүхдийн өсөлт хөгжлийг тэмдэглэдэг. Хүүхдийн өсөлтийг үнэлэх хүснэгт нь 2 өөр өнгөтэй. Цэнхэр

хүснэгтийг эрэгтэй, ягаан хүснэгтийг эмэгтэй хүүхдийн өсөлтийг үнэлэхэд ашиглана. Өсөлтийн хүснэгт дэх ногоон шугам болох “**голч шугам**” өсөлтийн дунджийг заана. Өсөлтийн хүснэгт дэх ногоон, шар, улаан, хар шугамуудыг z онооны шугам гэж нэрлэдэг. Өсөлтийг тэмдэглэсэн цэгэн тэмдэглэл нь голч ногоон шугам руу ойртох тусам сайн үзүүлэлт, алслагдах тусам өсөлтийн асуудалтайг илэрхийлнэ.

Өсөлтийн хоёр буюу түүнээс олон цэгэн тэмдэглэлийг хооронд нь зураасаар холбосон холболтыг **өсөлтийн муруй** гэнэ. Энэ муруйгаар хүүхдийн өсөлтийн хандлагыг тодорхойлно.

**Эрэгтэй хүүхдийн Жин насны хүснэгт**  
Төрснөөс хойш 24 сар хүртэл (Z-оноогоор)



**Зураг. Жин-насны хүснэгтэд өсөлтийн муруйг тэмдэглэсэн байдал**

**Хүснэгт. Өсөлт, хөгжил, хоол тэжээлийн цочмогдутлыг үнэлэх үзүүлэлт**

Z оноо (CX)	Өсөлтийн үзүүлэлт		
	Урт/өндөр-нас	Жин-нас	Жин-урт/өндөр
3 – аас дээш	Хэт өндөр	-	Тарган
2-оос дээш	Өндөр	-	Илүүдэл жинтэй
1 – ээс дээш	Эрсдэл	Эрсдэл	Эрсдэл
0 (голч)	Хэвийн	Хэвийн	Хэвийн
-1-ээс доош	Эрсдэл	Эрсдэл	Эрсдэл
-2-оос доош	Өсөлт хоцрогдол/намхан	Тураал	Туранхай
-3-аас доош	Өсөлтийн хүнд хоцрогдол	Хүнд тураал	Хүнд тураал

**Өсөлтийн муруйг ашиглан эцэг эх, асран халамжлагчид зөвлөгөө өгөх**

Хүүхдийн өсөлт, хөгжлийн хэмжилт бүрийг 5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэн тухайн хүүхдийн өсөлтийн байдлыг эцэг, эхчүүдэд мэдээлж, эрсдэлтэй буюу өөрчлөлттэй тохиолдол бүрийг эцэг эх, асран халамжлагчтай ярилцаж, шалтгааныг тодорхойлон тохирох зөвлөмж өгнө.

**Хадгалах хугацаа: байнгийн**

**2. Маягтын нэр:** 6-18 НАСТАЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДЭВТЭР  
**Маягтын дугаар:** ӨЭ-1.Б

**Ойлголт, тодорхойлолт:** Энэхүү маягт нь сургуулийн насны буюу 6 наснаас 17 настай хүүхдийн эрүүл мэндийг хянаж, улирал тутамд тодорхой эмчийн үзлэгт хамруулах зорилготой болно. Хүн амын эрүүл мэндийн зайлшгүй тулгамдсан асуудлын нэг болох төрөлхийн болон олдмол хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж, хөгжлийн дэмжлэг, сэргээн засах, оролцоо, боловсролын үйлчилгээнд аль болох эрт хамруулах нь нэн чухал юм.

Манай улсад хүүхэд бүрийн жин өндрийг хянах тогтолцоотой ч хөгжлийг хянах тогтолцоо байхгүй байна. Хүүхдийн хөгжлийг тандаж хянаж, хөгжлийн хоцрогдлын эрсдэлтэй хүүхдийг олж илрүүлэх үйл явц нь анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага өрх, сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай шууд холбогдох ёстой.

Мөн сургуулийн хүүхдүүдийн эрүүл мэндийг хянах, дэмжих зорилгоор уг маягтыг Эрүүл мэндийн байгууллагын их эмчээс гадна “Сургуулийн эмч” хөтлөхөөр оруулж байна.

**Нөхөх заавар:** Сургуулийн эмч болон өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч нь Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.14.1-т заасны дагуу уг дэвтэрт хүүхдийн биеийн жингийн индексийг жилд 2 удаа хэмжиж, тооцоолно.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 255 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл шүд - Эрүүл хүүхэд" хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах, эрчимжүүлэх зорилгоор хүүхдийн Амны хөндийн эрүүл мэндийн асуудлуудыг багтаасан асуумжийг цогцоор оруулсан. Энэхүү асуумж нь мэргэжлийн шүдний эмч бус өрх, сумын эмч, сургуулийн эмч зааврын дагуу хараад тэмдэглэх боломжтойгоор оруулсан тус хүүхдийн шүдийг харж, майгтын дагуу тэмдэглэн, эмчилгээ, үйлчилгээ шаардлагатай хүүхдийг шүдний эмч, нарийн мэргэжлийн эмчийн хяналтад шуурхай явуулна.

Сургуулийн насны хүүхдийн эрүүл мэндийн хяналт, дэмжлэг нь боловсролын байгууллага дээр тулгуурлан сургуулийн эмчийн оролцоо, үүрэгтэйгээр хийвэл зохистой бөгөөд ЭМБ-ууд харьяа боловсролын байгууллагуудтай хамтран ажиллаж, зөвшилцөн сургуулийн эмч нар хөтөлж мөрдүүлэх шаардлагатай.

**Маягтыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн:** Өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч, сургуулийн эмч

**Хадгалах хугацаа:** Байнга

**3. Маягтын нэр:** ӨРХИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН БҮРТГЭЛ  
**Маягтын дугаар:** ӨЭ-2

**Ойлголт, тодорхойлолт:** Тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний өрх тус бүрээр эрүүл мэндийн бүлэг, амьдралын орчин, өрхийн гишүүн тус бүрээр эрүүл мэндийн зарим мэдээллийг бүртгэх, хянах зориулалттай бүртгэл юм.

Өрхийн эрүүл мэндийн бүлгийг дараах байдлаар тодорхойлно.

**"Эрүүл өрх"**- Эрүүл мэндийн III-V бүлэгт хамрагдах архаг өвчтэй хүн байхгүй бөгөөд жилд өрхийн нэг гишүүн өвчилж үзүүлсэн тоо нэгээс илүүгүй байна.

**"Эрүүл мэндийн бага өртөмтгий өрх"**-Гэр бүлийнхний дотор архаг өвчтэй хүн 1-с илүүгүй бөгөөд жилд өрхийн нэг гишүүн хурц өвчнөөр 3-аас олон өвдсөн байна.

**"Эрүүл мэндийн өртөмтгий өрх"** - Ам бүлийн дотор архаг өвчтэй 2 ба түүнээс олон, жилд өрхийн нэг гишүүн хурц өвчнөөр өвчилсэн тоо 3-аас олон байна.

Хүн амын эрүүл мэндийн бүлгийг дараах байдлаар тодорхойлно.

**I бүлэг**-“Цоо эрүүл”- Эмнэлгийн үзлэг шинжилгээнд болон сэтгэцийн ямар нэг өөрчлөлтгүй хүнийг хэлнэ.

**II бүлэг**- “Эрүүл” - Энэ бүлэгт эмчилгээ шаардлагагүй төрөлхийн ямар нэг согог, урьд нь ямар нэг өвчний үлдэцтэй, эсвэл өвчний эхлэл, нууц үеийн зарим илрэлтэй боловч ажлын чадвар хязгаарлагдаагүй хөдөлмөрийн чадвартай хүмүүс орно.

**III бүлэг** - Ээнэгшил бүхий архаг өвчтэй хүмүүс Архаг өвчтэй боловч тухайн эрхтэн системийн үйл ажиллагаа алдагдаагүй ажил хөдөлмөрөө хийж байгаа хүмүүс

**IV бүлэг** - Хагас ээнэгшил бүхий архаг өвчтэй хүмүүс. Архаг өвчнөөр удаан өвчилж, эрхтэн системд өөрчлөлт орсон (субкомпенсацийн байдал) өвчин гэмтлийн улмаас эрхтэн системийн үйл ажиллагаа буурч хөдөлмөрийн чадвар үе үе алддаг, хөдөлмөрийн чадвараа 50%-иас дээш алдаж, тэтгэвэр тэтгэмжинд хамрагдсан хүмүүс,

**V бүлэг** - Ээнэгшилээ алдсан архаг өвчтэй хүмүүс Голдуу хэвтрийн дэглэм баримталдаг, декомпенсацийн байдалтай архаг хүнд өвчтэй, хөдөлмөрийн чадвараа 50%-иас дээш алдаж, тэтгэвэр тэтгэмжинд хамрагдсан хүмүүс орно.

**Нөхөх заавар:** Уг маягыг үндэслэн ЭМТ101.1 тайлан гарна. Өрхийн хүн амын эрүүл мэндийн бүртгэлийг H-info V3.0 программд оруулж тогтмол хөдөлгөөн хийж байх хэрэгтэй.

Өрхийн усан хангамж, халаалт болон бие засах газар /жорлон/, боловсролыг кодчлох зааврын дагуу бичих бөгөөд кодлох заавар ороогүй зарим мэдээллийг дараах байдлаар тэмдэглэнэ.:  
Үүнд:

- **Усан хангамж:** төвлөрсөн-1, худаг, зөөврийн-2, гол булаг шанд-3, задгай-4
- **Халаалт:** төвлөрсөн-1, ердийн-2
- **Жорлон:** төвлөрсөн-1, стандартын нүхэн-2, стандартын нүхэн бус-3, задгай-4
- **Хорт зуршил:** А-архи, Т-тамхи, хоёуланг нь хэрэглэдэг бол АТ гэж бичнэ.
- **Жирэмслэлтээс сэргийлэх эм хэрэгслэл:** Үүнд: Ерөндөг-1, эм-2, тариа-3, суулгац-4, бэлгэвч-5, стерилизаци-6. Хэрэв 2 аргыг зэрэг хэрэглэдэг бол аль илүү хэрэглэж буй арга хэрэгслэлийг тавина.

**Маягыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн:** Өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч

**Хадгалах хугацаа:** Байнга

**Хяналт, баталгаажилт:** Тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч дээрх маягтын хөтлөлт, үнэн зөв байдалд сар туамд хяналт тавьж баталгаажуулна.

#### **4. Маягтын нэр:** ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙН ХЯНАЛТЫН КАРТ

**Маягтын дугаар:** ӨЭ-3.А

**Ойлголт, тодорхойлолт:** Уг маягт нь тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн харьяалалд байгаа болон түр хугацаанд хяналтад байгаа хүүхэд тус бүрээр хүүхдийн өсөлтийг нэг нас хүртэл сар бүрээр, хоёр нас хүртэл 3 сараар, 5 нас хүртэл нэг жилээр холбогдох үзлэг, хэмжилт, өвчлөлийн байдлаар бүртгэнэ.

**Нөхөх заавар:** Өрх, сумын эрүүл мэндийн төвийн сувилагч, бага эмч нар нь хүүхдийн өсөлтийг маягтын дагуу хянаж, зааврын дагуу бөглөн үнэн зөв тэмдэглэж, бөглөнө. Хүүхдийн өсөлт, хоол тэжээл, амин дэм, эрдсийн хэрэглээг зааврын дагуу тэмдэглэж, хүүхдийн өвчлөлийн байдлыг эмчийн үзлэгийг үндэслэн эмчийн зааврын дагуу тэмдэглэл хийнэ. ӨЭ-3А болон ӨЭ-3Б маягтуудыг үндэслэн ЭМТ 101.2-3 тайлангууд гарна.

**Хадгалах хугацаа:** 20 жил

**Хяналт, баталгаажилт:** Тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч дээрх маягтын хөтлөлт, үнэн зөв байдалд сар туамд хяналт тавьж баталгаажуулна.

**5. Маягтын нэр:** ХҮҮХДИЙН ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ  
**Маягтын дугаар:** ӨЭ-3.Б

**Ойлголт, тодорхойлолт:** Уг маягт нь тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн харьяалалд байгаа болон түр хугацаанд хяналтад байгаа хүүхдүүдийн өсөлт, хоол тэжээлийн байдал, өвчлөлийг тодорхой насны ангиллаар бүртгэж хянах маягт юм.

**Нөхөх заавар:** Өрх, сумын эрүүл мэндийн төвийн сувилагч, бага эмч нар нь Хүүхдийн эрүүл өсөлт, хөгжлийн хяналтын карт ӨЭ-3А маягыг үндэслэн, зааврын дагуу үнэн зөв тэмдэглэж, бөглөнө.

Насны ангиллыг 0-6 сартай, 7-12 сартай, 24 сартай, 36 сартай, 48 сартай, 59 сартай хүүхдийн үзлэг, хэмжилтийн мэдээллийг оруулах ба “хэмжвэл зохих” мөрөнд тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн хяналтад байгаа болон түр оршин суугч иргэдийн хүүхдийн тоог сар бүрээр тооцоолон тэмдэглэнэ. “Хэмжсэн” мөрөнд тухайн сард өсөлт, хөгжлийн хяналтад хамрагдсан хүүхдийн тоог тэмдэглэж, өсөлт, хоол тэжээлийн байдал, амин дэм, эрдсийн хэрэглээ, өвчлөлийн байдлыг зааврын дагуу үнэн зөв тэмдэглэнэ.

**Маягыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн:** Өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч

**Хадгалах хугацаа:** 20 жил

**Хяналт, баталгаажилт:** Тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч дээрх маягтын хөтлөлт, үнэн зөв байдалд сар тутамд хяналт тавьж баталгаажуулна.

**6. Маягтын нэр:** 2 САР ХҮРТЭЛХ ХҮҮХДИЙН ҮЗЛЭГИЙН МАЯГТ  
**Маягтын дугаар:** ӨЭ-4.А

**Ойлголт, тодорхойлолт:** Уг маягт нь тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн харьяалалд байгаа нь нярай хүүхдэд үзлэг хийх тутамд энэ маягыг бөглөнө. Үзлэгийг ЭМС-ын тушаалаар батлагдсан эмнэлзүйн удирдамжийн дагуу үзлэгийг хийж илэрч байгаа, зовиур, шинж тэмдгүүдийг нарийвчлан тодорхойлж, эмчилгээг тэмдэглэнэ.

**Нөхөх заавар:** Өрх, сумын эрүүл мэндийн төвийн сувилагч, бага эмч нар нь Хүүхдийн эрүүл өсөлт, хөгжлийн хяналтын карт ӨЭ-3А маягыг үндэслэн, зааврын дагуу үнэн зөв тэмдэглэж, бөглөнө.

Насны ангиллыг 0-6 сартай, 7-12 сартай, 24 сартай, 36 сартай, 48 сартай, 59 сартай хүүхдийн үзлэг, хэмжилтийн мэдээллийг оруулах ба “хэмжвэл зохих” мөрөнд тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн хяналтад байгаа болон түр оршин суугч иргэдийн хүүхдийн тоог сар бүрээр тооцоолон тэмдэглэнэ. “Хэмжсэн” мөрөнд тухайн сард өсөлт, хөгжлийн хяналтад хамрагдсан хүүхдийн тоог тэмдэглэж, өсөлт, хоол тэжээлийн байдал, амин дэм, эрдсийн хэрэглээ, өвчлөлийн байдлыг зааврын дагуу үнэн зөв тэмдэглэнэ.

**Маягыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн:** Өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч

**Хадгалах хугацаа:** 5 жил

**7. Маягтын нэр:** ХОЁР САРААС 5 ХҮРТЭЛХ НАСНЫ ӨВЧТЭЙ ХҮҮХДИЙН ҮЗЛЭГИЙН МАЯГТ  
**Маягтын дугаар:** ӨЭ-4.Б

**Ойлголт, тодорхойлолт:** Уг маягт нь тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн харьяалалд байгаа өвчилсөн хүүхэд ирж үзүүлэх үед хөтлөгдөнө.

**Нөхөх заавар:** Өвчний шинж тэмдэг илэрч, үзлэгт орж хийлгэж буй 2 сараас 5 хүртэлх насны хүүхдэд уг маягыг хөтлөх ба илэрч байгаа, зовиур, шинж тэмдгүүдийг нарийвчлан тодорхойлж, эмчилгээг тэмдэглэх шинж тэмдгүүдийг нарийвчлан тодорхойлж, эмчилгээг тэмдэглэнэ.

**Маягыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн:** Өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч

**Хадгалах хугацаа:** 15 жил

**8. Маягтын нэр:** ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРАГДСАН 0-15 НАСТАЙ ХҮҮХДИЙН НЭГДСЭН БҮРТГЭЛ  
**Маягтын дугаар:** ӨЭ-5.А

**Ойлголт, тодорхойлолт:** Хүүхэд ямар вакцины, хэддүгээр тунд, хичнээн тун хэмжээтэй, хэзээ, хаана хамрагдсаныг тодорхойлох бүртгэл юм.

**Нөхөх заавар:** Вакцинатор сувилагч хүүхдэд вакцин хийх бүртээ холбогдох асуултын дагуу бүрэн, гаргацтай бөглөнө. Вакцин хийсэн сар, өдөр, цаг минут, тун хэмжээ, серийн дугаарыг бүрэн, зөв тэмдэглэх ба хийсэн вакцины тунг (+ ) тэмдгээр тэмдэглэнэ. Өрхийн эмч, дархлаажуулалт хариуцсан эмч, тархвар судлагч хяналт тавина.

Уг бүртгэлийн мэдээллийг сар бүрийн заавал хийх дархлаажуулалтын хамралтын мэдээг гаргахад ашиглана.

“Урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан байдал”-ыг бөглөхдөө заавал хийх дархлаажуулалтын сарын төлөвлөгөө, эх, хүүхдийн ягаан дэвтэр, урьдчилан сэргийлэх тарилгын карт, дархлаажуулалтын өдөр тутмын бүртгэл зэрэгт үндэслэн үнэн зөв, бүрэн бөглөнө.

**Маягтыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн:** Өрх, сумын эмч, өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч

**Хадгалах хугацаа:** 5 жил

**Хяналт, баталгаажилт:** Тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч, эрхлэгч эмч дээрх маягтын хөтлөлт, үнэн зөв байдалд сар тутамд хяналт тавьж баталгаажуулна.

**9. Маягтын нэр:** ТОВЛОЛЫН БУС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАРИЛГАД ХАМРАГДСАН ХҮМҮҮСИЙН БҮРТГЭЛ

**Маягтын дугаар:** ӨЭ-5.Б

**Ойлголт, тодорхойлолт:** Хүүхэд ямар вакцины, хэддүгээр тунд, хичнээн тун хэмжээтэй, хэзээ, хаана хамрагдсаныг тодорхойлох бүртгэл юм.

**Нөхөх заавар:** Вакцинатор сувилагч хүүхдэд вакцин хийх бүртээ холбогдох асуултын дагуу бүрэн, гаргацтай бөглөнө. Вакцин хийсэн сар, өдөр, цаг минут, тун хэмжээ, серийн дугаарыг бүрэн, зөв тэмдэглэх ба хийсэн вакцины тунг (+ )тэмдгээр тэмдэглэнэ. Өрхийн эмч, дархлаажуулалт хариуцсан эмч, тархвар судлагч хяналт тавина.

Уг бүртгэлийн мэдээллийг сар бүрийн заавал хийх дархлаажуулалтын хамралтын мэдээг гаргахад ашиглана.

“Урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан байдал”-ыг бөглөхдөө заавал хийх дархлаажуулалтын сарын төлөвлөгөө, эх, хүүхдийн ягаан дэвтэр, урьдчилан сэргийлэх тарилгын карт, дархлаажуулалтын өдөр тутмын бүртгэл зэрэгт үндэслэн үнэн зөв, бүрэн бөглөнө.

**Маягтыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн:** Өрх, сумын эмч, өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч

**Хадгалах хугацаа:** 5 жил

**Хяналт, баталгаажилт:** Тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч, эрхлэгч эмч дээрх маягтын хөтлөлт, үнэн зөв байдалд сар тутамд хяналт тавьж баталгаажуулна.

**10. Маягтын нэр:** ТОВЛОЛЫН БУС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАРИЛГАД ХАМРАГДСАН ХҮМҮҮСИЙН БҮРТГЭЛ

**Маягтын дугаар:** ӨЭ-5.А

**Ойлголт, тодорхойлолт:** Уг бүртгэлийн мэдээллийг тархвар судлал, нэмэлт, сайн дурын дархлаажуулалтын хамралтын үед хөтлөгдөх бүртгэл юм.

**Нөхөх заавар:** Уг бүртгэлийг вакцинатор, өрх, сумын сувилагч, бага, их эмч нар бүртгэнэ.

**Маягтыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн:** Өрх, сумын эмч, өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч

**Хадгалах хугацаа:** 5 жил

**Хяналт, баталгаажилт:** Тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч, эрхлэгч эмч дээрх маягтын хөтлөлт, үнэн зөв байдалд сар тутамд хяналт тавьж баталгаажуулна.

1. Харьяа сум, өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагч хөтөлж, жил бүр шинэчлэх ба өрхийн эмч, эрхлэгч, дарга нар хяналт тавина.

**11. Дархлаажуулалтад хамрагдсан 0-15 насны хүүхдийн нэгдсэн бүртгэл ӨЭ-5.1**

**12. Товлолын бус урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан хүмүүсийн бүртгэл ӨЭ-5.3**

**13. Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн бүртгэл ӨЭ-5.4**

Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын их эмч, бага эмч, сувилагч нар дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг сэжиглэсэн, оношлосон тохиолдол бүрийг бүртгэнэ.

**14. Урьдчилан сэргийлэх тарилгын орлого зарлагын өдөр тутмын бүртгэл ӨЭ-5.5**

Орлого, зарлагын өдөр тутмын бүртгэлд вакцины үлдэгдлийг өдөр бүр тэмдэглэнэ. Багана бүрт тохирох мэдээллийг үнэн зөв, бүрэн бөглөнө. Вакцин татан авахад нэг төрлийн вакцины өөр үйлдвэрлэгчийн вакцин ирвэл түүнийг шинэ хуудаснаас бүртгэж эхэлнэ. Үлдэгдэл байгаа тунгаа хуучин хуудас дээрээ дуусгана. Уусгагч шингэн, тариур, аюулгүй хайрцагны орлого, зарлагыг бүртгэнэ.

А- Тарьсан болон хуваарилсан он, сар, өдрийг тэмдэглэнэ.

Б- Вакцин захилах бүрт захиалгын хуудас бөглөх бөгөөд үүнийг дугаарласан байх ёстой. Уг дугаарыг тэмдэглэнэ.

В- Хүлээн авч байгаа эсвэл зарцуулж байгаа вакцины серийн дугаарыг бүтэн бичнэ.

Г- Хүлээн авч байгаа эсвэл зарцуулж байгаа вакцины дуусах хугацааг тэмдэглэнэ.

Д- Вакцин хүлээн авах бүрт он, сар, өдрийг тэмдэглэнэ.

Е- Вакцин хүлээн авах үед хэм хяналтын хэрэгсэл ямар байсан тухай тэмдэглэнэ. ВШМ хэддүгээр шатанд байсан, термометрийн заалт хэдийг зааж байсан, хөлдөлтийг тандах заагуур хэвийн байсан эсэх гэх мэт ямар хэм хяналтын хэрэгсэл байснаас шалтгаалж уг нүдийг бөглөнө.

Ё- ХӨСҮТ болон аймаг, дүүргээс нэгжид вакцин хуваарилсан тохиолдолд тухайн хуваарилж байгаа ЭМБ-ын нэрийг бичнэ. Энэ нь сум, ӨЭМТ, дархлаажуулалтын нэгжид хамаарахгүй.

Ж- Хэдэн хүн тун вакцин орлогод хүлээн авсанаа бичнэ. З, И, К хэсгийг дархлаажуулалтын нэгжид хөтлөнө.

ХӨСҮТ, аймаг, дүүргээс хуваарилалт хийж байгаа тохиолдолд зарцуулалтыг К /бүгд зарлага/ багананд бичнэ.

З- Хэдэн хүн тунг тарьсан тоог бичнэ.

И- Хэдэн хүн тунг устгасан тоог бичнэ. Вакцин, биобэлдмэл устгах журмын дагуу устгалын протокол үйлдэнэ.

К- Бүгд зарлага хэсэгт тарьсан тун дээр устгасан тунг нэмж бичнэ.

Л- Эцсийн үлдэгдлээ бичнэ. Үлдэгдэл = Өмнөх үлдэгдэл+орлого-бүгд зарлага

Сар бүрийн эцэст улаан шугам татаж орлого, тарьсан тун, устгасан тун, бүгд зарлага, эцсийн үлдэгдлээ нэгтгэн бичнэ. Сарын эцэст хөргөгчинд байгаа вакцины үлдэгдлийг тоолж, дүнг орлого зарлагын бүртгэлтэй тулган хянасны дараа тооллогын протокол үйлдэн, зарцуулалтын мэдээг маягтын дагуу гаргана. Дууссан дэвтрийг архивлана.

### **0-15 настай хүүхдийг дархлаажуулах сарын төлөвлөгөө ба хамралт ӨЭ-6**

Уг төлөвлөгөө нь тухайн сард вакцинд хамрагдвал зохих хүүхдийн судалгааг гаргаж, дархлаажуулалтад хамруулсан хүүхдийг тэмдэглэх бүртгэл бөгөөд дархлаажуулалтын сар бүрийн хамралтын мэдээ гаргахад ашиглана. Харьяа сум, өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагч, бага, их эмч нар сар бүр гаргана. Өрхийн эмч, дархлаажуулалт хариуцсан эмч, тархвар судлагч хяналт тавина.

### **Сэргийлэх тарилгаас татгалзсан тухай мэдээлэх хуудас ӨЭ-6.А**

Сэргийлэх тарилгаас татгалзсан тухай мэдээг тухай бүр бүртгэж, дараа сарын 10-ны дотор ХӨСҮТ-д [immunization@nccd.gov.mn](mailto:immunization@nccd.gov.mn) цахим хаягаар ирүүлэх ба мөн сар бүр статистикийн албан ёсны мэдээлэлд оруулна.

### **Хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээ ӨЭ-7**

Хүүхэд тус бүрийг заавал хийх дархлаажуулалтын товлолын дагуу вакциныг хэзээ хийснийг тэмдэглэх маягт юм. Хүүхдийг дархлаажуулсан вакцинаатор сувилагч хөтөлнө.

### **СТ-9 Нярайн вакцин хийсэн тухай бүртгэл**

1. Амаржих газар, төрөх тасгийн вакцинаатор сувилагч өдөр тутамд заавал хийх дархлаажуулалтад хамруулсан нярай хүүхдийн бүртгэлийг хөтлөх ба дархлаажуулалт хариуцсан бага, их эмч нар хяналт тавина.
2. Нярайд вакцин хийгээгүй үед вакцины тухай мэдээллийг хоосон орхих ба вакцинд хамрагдаагүй шалтгааныг товч дурьдана.
3. Тогтмол хаягт иргэний үнэмлэх дээрх хаягыг бүртгэх ба 2 утасны дугаар авахыг хичээнэ.
4. Уг бүртгэлийн мэдээллийг сар бүрийн заавал хийх дархлаажуулалтын хамралтын мэдээг гаргахад ашиглана.

### **“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүртгэл” ӨЭ-8**

Энэ бүртгэлд үйлчлэх хүрээний хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнийг бүртгэнэ. Өрх, сумын эмч хөтөлнө. ӨЭ-8, ӨЭ-9, ӨЭ-10 маягтуудыг үндэслэн ЭМТ101.5.1-3 тайлан гарна.

**Хөгжлийн бэрхшээлтэй хүн:** Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг "хөгжлийн бэрхшээлтэй" хүн гэнэ. Хөгжлийн бэрхшээлийн төрлийг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

**Төрөлхийн:** Хөгжлийн бэрхшээлийн төрөлд удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадваргүй хүнийг хамруулна.

**Олдмол:** Хөгжлийн бэрхшээлийн төрөлд ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, эрдийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадваргүй хүнийг хамруулна.

Хөгжлийн бэрхшээлийн илэрсэн хэлбэрийг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

- 1. Харааны:** Харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний "харах" хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан. /2 нүдний хараа бүрэн эсвэл хагас алдагдсан, / - 12 / - / -20 / хүртлэх харааны шил зүүдэг хүмүүс, нэг нүд нь огт байхгүй юмуу эсвэл протезтой нөгөө нүд нь шилээр засрахгүй тохиолдол хамаарна/
- 2. Ярианы:** Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин, эмгэгийн улмаас хүний "ярих" хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан/ авиан дуудлагын өөрчлөлттэй, тультраа, ээрүү, гацаа гэх мэт хүмүүс орно/
- 3. Сонсголын:** Сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний "сонсох" хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан. /Төрөлхийн болон өвчний улмаас үүссэн дүлийрэлүүд, 70 дицепилээс дээш сонсголын алдагдалтай, бууралттай/
- 4. Хөдөлгөөний:** Биеийн тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан. /Саа, саажилт, үе мөч, яс, булчингийн системийн эмгэг өөрчлөлтөөс хөдлөх чадвараа алдсан, мөч тайралттай, бие бялдрын өөрчлөлттэй, одой, нанизм, майга тавхайтай хүмүүс орно/
- 5. Сэтгэцийн:** Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх ухамсарлахуйн болон зан төлөвийн өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдэцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцоо дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан оюун ухааны бэрхшээлийг сэтгэцийн эмгэг гэж ойлгоно. /Нойрны хямралтай, нүдэнд нь хий юм харагддаг, ганцаараа ярьж хөхөрдөг, их уур уцаартай, архи болон эм, мансууруулах бодист донтой хүмүүс орно/
- 6. Хавсарсан бэрхшээл:** Нэг хүнд 1- ээс дээш төрлийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, согог тохиолдвол бүртгэнэ. /Оюун ухааны хомсдолтой хүүхэд, хөдөлгөөний өөрчлөлттэй, хэл ярианы дутагдалтай хүмүүс байж болно/
- 7. Бусад:** Хөгжлийн бэрхшээлийн дээр дурдсан хэлбэрээс бусад хэлбэрийг үүнд хамааруулна. /Тухайлбал: дотор эрхтний эмгэгүүд, хавдар гэх мэт/

### **“Хөгжлийн бэрхшээлтэй хүний ахиц дэвшлийг үнэлэх маягт” ӨЭ-9**

энэ маягтыг хөгжлийн бэрхшээлтэй хүн тус бүр дээр ямар ахиц дэвшил гарч байгааг үнэлэхэд ашиглана.

### **“Өрхийн эмчийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст үзүүлсэн тусламжийн бүртгэл” ӨЭ-10**

Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс ирж үзүүлэх үед маягтыг бөглөнө. Өвчлөл нь шинэ, хуучин эсэх, хяналтанд авсан эсэх, эм олгосон эсэхийг тэмдэглэх боломжтой маягт юм.

### **Маягтын нэр: ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН МАЯГТ**

**Маягтын дугаар: ИЭМ-1**

Үзлэг хийсэн он сар эмч хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжил, хоол тэжээл, хөгжлийг үнэлж үзлэг хийхээр гэрээр нь очсон эсвэл хүүхэд эцэг эхийн хамт ЭМТ-д ирсэн он сар өдөр.

#### **1. Хүүхдийн мэдээлэл:**

Хүүхдийн хаягийн хэсгийн мэдээллийг эцэг, эх, амран хамгаалагдаас асууж, үнэн зөв, бүрэн гүйцэд бөглөнө. Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ.

Хүүхдийн ургийн овог, эцэг, эхийн нэр, хүүхдийн нэр, нас хүйсийг анхааралтай бүрэн гүйцэд бөглөнө. Гэрийн хаягийг засаг захиргааны нэгжийн кодын дагуу кодлож бүртгэнэ. Эхийн иргэний үнэмлэхийг үндэслэн аймаг/хот, сум/дүүрэг, баг/хороо зэргийг гаргацтай бичнэ.

Жишээ: Аймаг/хот Орхон

Сум/дүүрэг Жаргалант

Баг/хороо Улаантолгой баг

## **2. Эхийн мэдээлэл**

Эхийн мэдээллийн хаягийн хэсгийг кодлох зааварт заасан ангиллын дагуу тэмдэглэж, програм хангамжид оруулна.

Эхийн регистрийн дугаарыг бөглөхдөө иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ. Регистрийн дугаар гэсэн 10 нүд бүхий хүснэгтийн эхний 2 нүдэнд үсгийг том үсгээр, сүүлийн 8 нүдэнд цифрийг тус бүрт гаргацтай бичнэ.

Кодлох аргачлалыг ашиглан гэрлэлтийн байдлыг тэмдэглэнэ. Тусгаарласан гэдэгт гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй тусдаа амьдарч байгаа хүмүүсийг оруулна. Гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч иргэний бүртгэл мэдээллийн төвд бүртгүүлж гэр бүлээ батлуулаагүй хүмүүсийг батлуулаагүй гэж кодлоно.

Тамхи татдаг эсэх асуултад хэрэв тийм бол, өдөрт татдаг тамхины тоог асууж тэмдэглэнэ.

Архи уудаг эсэх талаар тэмдэглэгээг огт уудаагүй тохиолдолд үгүй гэсэн хариултыг,

Тийм гэсэн хариултыг-архийг үгүйлэх байдлаар уудаг, архины хамаарал бүхий хүмүүсийг оруулна. Хааяа-гэсэн асуултад зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд хэрэглэдэг тохиолдолд энэ тэмдэглэгээг хийнэ.

## **3. Эхийн эрүүл мэндийн мэдээлэл**

Маягтад заасан өвчнүүд болон бусад өвчнүүдээр өвдөж, оношлогдож эмчилгээ хийлгэж байсан тохиолдолд **Тийм** гэсэн тэмдэглэгээг хийж, харгалзах өвчнийг тэмдэглэх буюу бичнэ.

Өмнө нь ямар нэгэн өвчин оношлогдож, эмчлэгдэж байгаа тохиолдолд **үгүй** тэмдэглэгээг хийнэ. Эхэд жирэмсэнтэй хавсарсан эрхтэн тогтолцооны эмгэг байвал тохирох хариултын кодыг сонгоно. Нэгээс олон хариулт сонгож болно. Эхэд тохиолдсон эрхтэн тогтолцооны эмгэг дээрх хариултад эмгэгийн нэрийг тодорхой бичнэ. Халдварт ба шимэгчит өвчин байвал тодорхой бичнэ.

Эцгийн эрүүл мэндийг ямар нэгэн өвчин зовиургүй тохиолдол  **Хэвийн** , тухайн нөхцөлд юм уу эсвэл урьд нь өвчин эмгэг оношлогдож, эмчлэгдэж байсан тохиолдолд  **Хэвийн биш** тэмдэглэгээг хийж зовиурыг тодорхой бичиж тэмдэглэнэ.

Эхийн жирэмслэлтийн түүхийг нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний заавар удирдамжуудыг мөрдлөг болгосон болно.

Өмнөх төрөлтийн тоонд нийт төрөлтийн тоог бичнэ. Ихэр бол нэг төрөлтөнд тооцно. Эхийн төрсөн, үр хөндүүлсэн, зулбасан, мэс засал хийлгэсэн эсэхийг доогуур нь зурж хэдэн удааг асууж бичнэ.

## **V. Эмчийн үзлэг /хүүхэд/**

Эмнэлгийн мэргэжилтэн бодит үзлэгийг ЗАВАЛ хийнэ. Үзлэг хийхдээ хүүхдийн эх болон гэр бүлийн гишүүдийг хамт байлцуулна. Хүүхэд эрүүл бол “Эрүүл” гэсэн хариултын өмнөх  энэ нүдэнд  тэмдгээр тэмдэглэнэ. Өвчтэй бол өөрчлөлт илэрсэн хэсэгт тэмдэглэнэ.

Үнэлгээний хэсэгт хүүхэд эрүүл бол “Эрүүл” гэсэн хариултын өмнөх  энэ нүдэнд  тэмдгээр тэмдэглэнэ. Өвчтэй бол ХӨЦМ-ийн дагуу үнэлэн ангилал, бусад өвчин илэрвэл тухайн өвчний онош, өсөлт хөгжлийн хоцрогдолтой бол тураал, туранхай, өсөлтийн хоцрогдол болон хоол тэжээлийн дутагдалтай эсэхийг тэмдэглэнэ.

Өсөлтийг хэмжиж тэмдэглэнэ: Хүүхдийн биеийн жинг хэмжин, килограммаар бичнэ. Жишээ нь: хүүхдийн жин 8 кг 700 гр байвал 8.7 кг гэж бичнэ.

Хүүхдийн биеийн уртыг хэмжин тэмдэглэнэ: Уртын хэмжээг сантиметрээр бичнэ. Жишээ нь: хүүхдийн өндөр 1 метр 12 см байвал 112 см гэж бичнэ.

Хүүхдийн жин, уртын харьцааг тодорхойлно: Биеийн жинг урт/өндөрт нь харьцуулсан харьцааг хэлнэ. Энэ үзүүлэлтээр туранхай, илүүдэл жин, таргалалтыг илрүүлэх ач холбогдолтой. Мөн хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутлыг тодорхойлдог.

Толгойн тойргийг туузан метрээр хэмжиж см-ийг тэмдэглэнэ.

Цус багадалттай бол () зохих тэмдэгээг хийнэ.

Хооллолтын байдал : Хөхөө хөхдөг  Холимог  Ердийн  нүдэнд () зөвлөх тэмдгээр тэмдэглэнэ.

Хөхөө хөхдөг – Эхийн сүүгээр дагнан хооллож (Эхийн хөхний сүүнээс өөр бусад шингэн, ус, цай, шүүс зэргийг огт авахгүй байхыг хэлнэ) байгаа,

Холимог - Эхийн сүүний зэрэгцээ эхийн сүү орлуулагчаар хооллож байгаа буюу холимог хооллолтойг тэмдэглэнэ.

Шүдний эрүүл мэндийг үнэлнэ. Үүнд: Хүүхдийн шүд анх хэдэн сартайд ургасан талаар эцэг, эх асран хамгаалагчаас тодруулж тэмдэглэх ба одоо хэдэн шүдтэй байгааг үзэж тэмдэглэнэ. Шүд амны хөндийн эрүүл мэндийг хамтад нь үнэлж ямар нэгэн эмгэггүй, шүд цоорол, гажиггүй бол  эрүүл нүдэнд () зөвлөх тэмдгээр тэмдэглэнэ. Хэрэв эмгэг ажиглагдвал тохирох  нүдэнд () зөвлөх тэмдгээр тэмдэглэж дүгнэлтийн хэсэгт оношийг тавина.. Цооролттой бол эмчлэх шаардлагатай шүдний тоог бичнэ.

Үнэлгээний хэсэгт хүүхэд эрүүл бол “Эрүүл” гэсэн хариултын өмнөх  энэ нүдэнд  тэмдгээр тэмдэглэнэ. Өвчтэй бол ХӨЦМ-ийн дагуу үнэлэн ангилал, бусад өвчин илэрвэл тухайн өвчний онош, өсөлт хөгжлийн хоцрогдолтой бол тураал, туранхай, өсөлтийн хоцрогдол болон хоол тэжээлийн дутагдалтай эсэхийг тэмдэглэнэ

## **Дархлаажуулалт**

Өрх сумын эмч, ээлжит үзлэгийн үед дархлаажуулалтад хугацаандаа хамрагдсан эсэхийг шалгаж тэмдэглэх ба хамрагдаагүй бол хэрхэн дархлаажуулалтад орохыг зөвлөх болон дархлаажуулалтын ач холбогдлыг эцэг эхэд тайлбарлаж өгнө.

Дархлаажуулалтын товлолын дагуу хүүхдийн товлосон насанд заавал хийх вакцины нэрний ард байгаа □ нүдэнд (√) зөвлөх тэмдгээр тэмдэглэн, вакцин хийсэн огноо цаг минутыг заавал бичнэ.

### Хүүхдэд хэмжилт хийх

Хүүхэд бүрийн өсөлт, хөгжил тухайн хүүхдийн биеийн онцлогоос хамаарч янз бүр байдаг. Хүүхдийн биеийн байдал, өсөлт, хөгжлийг төрсний дараах эхний 2 сарын дотор 6 удаа, түүнээс хойш сар бүр гэрийн идэвхтэй эргэлт, амбулаторийн үзлэг, дархлаажуулалтын үед тогтмол үнэлж, хянаснаар хүүхдийн биеийн өсөлтийн хоцрогдол, хоол тэжээлийн цочмог дутлыг илрүүлэх ач холбогдолтой.

### Зураг. Жин-насны хүснэгтэд өсөлтийн муруйг тэмдэглэсэн байдал

#### Хүснэгт. Өсөлт, хөгжил, хоол тэжээлийн цочмог дутлыг үнэлэх үзүүлэлт

Z оноо (СХ)	Өсөлтийн үзүүлэлт		
	Урт/өндөр-нас	Жин-нас	Жин-урт/өндөр
3 – аасдээш	Хэт өндөр	-	Тарган
2-оос дээш	Өндөр	-	Илүүдэл жинтэй
1 – ээсдээш	Эрсдэл	Эрсдэл	Эрсдэл
0 (голч)	Хэвийн	Хэвийн	Хэвийн
-1-ээс доош	Эрсдэл	Эрсдэл	Эрсдэл
-2-оос доош	Өсөлт хоцрогдол/намхан	Тураал	Туранхай
-3-аас доош	Өсөлтийн хүнд хоцрогдол	Хүнд тураал	Хүнд тураал

### Өсөлтийн муруйг ашиглан эцэг эх, асран халамжлагчид зөвлөгөө өгөх

Хүүхдийн өсөлт, хөгжлийн хэмжилт бүрийг 5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэн тухайн хүүхдийн өсөлтийн байдлыг эцэг, эхчүүдэд мэдээлж, эрсдэлтэй буюу өөрчлөлттэй тохиолдол бүрийг эцэг эх, асран халамжлагчтай ярилцаж, шалтгааныг тодорхойлон тохирох зөвлөмж өгнө.

Өвчний шинж тэмдэг илэрсэн бол илэрч байгаа, зовиур, шинж тэмдгүүдийг нарийвчлан тодорхойлж, эмчилгээг тэмдэглэх шинж тэмдгүүдийг нарийвчлан тодорхойлж, эмчилгээг тэмдэглэнэ. Дээд шатлалд онош баталгаажуулах шардлагатай бол тэмдэглэгээг хийж, эцэг, эх асран хамгаалагчид нарийн тайларлаж ойлгуулна.

## I. Ерөнхий дүгнэлт

Эмчийн ерөнхий дүгнэлтийг дараах байдлаар гаргана.

Үзлэгт хамрагдсан хүүхдэд ямар нэгэн эмгэг шинж болон өвчлөл илрээгүй тохиолдолд **Эрүүл** гэж дүгнэнэ.

Ямар нэгэн эмгэг болон өвчлөл илэрсэн тохиолдолд үндсэн өвчнийг сонгож дээрээс доош нь дараалуулах зарчмаар сонгож бичнэ. Үндсэн өвчин гэдэг нь хамгийн их оношлогоо, эмчилгээ шаардагдах өвчнийг хэлнэ.

Нэг хүүхдэд хэдэн ч өвчлөл бүртгэгдэж болох ба авсан арга хэмжээг доорх зааврын дагуу бүртгэсэн өвчлөл тус бүрд тодорхой зааж бичнэ.

- **Амьдралын хэв маягаа өөрчлөх (зөвлөгөө)**
- 1. **Хооллолт**                      2. **Идэвхитэй хөдөлгөөн**    3. **Хорт зуршил**                      4. **Бусад**
  - Өрх, сумын ЭМТ-д хяналтанд авах **(кодоор)**
- 1. **3 хүртэлх сар**                      2. **6 хүртэлх сар**
  - Өрх, сумын ЭМТ-д эмчилгээнд хамрагдах **(кодоор)**
- 1. **Эмийн**                      2. **Эмийн бус**
  - Дээд шатлалын эмнэлэгт онош баталгаажуулах **(кодоор)**
- 1. **Дүүргийн ЭМТ**                      2. **АНЭ, БОЭТЗ. Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг** 4. **Хувь ЭМБ**
  - Дээд шатлалын эмнэлэгт эмчилгээнд хамрагдах **(кодоор)**
- 1. **Дүүргийн ЭМТ**                      2. **АНЭ, БОЭТЗ. Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг** 4. **Хувь ЭМБ**

Үзлэгт хамрагдсан хүүхдийг эрүүл мэндийг үзлэгийг үндэслэн эрүүл мэндийн 5 бүлэгт хамруулна. /Эрүүл мэндийн бүлгийг ойлголт, тодорхойлолт бүлгээс харна уу/

**Маягтыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн:** Өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч, сургуулийн эмч

**Хадгалах хугацаа:** Байнга

**Маягтын нэр:** 5-18 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭД, ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН МАЯГТ

**Маягтын дугаар:** ЭИМ-2

Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ.

**Ойлголт, тодорхойлолт:** Энэхүү маягт нь 5 наснаас 17 настай хүүхдийн эрүүл мэндийг хянаж, тодорхой хугацаанд эмчийн үзлэгт хамруулах зорилготой болно. Хүн амын эрүүл мэндийн зайлшгүй тулгамдсан асуудлын нэг болох төрөлхийн болон олдмол хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж, хөгжлийн дэмжлэг, сэргээн засах, оролцоо, боловсролын үйлчилгээнд аль болох эрт хамруулах нь нэн чухал юм.

Манай улсад хүүхэд бүрийн жин өндрийг хянах тогтолцоотой ч хөгжлийг хянах тогтолцоо байхгүй байна. Хүүхдийн хөгжлийг тандаж хянаж, хөгжлийн хоцрогдлын эрсдэлтэй хүүхдийг олж илрүүлэх үйл явц нь анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага өрх, сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай шууд холбогдох ёстой.

**Нөхөх заавар:**

Үзлэг хийсэн он сар эмч хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжил, хоол тэжээл, хөгжлийг үнэлж үзлэг хийхээр гэрээр нь очсон эсвэл хүүхэд эцэг эхийн хамт ЭМТ-д ирсэн он сар өдөр.

---

## **II. Хүн ам зүйн ерөнхий мэдээлэл**

---

Хүүхдийн хаягийн хэсгийн мэдээллийг шаардлагатай тохиолдолд эцэг, эх, амран хамгаалагдаас асууж, үнэн зөв, бүрэн гүйцэд бөглөнө. Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ.

Хүүхдийн ургийн овог, эцэг, эхийн нэр, хүүхдийн нэр, нас хүйсийг анхааралтай бүрэн гүйцэд бөглөнө. Гэрийн хаягийг засаг захиргааны нэгжийн кодын дагуу кодлож бүртгэнэ. Эхийн иргэний үнэмлэхийг үндэслэн аймаг/хот, сум/дүүрэг, баг/хороо зэргийг гаргацтай бичнэ.

Жишээ: Аймаг/хот Орхон

Сум/дүүрэг Жаргалант

Баг/хороо Улаантолгой баг

---

### III. Эрүүл мэндийн ерөнхий мэдээлэл

---

Өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч нь Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.14.1-т заасны дагуу уг дэвтэрт хүүхдийн биеийн жингийн индексийг жилд 2 удаа хэмжиж, тооцоолно гэж заасан.

Хүүхдийн биеийн жингийн индексийг тооцохдоо доорх томъёогоор олно. Тооцоолохдоо ДЭМБ-аас гаргасан аргачлал, удирдамжийг баримтлах бөгөөд зарим насанд тооцооллыг өөрөөр хийж болно.

$$\text{БЖИ} = \frac{\text{Жин}}{\text{Өндөр}^2} \times 100$$

**Туранхай гэдэг нь** - биеийн жингийн индекс 18.5-аас бага кг/м.кв байх

**Хэвийн гэдэг нь** - биеийн жингийн индекс 18.5-24 кг/м.кв байх

**Илүүдэл жинтэй гэдэг нь** - биеийн жингийн индекс 25-29 кг/м.кв байх

**Тарган гэдэг нь** - биеийн жингийн индекс 30 кг/м.кв-аас их байхыг байхыг хэлнэ.

Хүүхдийн хараа, сонсголыг анхааралтай үзэж, харааны шил, сонсголын аппарат, шүдний гажгын аппарат зүүж буй эсэхийг тэмдэглэнэ.

---

### IV. Эмчийн үзлэг

---

Эмнэлгийн мэргэжилтэн бодит үзлэгийг ЗААВАЛ хийнэ. Үзлэг хийхдээ шаардлагатай тохиолдолд хүүхдийн эх болон гэр бүлийн гишүүдийг хамт байлцуулна. Хүүхэд эрүүл бол “Эрүүл” гэсэн хариултын өмнөх □ энэ нүдэнд ✓ тэмдгээр тэмдэглэнэ. Өвчтэй бол өөрчлөлт илэрсэн хэсэгт тэмдэглэнэ.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 255 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл шүд - Эрүүл хүүхэд" хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах, эрчимжүүлэх зорилгоор хүүхдийн Амны хөндийн эрүүл мэндийн асуудлуудыг багтаасан асуумжийг цогцоор оруулсан. Энэхүү асуумж нь мэргэжлийн шүдний эмч бус өрх, сумын эмч, сургуулийн эмч зааврын дагуу хараад тэмдэглэх боломжтойгоор оруулсан тус хүүхдийн шүдийг харж, маягтын дагуу тэмдэглэн, эмчилгээ, үйлчилгээ шаардлагатай хүүхдийг шүдний эмч, нарийн мэргэжлийн эмчийн хяналтад шуурхай явуулна.

Сүүн шүд унаагүй боловч байнгын шүд нь давхар ургасан эсэхийг сайтар тэмдэглэж мэргэжлийн эмчийн хяналтанд илгээнэ.

Байнгын 1-р их араа буюу 6-р шүд ургаж, буйлнаас цухуйж эхэлмэгц мэргэжлийн эмчид хандаж ховил битүүлэх эмчилгээ (ховилын ломбо) хийлгэх зайлшгүй шаардлагатай тул мэргэжлийн эмчийн хяналтанд илгээнэ.

Гэмтлийн улмаас шүд хөдөлгөөнд орсон хожуу үүсэх хүндрэлээс сэргийлж шүдний эмчид үзүүлж зөвлөгөө авах шаардлагатай

Холимог зуултын үед хүүхдийн сүүн ба байнгын шүдийг зураглалын шүд тус бүрт дараах байдлаар бичиж тэмдэглэнэ: Байнгын шүд: Ц, Л, А /цоорсон, ломбодсон, авсан/

Хүүхэд, өсвөр насныханд 8-18 насны хүүхдүүдэд ямар нэгэн хорт зуршилтай эмэх талаар асуумжийг заавал асууж, ажиглаж, үзлэг хийж бөглөнө.

Сэтгэцийн эмгэг өмнө нь оношлогдогдож байсан болон осол гэмтэлд өртөж байсан талаар асууж тэмдэглэнэ. Дараах тодорхойлолтыг баримтлана.

---

## V. Ерөнхий дүгнэлт

---

Эмчийн ерөнхий дүгнэлтийг дараах байдлаар гаргана.

Үзлэгт хамрагдсан хүүхдэд ямар нэгэн эмгэг шинж болон өвчлөл илрээгүй тохиолдолд **Эрүүл** гэж дүгнэнэ.

Ямар нэгэн эмгэг болон өвчлөл илэрсэн тохиолдолд үндсэн өвчнийг сонгож дээрээс доош нь дараалуулах зарчмаар сонгож бичнэ. Үндсэн өвчин гэдэг нь хамгийн их оношлогоо, эмчилгээ шаардагдах өвчнийг хэлнэ.

Нэг хүүхдэд хэдэн ч өвчлөл бүртгэгдэж болох ба авсан арга хэмжээг доорх зааврын дагуу бүртгэсэн өвчлөл тус бүрд тодорхой зааж бичнэ.

- **Амьдралын хэв маягаа өөрчлөх (зөвлөгөө)**

2. Хооллолт                      2. Идэвхитэй хөдөлгөөн      3. Хорт зуршил      4. Бусад

- Өрх, сумын ЭМТ-д хяналтанд авах (кодоор)

2. 3 хүртэлх сар                      2. 6 хүртэлх сар

- Өрх, сумын ЭМТ-д эмчилгээнд хамрагдах (кодоор)

2. Эмийн                      2. Эмийн бус

- Дээд шатлалын эмнэлэгт онош баталгаажуулах (кодоор)

2. Дүүргийн ЭМТ                      2. АНЭ, БОЭТЗ. Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг 4. Хувь ЭМБ

- Дээд шатлалын эмнэлэгт эмчилгээнд хамрагдах (кодоор)

2. Дүүргийн ЭМТ                      2. АНЭ, БОЭТЗ. Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг 4. Хувь ЭМБ

Үзлэгт хамрагдсан хүүхдийг эрүүл мэндийг үзлэгийг үндэслэн эрүүл мэндийн 5 бүлэгт хамруулна. /Эрүүл мэндийн бүлгийг ойлголт, тодорхойлолт бүлгээс харна уу/

**Маягтыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн:** Өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч, сургуулийн эмч

**Хадгалах хугацаа:** Байнга

**Маягтын нэр:** НАСАНД ХҮРЭГЧДИЙН ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН МАЯГТ

**Маягтын дугаар:** ЭИМ-3

---

## **VI. Хүн ам зүйн ерөнхий мэдээлэл**

---

Хүн ам зүйн ерөнхий мэдээллийг засаг захиргааны нэгжийн ангилал, кодын дагуу кодлож үнэн зөв, бүрэн гүйцэд бүртгэнэ. Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ.

Кодлох аргачлалыг ашиглан гэрлэлтийн байдлыг тэмдэглэнэ. Тусгаарласан гэдэгт гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй тусдаа амьдарч байгаа хүмүүсийг оруулна. Гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч иргэний бүртгэл мэдээллийн төвд бүртгүүлж гэр бүлээ батлуулаагүй хүмүүсийг батлуулаагүй гэж кодлоно.

Боловсролын түвшинг асуултын кодыг ашиглан тэмдэглэнэ.

---

## **VII. Эрүүл мэндийн ерөнхий мэдээлэл**

---

Эрүүл мэндийн үзлэгийг хийхдээ эмч үйлчлүүлэгчийн биеийн жингийн индекс тооцоолоход шаардлагатай хэмжилтүүдийг хийж, тооцоолно

Биеийн жингийн индексийг тооцохдоо доорх томъёогоор олно.

$$\text{БЖИ} = \frac{\text{Жин}}{\text{Өндөр}^2} \times 100$$

**Туранхай гэдэг нь** - биеийн жингийн индекс 18.5-аас бага кг/м.кв байх

**Хэвийн гэдэг нь** - биеийн жингийн индекс 18.5-24 кг/м.кв байх

**Илүүдэл жинтэй гэдэг нь** - биеийн жингийн индекс 25-29 кг/м.кв байх

**Тарган гэдэг нь** - биеийн жингийн индекс 30 кг/м.кв-аас их байхыг байхыг хэлнэ.

Биеийн жингийн индексийг тооцоолж хүн амын артерийн даралт, чихрийн шижингийн эрсдлийн бүлгийг тодорхойлж, үзлэг хийх төлөвлөгөөг гаргана. Мөн халдвар бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн асуумжууд болох арх, тамхины хэрэглээ, жимс ногоо хэрэглэдэг эсэх, идэвхтэй хөдөлгөөн хийдэг эсэх талаар асуумжийг анхааралтай асууж, асуултын өмнөх дугаарыг дугуйлж, програмд боловсруулалт хийнэ.

Амны хөндийн эрүүл мэндийн үзлэгийг өрх, сумын эмч сургалтаар заагдсан удирдамжийн дагуу хийж одоо байгаа шүдний тоог бичиж,  Эрүүл  Эрүүл бус-ийн аль нэгийг тэмдэглэнэ.

Хэрэв эрүүл бус гэвэл: Буйлны үрэвсэл (шүдээ угаахад цус гардаг эсэх)  Амны салстад шарх үүсдэг  Авагддаг шүдэлбэр зүүдэг (хиймэл шүд: хуванцар, уян хуванцар)  Шүдэлбэрийн таарамж сайн, дунд, муу (доогуур нь зурж тэмдэглэ)  Авагддаггүй шүдэлбэр (гүүрэлсэн шүдэлбэр, бүрээс, шаазан бүрээс, имплант гэх мэт) доогуур нь зурж тэмдэглэнэ.

Бусад үзлэгийг удирдамжийн дагуу хийж маягтын харьяалагдах асуумжийн өмнөх дугаарыг дугуйлж тэмдэглэнэ.

---

## ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ

### VIII. Артерийн гипертензи

---

Насанд хүрэгсдийн артерийн гипертензийн үзлэгийг Эрүүл мэндийн сайдын 2018 оны 07 сарын 17-ны өдрийн А/286 дугаар тушаалаар батлагдсан эмнэлзүйн зааврын дагуу үзлэг, оношлогоог хийж бүртгэнэ.

Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгийг өрхийн эрүүл мэндийн төв, сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн үзлэгийн эмч нар эмнэлгээр үйлчлүүлж буй 40-өөс дээш насны хүн амд хийнэ.

Артерийн даралт ихсэх эрсдэлтэй хүн амд 55-аас дээш насны эрэгтэй, 65-ас дээш насны эмэгтэйчүүдийг хамруулах ба мөн тамхи татдаг, удамшлын өвчинтэй, гиперхолестеринемитэй хүн амыг хамруулна.

Та сүүлийн 1 жилийн хугацаанд цусны даралтаа хэмжүүлсэн үү? асуугаад хэмжүүлсэн бол **1. Тийм**, хэмжүүлээгүй гэж хариусан тохиолдолд **2.Үгүй** хариултын өмнөх тоог дугуйлна.

Даралтын хэмжихдээ АГ-ийн илрүүлгийг баталгаажсан багажаар хийсэн олон удаагийн хэмжилт дээр үндэслэнэ. Хамгийн багадаа 2 удаагийн ирэлтээр, ирэлт бүрийн 2-3 удаагийн хэмжилтийн дунджаар АД-ын түвшинг тооцно.

Артерийн даралтаа хэмжүүлэхээс хамгийн багадаа 30 минутын өмнө хүнд зэргийн дасгал, хөдөлгөөн хийх, хэт идэх, кофе, цай, кока-кола уусан эсэхийг асууж, дүгнэлт гаргахдаа харгалзан үзнэ.

Өвчтөнд хэмжилт эхлэхийн өмнө дуу чимээгүй тасалгаанд хэдэн минут тайван суулгах ба артерийн даралтыг хэмжих явцад хэмжүүлж буй хүнтэй ярилцахыг хориглоно. Нуруугаа тэгш, урагш тонгойж гэдэс шахагдах байрлалд суулгахгүй, гарын бугалга ба зүрх ижил тувшинд байрласан байх ёстой. Гарын бугалга зүрхнээс дээш тувшинд байрлавал газрын татах хүчний нөлөөгөөр АД бага хэмжигддэг. Суудлын өндрийг тохируулан, хөлийн улаар шалан дээр бүтэн гишгүүлж суулгана. Артерийн даралтыг 1-2 минутын зайтайгаар, доод тал нь 2 удаа хэмжих ба даралтын түвшин зөрүү ихтэй байвал нэмэлт хэмжилтийг давтан хийнэ. Тарган, эсвэл туранхай хүнд том, жижиг манжетийг тааруулж, тохируулан хэрэглэх ба даралт буруу хэмжигдэх дараах үйлдлүүдийг анхаарна.

- Ханцуйгаа шамлах
- Хөлөө сандал, эсвэл ширээний хөндлөвч дээр тавих
- Бариу хувцас өмсөх (хоолойтой цамц/свитер)
- Алхаж, эсвэл дасгалын дараа цусны даралтыг шууд хэмжих
- Гараа тохойвчин дээр буруу байрлуулах
- Урагшаа тонгойх
- Тасалгаа хэтэрхий хүйтэн байх зэрэг нь артерийн даралтад нөлөөлдөг тул эдгээрийг зайлшгүй анхаарч, зөв хэмжилтийг хийнэ.

Цусны даралт хэмжилтийн үр дүнг дараах хүснэгтийн дагуу тэмдэглэнэ.

Түвшин	САД (мм.муб)	ДАД (мм.муб)
Хэвийн	<120	<80
Ихэссэн	120-129	<80
Артерийн гипертензи		
1-р зэрэг	130-139	80-89
2-р зэрэг	>140	>90

## IX. Артерийн гипертензийн онош баталгаажилт ба кодлох аргачлал

**Үр дүнгийн үзүүлэлт** тооцохдоо үзлэгийн эмч үйлчлүүлэгчийн цусны даралтыг 3 удаа хэмжиж, хэрэв цусны даралтын хэмжээ сиастолын даралт (СД) 120-өөс бага, ДД 80-ээс бага байвал хэвийн, СД 130 буюу түүнээс их, ДД 80 буюу түүнээс их байвал дахин даралтаа хэмжүүлэхийг товлон артерийн гипертензи байж болзошгүй гэж тодорхойлно.

### Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн давтан үзлэгийн үр дүнгийн тайлан

Артерийн гипертензи давтан үзлэгийн хэд хэдэн хэмжилтээр батлагдсан, эмчилгээ эхэлсэн үйлчлүүлэгчийн цусны даралт СД 130 буюу түүнээс их, ДД 80 буюу түүнээс их, нүдний уг дурандахад нүдний угт өөрчлөлт өгсөн байвал батлагдсан артерийн гипертензитэй гэж оношлоно.

Оношлогдсон тохиолдлыг шинээр бүртгэгдсэн өвчлөл гэж эрүүл мэндийн бүртгэл статистикийн програм хангамжид оруулан Өвчний олон улсын 10-р ангиллын дагуу тохирох кодыг тавина.

Даралт ихсэх өвчнийг I10-I15-аар кодлоно.

I10 Анхдагч даралт ихсэх өвчин

I11.\_ Зүрхний даралт ихсэх өвчин

I12.\_ Бөөрний даралт ихсэх өвчин

I13.\_ Зүрх ба бөөрний даралт ихсэх өвчин

I15.\_ Хоёрдогч даралт ихсэх өвчин

Даралт ихсэх өвчин ба зүрхний өвчин:

Хэрвээ зүрхний өвчин даралт ихсэх өвчний шалтгаант байвал I11.\_ Зүрхний даралт ихсэх өвчин гэж кодлоно. Жишээ нь: Зүрхний даралт ихсэх өвчин, кардиомегали I11.0

Хэрвээ зүрхний өвчин даралт ихсэх өвчний шалтгаант бус байвал тусад кодлоно. Атеросклероз зүрхний судасны өвчний шалтгаант байвал дараах байдлаар кодлоно.

Даралт ихсэх өвчин I25.1 I10

Бөөрний өвчний шалтгаант даралт ихсэх өвчин байвал I12.\_ кодлоно.

Зүрх ба бөөрний даралт ихсэх өвчин:

- ▶ хэрвээ I11.\_хамаарах зүрхний өвчин ба I12.\_ т хамаарах бөөрний өвчин хавсарсан байвал I13.\_ Зүрхний болон бөөрний даралт ихсэх өвчин гэж кодлоно.
- ▶ I11.\_ ба I13.\_ хамтад нь эсвэл I12.\_ ба I13. хамтад нь\_ , эсвэл I11.\_ ба I12.\_ хамтад нь хэзээ ч кодлож болохгүйг анхаар.

Хоёрдогч даралт ихсэх өвчин

- ▶ Тодорхой өвчний үед хоёрдогчоор үүссэн даралт ихсэх өвчин I15.\_ Даралт ихсэх өвчнийг 2догчоор үүсгэж байгаа өвчин үндсэн оношоор, даралт ихсэх өвчнийг дагалдах оношоор кодлоно.

Жишээ нь: Бөөрний артерийн судасны нарийслаас үүдэлтэй даралт ихсэх өвчин I70.1 I15.0

1-р зэргийн артерийн гипертензи оношлогдсон тохиолдолд өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмчийн хяналтад авч, удирдамжийн дагуу эмчилгээг хийх ба Эмчийн дүгнэлт хэсэгт амвдралын хэв маягаа өөрчлөх, өрх, сумын ЭМТ-д хяналтад авах, эмчилгээнд хамруулсан эсэхийг ялган тэмдэглэгээг хийнэ.

---

## Х. Артерийн гипертензи, нарийн мэргэжлийн эмчид илгээх заалт

---

Дараах шинж тэмдэг илэрсэн болон нарийн шинжилгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд дээд шатлалын эмнэлэгт илгээж Эмчийн дүгнэлт хэсэгт бичиж тэмдэглэнэ.

- Гипертензийн хямрал (криз)
- Хоёрдогч АГ
- Онцгой тохиолдлууд
- Бай эрхтний гэмтлийг илрүүлэх: Зүрх, бөөр, нүдний уг харах, цусны судасны эмгэгийг илрүүлэх гэх мэт.

---

## ХI. Чихрийн шижин

---

Цусан дахь сахарын хэмжээ ихэссэн эсвэл чихрийн шижин өвчнөөр оношлогдож байсан эсэх: талаар асуумжаар өмнө нь чихрийн шижин оношлогдсон бол 1. **Тийм**, өмнө шинжилгээгээр чихрийн оношлогдоогүй болон цусан дахь сахарын хэмжээ хэвийн байдаг тохиолдолд 2. **Үгүй**, шинжилгээ оношлогоо хийлгэж байгаагүй, цусан дахь сахарын хэмжээ ихсэж байсан эсэх талаар мэдээлэлгүй тохиолдолд 3. **Мэдэхгүй** гэдгийн өмнөх дугаарыг дугуйлна. Өмнө нь чихрийн шижин оношлогдсон хяналтад байдаг хүнийг дараагийн үр дүнг бөглөх шаардлагагүй. Бусад тохиолдолд эхлээд эрсдлийг тодорхойлно.

Чихрийн шижингийн эрсдэлийн үнэлгээг АНУ-ын ЧШ-гийн холбоо (ADA)-ноос гаргасан ЧШ-гийн эрсдлийн шалгуураар 8 ба түүнээс дээш оноо бүхий эрсдэлтэй хүн амд өлөн үеийн глюкозыг түргэвчилсэн аргаар үнэлэн, 5.6 ммоль/л ба түүнээс дээш гарсан тохиолдолд ЧШ-гийн онош тодруулах шинжилгээнд илгээнэ.

Чихрийн шижингийн эрсдэл бүхий хүн ам:

- 35 ба түүнээс дээш насны хүн ам;
- Таргалалт ба биеийн жингийн илүүдэлтэй (БЖИ>25 кг/м<sup>2</sup>, бүсэлхийн тойрог эрэгтэй >94см, эмэгтэй >80см);
- ЧШ-гийн удамшлын өгүүлэмжтэй (эцэг, эх, ах, эгч нь чихрийн шижинтэй);
- ЧШ-гийн эрсдлийн шалгуураар 8 ба түүнээс дээш оноо бүхий хүмүүс;
- Даралт ихсэлттэй буюу даралт бууруулах эм хэрэглэж буй;

- Зүрх судасны эмгэгтэй (зүрхний титэм судасны эмгэг, тархинд цус харвалт, захын судасны эмгэг);
- Бөөрний архаг эмгэгтэй;
- Жирэмсэн эмэгтэй (24-28 долоо хоногтой);

Чихрийн шижингийн эрсдлийн оноог Чихрийн шижингийн эрсдлийг тодорхойлох тусгай шалгуур хүснэгтийн дагуу тодорхойлно.

1	<b>Нас</b>	
	40-өөс доош	0
	40-49	1
	50-59	2
	60-аас дээш	3
2	<b>Хүйс</b>	
	Эрэгтэй	1
	Эмэгтэй	0
3	<b>Жирэмсэний ЧШ оношлогдож байсан эсэх</b>	
	Тийм	1
	Үгүй	0
4	<b>Эцэг, эх, ах, эгч, дүү ЧШ оношлогдож байсан эсэх</b>	
	Тийм	1
	Үгүй	0
5	<b>Артерийн даралт ихсэлт ба даралт бууруулах эм хэрэглэж буй эсэх</b>	
	Тийм	1
	Үгүй	0
6	<b>Өдөр бүр идэвхтэй дасгал хөдөлгөөн хийдэг эсэх</b>	
	Тийм	0
	Үгүй	1
7	<b>Биеийн жин хэвийн эсэх</b>	
	Тийм	0
	Үгүй	1
8	Нийт оноо	

**Нийлбэр оноо:**

**Эрсдэл бага** – Чихрийн шижингийн эрсдлийн оноо 4-оос бага байх;

**Дунд зэргийн эрсдэлтэй**- Чихрийн шижингийн эрсдлийн оноо 5-7 байх;

**Өндөр эрсдэлтэй**- Чихрийн шижингийн эрсдлийн оноо 8-аас дээш байх;

Цусны глюкозыг түргэвчилсэн (глюкометр) болон биохимийн гэсэн 2 аргаар тодорхойлж болно.

**Үр дүнгийн үзүүлэлт**

**Хэвийн**-түргэвчилсэн аргаар өлөн үед цусан дахь глюкозын хэмжээ 5.5-аас бага, биохимийн аргаар шинжилсэн үед 6.0-ээс бага байх;

**Өлөн үеийн глюкозын өөрчлөлттэй** - түргэвчилсэн аргаар өлөн үед глюкозын хэмжээ 6.0-ээс их, биохимийн аргаар үзэхэд 6.9-оос их байх;

Үр дүнгийн үзүүлэлтээр өлөн үеийн глюкозын өөрчлөлттэй эсвэл гипергликеми илэрсэн үед дараагийн шатлалд шилжүүлж цусны сийвэнд биохимийн аргаар глюкоз тодорхойлно.

Онош тавихдаа цусны глюкозын хэмжээг үндэслэн эмч дүгнэж Чихрийн шижин хэв шинж 2 онош батлагдсан эсэхийг дүгнэж тэмдэглэнэ.

1. Чихрийн шижин хэв шинж 2 өвчтэй
2. Чихрийн шижин хэв шинж 2 өвчингүй
3. Чихрийн шижин хэв шинж 2 байх сэжигтэй (Зөвхөн Глюкозын ачаалалтай сорил хийсний дараа тавигдана)

Өлөн үед, санамсаргүй тохиолдолд түргэвчилсэн аргаар болон биохимийн аргаар глюкоз үзэхэд глюкозын өөрчлөлттэй гарсан тохиолдолд оношийг батлах зорилгоор глюкозын ачаалалтай сорилыг удирдамж аргачлалын дагуу хийж маягтад тэмдэглэгээг хийнэ..

Оношийг лавлагаа шатлалын эмнэлэгт баталгаажуулж, батлагдсан тохиолдолд тэмдэглэж оношийг тавина.

Чихрийн шижин E10-E14 кодоод хамаарах ба ангиалал, хүндрэлээс шалтгаалан дараах аргачлалын дагуу кодлоно.

- ▶ Хэрвээ олон хүндрэлтэй боловч аль нэг нь давамгайлсан тодорхойлогдоогүй бол олон хүндрэлтэй .7 гэж кодлоно.

ИҮХЧШӨ бөөрний , захын судас үхжил, катарактай хавсарсан

E11.7 ЧШӨ олон хүндрэлтэй

E11.2† Инсулинээс үл хамаарах ЧШӨ бөөрний хүндрэлтэй

N08.3\* Гломерулонефрит

E11.5† Инсулинээс үл хамаарах ЧШӨ захын цусны эргэлтийн хүндрэлтэй

I79.2\* Захын судасны ангипати

E11.3† Инсулинээс үл хамаарах ЧШӨ нүдний хүндрэлтэй

H28.0\* ЧШӨ үеийн катаракт

- ▶ Чихрийн шижин өвчний төрөл, хүндрэлүүд

- Хэв шинж I = Инсулинээс хамаарах ЧШӨ = ЧШӨ өсвөр насанд үүсдэг

- Хэв шинж II = Инсулинээс үл хамаарах ЧШӨ = ЧШӨ насанд хүрсэн хойно үүсдэг

- ▶ Хүндрэлийг кодлохдоо дараах 4 дэгч тэмдэглэгээг тавина.

.0 Комтой

.1 Кетоацидозтай

.2 Бөөрний хүндрэлтэй

.3 Нүдний хүндрэлтэй

.4 Мэдрэлийн хүндрэлтэй

.5 Захын цусны эргэлтийн хүндрэлтэй

.6 Бусад тодорхой хүндрэлтэй

.7 Олон тооны хүндрэлтэй

.8 Тодорхойгүй хүндрэлтэй

.9 Хүндрэлгүй

### **Үйлчлүүлэгчийг дараагийн шатлалын эмчид илгээх заалт**

- Шинээр оношлогдсон чихрийн шижинтэй үйлчлүүлэгчийг онош баталгаажуулах зорилгоор лавлагаа шатны эмнэлгийн дотоод шүүрэл судлаач эмч рүү илгээнэ.
- Метформин эмчилгээнд (хоногт 2000 мг) үр дүнгүй эсвэл бодисын солилцооны хямрал (шээсэнд кетон+) илэрсэн, мөн ЧШ-тэй жирэмсэн эмэгтэйг лавлагаа шатны дотоод шүүрэл судлаач эмч рүү илгээнэ.

- ЧШ-гийн архаг хүндрэлүүдийн эмнэлзүйн шинж илэрсэн тохиолдолд өрх, сум, тосгоны ЭМТ-өөс харьяа аймаг, дүүргийн ЭМТ-ийн нүд, зүрх, бөөр, мэдрэл, мэс засал зэрэг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч рүү илгээнэ.
- Олон эрхтний хүндрэл хавсарсан тохиолдолд лавлагаа шатны (төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг) ЧШ-гийн хүндрэлээр мэргэшсэн багт (нүд, зүрх судас, бөөр, мэдрэл, судасны мэс засал, хөлний эмч) илгээнэ.

## **ХII. Цусан дахь холестерин түвшин**

Цусан дахь холестерин түвшинг өрх, сумын эрүүл мэндийн төвийн харьяаны 40-өөс дээш насны хүн амд хийнэ. Эрсдлийн бүлгийг толорхойлон эрсдэл өндөртэй хүмүүст тодорхойлох ба аргачлалын дагуу үзэж дүгнэлт, тэмдэглэгээг хийнэ.

## **ХIII. Хөх, Умайн хүзүүний хавдар**

Хөх, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийг 30-60 насны эмэгтэйчүүдэд хийнэ. Үзлэгийг хөх, умайн хүзүүний хавдрыг илрүүлэх удирдамжийн дагуу хийж, үр дүнг тэмдэглэнэ. Нүдээр харах тэмтрэхэд хэвийн байна уу, Бэрсүү байна уу Бэлэгдсэн /хөдөлгөөн/ байдал Жүржийн хальсны шинж /арьсны шархлаа/ зангилаа Хөхний толгой цааш татагдсан Хөхний толгойноос шүүрэл гарах зэрэг шинж байгаа эсэхийг сайтар үзэж, үр дүнг тэмдэглэнэ.

Өөрчлөлт илэрсэн тохиолдолд лавлагаа шатлалын эмнэлэгт онош тодруулахаар илгээнэ.

## **ХIV. Түрүү булчирхайн хавдрын илрүүлэг үзлэг**

Түрүү булчирхайн хавдрын эрт илрүүлэг үзлэгийг 50 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүдэд хийнэ. IPSS асуумжийг түрүү булчирхайн томролтой өвчтөнд илрэх шинж тэмдгийн үнэлэхэд ашиглана.

<b>Гадагшлуулалт хямралын шинж</b>							
1	<b>Шээсний дараа давсаг бүрэн сулрахгүй байх</b>	0	1	2	3	4	5
	Энэ мэдрэмж хэр олон тохиолдсон бэ?						
2	<b>Шээс тасалдах</b>	0	1	2	3	4	5
	Шээс явцад тасалдаж, дахин шээс тохиолдол хэр олон тохиолдсон бэ?						
3	<b>Шээс дусагнах эрчим султай гарах</b>	0	1	2	3	4	5
	Хэр олон тохиолдсон бэ?						
4	<b>Дүлүүлж шээх</b>	0	1	2	3	4	5
	Шээж эхлэх үед дүлэх байдал хэр олон тохиолдож байсан бэ?						
<b>Хуримтлуулалт хямралын шинж</b>							
5	<b>Шээсний давтамж</b>	0	1	2	3	4	5
	2 цагийн дотор дахин шээх шаардлага хэр олон тохиолдсон бэ?						
6	<b>Шээсээ барихад хэцүү болох</b>	0	1	2	3	4	5
	Хэр олон тохиолдсон бэ?						
7	<b>Шөнийн шээлт</b>	Үгүй	1 удаа	2 удаа	3 удаа	4 удаа	5< удаа
	Унтахаар хэвтсэний дараа өглөө босох хүртэл хэдэн удаа босож шээдэг вэ?	0	1	2	3	4	5
<b>Ерөнхий IPSS</b>							

- 7 асуулттай, асуулт бүр 6 хариултын хувилбартай
- Нийт 0-35 оноо байна
- Дүгнэхдээ:
- Нийлбэр оноо бага байх тусам түрүү булчирхайн эмгэгийн шинж тэмдэгийн илрэл бага байх ба эмийн эмчилгээний үр дүн сайн байна.

<b>Шинж тэмдэг бага зэргийн илрэлтэй</b>	<b>0-7 оноо</b>
Шинж тэмдэг дунд зэргийн илрэлтэй	8-19 оноо
Шинж тэмдэг хүнд зэргийн илрэлтэй	20-35 оноо

## **XV. Зүрхний цахилгаан бичлэг**

Зүрхний цахилгаан бичлэгийг өрхийн эрүүл мэндийн төвийн харьяаны 40-өөс дээш насны хүн амд хийнэ.

Мобайл зүрхний цахилгаан бичлэгийн аппаратаар үр дүн хэвийн гарсан тохиолдолд 1, өөрчлалттэй гарсан тохиолдолд хэвийн эсвэл эргэлзээтэй гэсэн үр дүнг дугуйлна. Үзлэгээр хэвийн бус оношлогдсон тохиолдолд хэм алдалт, ишемийн өөрчлөлт, бусад шинж тэмдгийн аль тохирохыг заавал тэмдэглэнэ.

Үзлэгээр хэвийн бус гарч ямар нэгэн онош тавих боломжгүй тохиолдолд **3. эргэлзээтэй** гэж тэмдэглэнэ.

Оношийн баталгаажилтийг хэвийн гэж дугуйлсан тохиолдолд **2. Эрүүл** тэмдэглэгээг хийнэ.

Хэвийн биш гээд хэм алдалт, ишемийн өөрчлөлт болон бусад өвчин оношлогдсон тохиолдолд **1. Өвчтэй** тэмдэглэгээг хийж оношийг Өвчний олон улсын 10-р ангиллын дагуу кодлож, сарын шуурхай мэдээлэлд өвчлөлийг бүртгэн бүртгэл статистикийн програм хангамжид бүртгэж мэдээлнэ.

Өвчний сэжигтэй гэдэг нь хэвийн бус боловч өрх, сумын эрүүл мэндийн төвд онош тавих боломжгүй тохиолдолд лавлагаа шатлалын эмнэлэгт онош тодруулахаар илгээнэ.

## **XVI. Хэт авиан (ЭХО) оношилгоо**

Хэт авиан оношлогоог өрхийн эрүүл мэндийн төв, сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн үзлэгийн эмч нар эмнэлгээр үйлчлүүлж буй 40-өөс дээш насны хүн амд хийнэ.

Мобайл ЭХО – ны үр дүнгээр ямар нэгэн өөрчлөлтгүй тохиолдолд **1. Хэвийн** тэмдэглэгээг хийнэ. Үзлэгээр өөрчлөлт илэрсэн тохиолдолд **2. Хэвийн бус** тэмдэглэгээг хийнэ.

Хэвийн бус гэж тэмдэглэсэн тохиолдолд маягтад өгөгдсөн эрхтнүүдийн аль нэгд заавал тэмдэглэгээ хийгдсэн байх ба эсвэл хэд хэдэн эмгэг өөрчлөлт илэрч, тэмдэглэгдсэн байж болно.

Оношийн баталгаажилтийг хэвийн гэж дугуйлсан тохиолдолд **2. Эрүүл** тэмдэглэгээг хийнэ.

Хэвийн биш байвал оношлогдсон Өвчний олон улсын 10-р ангиллын дагуу кодлож, сарын шуурхай мэдээлэлд өвчлөлийг бүртгэн бүртгэл статистикийн програм хангамжид бүртгэж мэдээлнэ.

Өвчний сэжигтэй гэдэг нь хэвийн бус боловч өрх, сумын эрүүл мэндийн төвд онош тавих боломжгүй тохиолдолд лавлагаа шатлалын эмнэлэгт онош тодруулахаар илгээнэ.

Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгээр дээрх шалтгаануудаас бусад өвчлөл илэрсэн эсэх гэсэн асуултад заавал хариултыг тэмдэглэх ба ямар нэгэн өвчлөл илрээгүй бол **2. Үгүй**, эмгэг илэрсэн тохиолдолд 1. Тийм гэдэг тэмдэглэгээг хийж, ямар өвчин, зовиур илэрсэн талаар тодорхой бичиж тэмдэглэнэ.

---

## **ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ**

### **XVII. Сүрьеэ өвчний илрүүлэг үзлэг**

Өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч нар 18-аас дээш насны хүн амд илрүүлэг үзлэг хийнэ. Сүрьеэгийн шинж тэмдэг ба зовиур, Сүрьеэгийн тархвар судлалын асуумжаар сэжигтэй шинж илрэхгүй байвал хэвийн гэж үзээд сүрьеэ өвчингүй гэсэн дүгнэлтэд хүрнэ.

Асуумжаас сэжигтэй тохиолдол илэрвэл цээжний рентген, цэрний шинжилгээг авах эсэхийг шийдвэрлэнэ.

Шаардлагатай тохиолдлуудад Цээжний рентген шинжилгээнд хамруулж, цаашид цэрний шинжилгээ өгөх эсэхийг шийдвэрлэнэ. Оношийг лавлагаа шатлалын эмнэлэгт илгээж баталгаажуулна.

В, С вирүст хепатит, Тэмбүүгийн эрт илрүүлэг үзлэгийг удирдамжийн дагуу хийж харгалзах хариу, дүгнэлтийн өмнөх тоог дугуйлж, програм хангамжид оруулан үр дүнг тооцно.

---

## **XVIII. Хеликобактерийн халдвар илрүүлэг үзлэгийн үр дүн**

Илрүүлэг шинжилгээг 40-өөс дээш насны хүн амд хийх ба Хеликобактер Пилорийн хурдавчилсан оношлуураар удирдамж зааврын дагуу хийж үр дүнг тэмдэглэнэ. Оношлуурыг хэрэглэх зааврын дагуу хэрэглэж, үр дүнг тооцно.

Хеликобактер Пилорийн хурдавчилсан оношлуурын хариу:

1. Эерэг (+) Оношлуураар 2 тод өнгөт зурвас үүсэх. Нэг зурвас нь контрол зурвасын (С) хэсэгт нөгөө нь тест зурвасын хэсэгт үүснэ.(Т)  
(Т) хэсэгт үүсэх зурвасын өнгөний илрэл ийлдэс дэх эсрэг биеийн хэмжээнээс шалтгаалж янз бүр байх ба маш бүдэг зурвас үүссэн ч хариуг эерэг гэж үзнэ.
2. Сөрөг (-) байвал зөвхөн зурвасын (С) хэсэгт өнгөт зурвас үүснэ. (Т) тест зурвасын хэсэгт ямар ч зурвас үүсэхгүй.
3. Эргэлзээтэй-- С) хэсэгт зурвас үүсэхгүй байвал сорьцын хэмжээ хангалтгүй байсан эсвэл ажилбарын алдаа гарсан эсэхийг тодруулж, давтан хийнэ.

Оношийн баталгаажилтийг:

1. Хеликобактер Пилорийн халдвартай /оношлуураар Эерэг (+) гарсан/
2. Хеликобактер Пилорийн халдваргүй / оношлуураар Сөрөг (-) гарсан/ гэж оншлоно

---

## **XIX. Настанд илрүүлэг хийх хураангуйлсан асуумж**

---

Настанд эрүүл мэндийн анхан шатны байгууллага болох өрх, сумын эрүүл мэндийн төв өөрийн харьяалалд оршин суудаг 55, түүнээс дээш насны эмэгтэй, 60, түүнээс дээш насны эрэгтэйг хамруулна.

Настны өдөр тутмын бие даах чадварын болон багаж хэрэгсэлтэй ажиллах чадвар үнэлгээг Эрүүл мэндийн Сайдын 2010 оны 5 дугаар сарын 31-ны 180 тоот тушаалаар батлагдсан “Настны эрүүл мэндийн үнэлгээний удирдамж”-аар батлагдсан сорилуудаар үнэлдэг.

Настны эрүүл мэндийн байдлыг хэвийн, хэвийн бус 2 хэлбэрээр ангилна.

Маягтад буй 9 асуумжаас 2 нь тийм гэсэн тохиолдолд хэвийн бус ангилалд хамаарна.

**Сэтгэцийн болон зан төрхийн эмгэг:** Настанд өвчний олон улсын 10-р ангиллын 5-р бүлэгт хамаарах өвчин эмгэг бүртгэгдсэн тохиолдолд бичнэ.

**Насны доройтол:** Настанд өвчний олон улсын 10-р ангиллын R54 кодоод хамаарагдах шинж тэмдэг илэрсэн тохиолдолд бичнэ.

---

## **XX. Эмчийн ерөнхий дүгнэлт**

---

Үзлэгийг хийж эмч ерөнхий дүгнэлт гаргана.

Үзлэгт хамрагдсан иргэнд ямар нэгэн эмгэг шинж болон өвчлөл илрээгүй тохиолдолд **Эрүүл** гэж дүгнэнэ.

Ямар нэгэн эмгэг болон өвчлөл илэрсэн тохиолдолд үндсэн өвчнийг сонгож дээрээс доош нь дараалуулах зарчмаар сонгож бичнэ. Үндсэн өвчин гэдэг нь хамгийн их оношлогоо, эмчилгээ шаардагдах өвчнийг хэлнэ.

Нэг хүнд хэдэн ч өвчлөл бүртгэгдэж болох ба авсан арга хэмжээг доорх зааврын дагуу бүртгэсэн өвчлөл тус бүрд тодорхой зааж бичнэ.

- **Амьдралын хэв маягаа өөрчлөх (зөвлөгөө)**
- 3. **Хооллолт**                      2. **Идэвхитэй хөдөлгөөн**      3. **Хорт зуршил**                      4. **Бусад**
  - Өрх, сумын ЭМТ-д хяналтанд авах (**кодоор**)
- 3. **3 хүртэлх сар**                      2. **6 хүртэлх сар**
  - Өрх, сумын ЭМТ-д эмчилгээнд хамрагдах (**кодоор**)
- 3. **Эмийн**                      2. **Эмийн бус**
  - Дээд шатлалын эмнэлэгт онош баталгаажуулах (**кодоор**)
- 3. **Дүүргийн ЭМТ**                      2. **АНЭ, БОЭТЗ. Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг** 4. **Хувь ЭМБ**
  - Дээд шатлалын эмнэлэгт эмчилгээнд хамрагдах (**кодоор**)
- 3. **Дүүргийн ЭМТ**                      2. **АНЭ, БОЭТЗ. Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг** 4. **Хувь ЭМБ**

Үзлэгт хамрагдсан иргэний эрүүл мэндийг үзлэгийг үндэслэн эрүүл мэндийн 5 бүлэгт хамруулна.

Эрүүл мэнд, спортын сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2016 оны “Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинэчлэн батлах тухай” А/252, А/74 дугаар тушаалын дагуу Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв, салбар комисс, орон нутгийн комисс, эмнэлгийн байгууллагуудын эмнэлэг, хяналтын комиссоор батлагдсан хүмүүсийг 5-р бүлэгт шууд хамруулна

## Бүлэг I - Эрүүл хүмүүс

II Бүлэг – Ямар нэгэн архаг өвчингүй боловч өвчний өмнөх буюу дараах байдалд байгаа, аль нэгэн эрхтэн системийн үйл ажиллагааны ба бие бялдрын зарим нэгэн хөнгөн өөрчлөлттэй, биеийн эсэргүүцэл суларсан (хурц өвчнөөр олон дахин өвчлөгсөд ) хөдөлмөрийн чадвартай хүмүүс,

III Бүлэг – Архаг өвчтэй боловч тухайн эрхтэн системийн үйл ажиллагаа алдагдаагүй ( компенсацийн байдал) бие махбодын зарим өөрчлөлт, эрхтэн системийн гажиг (уродство)-тай, гэмтлийн үлдэцтэй боловч ажил хөдөлмөрөө хийж байгаа хүмүүс,

IV Бүлэг – Архаг өвчнөөр удаан өвчилж, эрхтэн системд өөрчлөлт орсон (субкомпенсацийн байдал ) өвчин гэмтлийн улмаас эрхтэн системийн үйл ажиллагаа буурч хөдөлмөрийн чадвар үе үе алддаг, тахир дутуугийн группд орсон хүмүүс,

V Бүлэг – Голдуу хэвтрийн дэглэм баримталдаг, декомпенсацийн байдалтай архаг хүнд өвчтэй, тахир дутуугийн 1 ба 2 группэд байдаг хүмүүс орно. Эдгээр ангиллын дагуу аль тохирох бүлгийг авч сонгож бичнэ.

Оношийн үндэслэл, хяналтын үечилсэн дүгнэлтийг эмчлэгч эмч асуултын дагуу үнэн гүйцэд маш тодорхой бичих бөгөөд хяналтын явцын байдал өөрчлөлтийг маш сайн тодорхой гаргаж бичих шаардлагатай.

Дараагийн шатлалд эмнэлэгт явуулж буй үндэслэлд онош тодруулах болон эмчилгээ хийлгэх шаардлагатай эсэхээ тэмдэглэж, анхдагч шатлалд хийгдсэн эмчилгээ, шинжилгээг амбулаторийн маяганд дэлгэрэнгүй бичнэ.

### Эмчийн үзлэгийн бүртгэл АМ-1А

Эрүүл мэндийн бүртгэл маягт АМ-1А маягтыг өрх,сумын эмч нар, АМ-1Б бүртгэлийн маягтыг амбулатори поликлиникин үзлэгийн эмч нар өдөр бүр хөтөлж, үзлэгийг 7 хоногоор нэгтгэж статистик мэдээллийн тасаг нэгжид хүлээлгэн өгнө. Эмчийн үзлэгийн бүртгэл нь өрхийн болон сумын эмч, нарийн мэргэжлийн кабинетын эмч нарын ажлын ачаалал болон үр дүнг үнэлэх үндсэн баримт болдог. Өрхийн эмчийн үзлэгийн бүртгэлээс ЭМТ 101.1-2 болон өвчлөлийн тайлангууд гарна.

Үзлэгийн төрөл, өвчлөлийн харгалзах нэг тоог дугуйлан тэмдэглэнэ.Өвчний улмаас амбулаторит тухайн өвчнөөр анх удаа хандвал **анх** гэснийг, 2 ба түүнээс дээш удаа үзүүлж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх шаардлага гарах тохиолдолд **давтан** гэж дугуйлна.

- Өвчний учир амбулаторийн үзлэг - ямар нэг өвчний шинж тэмдэг/ зовиур, шаналгааны улмаас эмнэлэгт хандахыг
- Урьдчилан сэргийлэх үзлэг - тодорхой зорилготой,тодорхой бүлэг хүмүүсийн дунд /албан байгууллага, сургууль,цэцэрлэг, цэрэг татлага г.м/ зориудаар хийгдсэн үзлэг
- Идэвхтэй хяналтын үзлэг –ЭМС-ын тушаалаар хяналтад авахаар заагдсан өвчний үзлэг
- Гэрийн идэвхтэй үзлэг-Өндөр настан, 0-15 насны хүүхэд, жирэмсэн эхчүүд, өртөмтгий бүлгийн хүмүүс (өрх толгойлсон эмэгтэйчүүд, ганц бие хүмүүс г.м )
- Гэрийн дуудлагын үзлэг-гэрээр нь дуудлагаар очиж үзсэн үзлэг

Үндсэн оношийг ӨОУА-10 –ын дагуу шифрлэнэ. Осол гэмтлийн өвчлөлийн тохиолдолд XIX бүлэг /S00-T99/, Н онош тавьсан тохиолдолд осол гэмтлийн шалтгааны V00-Y98-ын аль нь болохыг тогтоож шифрийг бичнэ.

**Шинэ өвчлөл-** Хүн амын дундах амбулаторит бүртгэгдсэн өвчлөлийг бүртгэх зорилгоор тухайн хүн уг өвчнөөр амьдралдаа анх удаа өвчилсэн тохиолдлыг бүртгэнэ.

**Хуучин өвчлөл-** Тухайн хүн урьд өвдсөн өвчин нь сэдрээд ирсэн тохиолдолд буюу архагшсан өвчлөлийг тухайн ондоо нэг удаа үзүүлэх тохиолдолд хуучин өвчлөлд тооцож авна. Хуучин өвчлөлөөр дахин давтан үзүүлсэн бол давтан үзлэгт тооцно.

**Давтан үзлэг-** Өвчлөл бүртгэгдсэнээс хойш эдгэрэх хүртлээ амбулатори, гэрээр эмчилгээ хийгдэж, дахин давтан ирж үзүүлсэн, шинжилгээ, боолт хийлгэсэн тохиолдолд давтан үзлэгт тооцно.

Хийгдсэн эмчилгээнээс шалтгаалан нэг буюу хоёр эмчилгээг зэрэг тэмдэглэж болно.

**Эрүүл мэндийн маягт АМ-2- Халдварт өвчлөлийг бүртгэх маягтыг халдварт өвчин, хам шинж, сэжигтэй тохиолдлыг бүртгэх, мэдээлэх журмын дагуу бүртгэнэ.**

**Эрүүл мэндийн маягт АМ-3- БЗДХ-ыг мэдээлэх маягтыг бэлгийн замаар дамжих халдварын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх журмын дагуу бүртгэнэ.**

БЗДХ-ын шинэ тохиолдлыг бүртгэх, мэдээлэх журам, мэдээллийн урсгал

Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвийн түвшинд

1.1 Өрх, сум (тосгон)-ын эмнэлэг, сум дундын эмнэлгийн статистикч бага эмч нь өрх, сум (тосгон)-ын үзлэгийн эмч нараас БЗДХ-ыг хам шинжээр оношлон “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас” АМ-3 маягтаар, лаборатори бүхий сум, сум дундын эмнэлэг онош батлагдсан бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ), төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас” АМ-3 маягтаар авна.

1.2 Өрх, сум (лаборатори бүхий сум, сум дундын эмнэлэг, тосгон)-ын үзлэгийн эмч нар төрөлхийн тэмбүүгийн батлагдсан тохиолдлыг “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас” АМ-3 маягтаар бүртгэж БЗДХ-ын эмчид мэдээлнэ. Цаашдын хяналт болон эмчилгээг БЗДХ-ын мэргэжлийн эмчээс зөвлөгөө авч эрүүлжүүлнэ.

1.3 Мэдээг сараар нэгтгэн нэгтгэлийг сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгон аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн БЗДХ-ын кабинетийн эмчид дараа сарын 3-нд цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн түвшинд

2.1 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын статистик мэдээллийн алба, нэгж нь аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн статистик тасгаас онош батлагдсан БЗДХ, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын тоон мэдээг авч дараа сарын 4-ны дотор үндэсний түвшинд **цахим хэлбэрээр** хүргүүлнэ.

2.2 Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн статистик тасаг нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн БЗДХ-ын кабинетаас онош батлагдсан БЗДХ, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг бүртгэсэн “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас”(АМ-3

маягт)-ыг ЭМЯ-наас зөвшөөрөгдсөн программд шивж цахим мэдээний санг үүсгэнэ. Цаасан (Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-304 тайлан) болон цахим мэдээний санг сар, улирлаар нэгтгэн дараа сарын 10-ны дотор цахим, 20-ны дотор цаасан хэлбэрээр ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА-нд хүргүүлнэ. БЗДХ-ын шинжилгээний тайланг эрүүл мэндийн байгууллагын лабораторийн эмч, лаборант нар сар, улирлаар гарган дараа сарын 10-ны дотор цахим, 20-ны дотор цаасан хэлбэрээр ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА-нд хүргүүлнэ.

2.3 Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн төрөх, эмэгтэйчүүд, арьс өнгө, хүүхэд, нярайн тасагт төрөлхийн тэмбүүгийн сэжигтэй тохиолдлыг тухайн эмнэлэгийн БЗДХ-ын мэргэжлийн эмч, нярайн эмч хамтран оношийг баталгаажуулж, эмчлэгч эмч “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас”(АМ-3 маягт)-ыг бичиж БЗДХ-ын кабинетийн эмчид мэдээлнэ.

2.4 Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн БЗДХ-ын кабинетийн эмч нь өрх, сумаас БЗДХ-ын хам шинжийн оношлогоо, БЗДХ, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг, тухайн харьяалалын БЗДХ-ын чиглэлээр ажиллаж буй ХХЭ, бусад тасаг, кабинетаас (төрөх, эмэгтэйчүүд, арьс өнгө, харшил, мэс засал...) илэрсэн БЗДХ, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас”(АМ-3 маягт)-ыг хүлээн авч мэдээллийн давхардлыг шалган, оношийг баталгаажуулан эцэслэж цаасан болон цахим мэдээний санг сар, улирлаар нэгтгэн дараа сарын 5-ны дотор цахим болон цаасан хэлбэрээр аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн статистик тасагт хүргүүлнэ.

2.5 Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн БЗДХ-ын кабинетийн эмч нь хам шинжийн оношлогооны болон онош батлагдсан БЗДХ, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын жилийн тайлан (Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-304 )-г дараа жилийн 1-р сарын 20-ны дотор ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА-нд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, төвүүд, БЗДХ чиглэлээр ажиллаж буй хувийн эмнэлэг

3.1 Мэдээллийн мэргэжилтэн, статистикч нь үзлэгийн кабинет, эмчилгээ, оношлогооны эмч нараас БЗДХ-ын шинэ тохиолдлыг “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас” АМ-3 маягтаар сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгон авна.

3.2 ЭНЭШТ болон төрөх эмнэлгүүдэд төрөлхийн тэмбүүгийн сэжигтэй тохиолдлыг тухайн харьяалалын БЗДХ-ын мэргэжлийн эмч, нярайн эмч хамтран оношийг баталгаажуулж, эмчлэгч эмч “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас”(АМ-3 маягт)-ыг бичиж ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА-нд мэдээлнэ. Эмнэлгээс гарсан тохиолдолд харьяа эмнэлгийн БЗДХ-ын мэргэжлийн эмчийн хяналтанд бүртгүүлнэ.

3.2 Сарын мэдээг өссөн дүнгээр улиралд нэгтгэн улирлын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа улирлын эхний сарын 5-ны дотор цахим болон цаасан хэлбэрээр ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА-нд хүргүүлнэ.

Үндэсний түвшинд

4.1 ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА нь мэдээний эх сурвалж байгууллагуудаас БЗДХ-ын хам шинжийн оношлогоо, онош батлагдсан БЗДХ, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг бүртгэсэн “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас”(АМ-3 маягт)-ын цахим баазыг дараа сарын 10-ны дотор, цаасан хэлбэрээр 20 ны дотор хүлээн авна.

4.2 ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА-ны статистикч бага эмч нь өөрийн байгууллагын үзлэгийн кабинет, эмчилгээ, оношлогооны эмч нараас онош батлагдсан БЗДХ, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг бүртгэсэн “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас”(АМ-3 маягт) маягтаар 7 хоног бүр хүлээн авч сар, улирлаар нэгтгэн гаргаж ЭМЯ-наас зөвшөөрөгдсөн программд шивж цахим мэдээний санг үүсгэн улсын хэмжээний тайлангийн нэгтгэлд оруулна.

4.3 ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА-нь БЗДХ-ын хам шинжийн оношлогоо, онош батлагдсан ДОХ/БЗДХ, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын мэдээний санг үндэсний түвшинд нэгтгэн, боловсруулалт, дүн шинжилгээ хийн ЗГХА-ЭМГ-ЭМСМХ-т дараа сарын 20-ны дотор цахим хэлбэрээр мэдээлнэ.

4.4 ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА-нь БЗДХ-ын хам шинжийн оношлогоо, онош батлагдсан ДОХ/БЗДХ, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг ДОХ/БЗДХ-ын шалтгаант нас баралтын жилийн тайланг (Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-304) нэгтгэн үндэсний түвшинд цахим болон цаасан хэлбэрээр дараа оны 2-р сарын 15-ны дотор хүргүүлнэ.

**“Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас”(АМ-3 маягт)  
хөтлөх заавар**

Асуумж	Аргачлал-Тодорхойлолт-Жишээ									
Эмнэлгийн нэр	2	0	0	2	1	2				
	УБ хот/аймаг/		Дүүрэг /сум/		Эмнэлгийн нэр					
<b>Хувь хүний тухай мэдээлэл</b>										
Дугаар 1.2 эцэг эхийн нэр, нэр	Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээг үндэслэн тод гаргацтай, татлахгүйгээр үнэн зөв бичнэ									
Дугаар 3: Өвчтний регистрийн дугаар	Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ. Анхаарах зүйл: РД гэсэн 10 нүд бүхий хүснэгтийн эхний 2 нүдэнд үсгийг том үсгээр дармалаар, сүүлийн 8 нүдэнд цифрийг нүд тус бүрт гаргацтай тод бичнэ. Жишээ нь:									
	А	Ю	7	8	1	2	2	9	1	3
Дугаар 4.5: Өвчтөний нас, хүйс	На сыг асууж гараар бичиж оруулна. Эрэгтэй- 1, Эмэгтэй бол 2-ийг зурна.									
Дугаар 6: Жирэмсэн	Тийм- 1, үгүй- 2 дугуйлна.									
Дугаар 7: Тогтмол хаяг: Утас: Ажлын газар, албан тушаал	Өвчтөний иргэний үнэмлэхийг үндэслэн аймаг, хот, сум, дүүрэг, хороо, хаалганы дугаар зэргийг гаргацтай тод гараар бичиж оруулна. Ажиллаж байгаа албан тушаал болон ажлын газрыг бичнэ									

Дугаар 8: Боловсрол	Боловсрол бага -1 /дунд сургуулийн 1- 4-р ангийг төгссөн / Боловсрол дунд-2 /дунд сургуулийн 5-11-р ангийг төгссөн/ Боловсрол мэргэжил-техникийн-3 /Мэргэжлийн болон техникийн коллеж төгссөн/ Боловсрол дээд-4 /Их дээд сургууль төгссөн/ Боловсролгүй -5 /ямар нэгэн сургууль төгсөөгүй буюу сургуульд ороогүйг хамааруулна/
Дугаар 9: Гэр бүлийн байдал	Гэрлээгүй-1, Гэрлэсэн -2, Салсан-3, Бэлэвсэн-4, Хамтран амьдрагчтай-5 аль тохирохыг дугуйлна.
Дугаар 10: Нийгмийн байдал	Ажил эрхэлдэг -1 Ажил эрхэлдэггүй-2 Оюутан-3 0-15 насны хүүхэд-4 Цэргийн албан хаагч, цэрэг-5 Тэтгэвэрт-6 Бусад-7
Дугаар 10: Илрүүлэлт	Урьдчилан сэргийлэлт -1 Өвчний учир амбулаторт-2 Амбулаторийн хяналт -3 Хавьтлаас -4 Сайн дураараа-5 Эмнэлгээс бусад /нэрийг тодорхой бичнэ үү/ -6 .....
<b>II. БЗДХ-ын мэдээлэл</b>	
Дугаар 12. Онош, оношийн үе шат	<b>2 дах шатлалаас онош батлагдсан шинэ БЗДХ</b> <b>Тэмбүү: 1-р үе шат/A51.1/</b> 2-р үе шат /A51.2/ 3-р үе шат /A51.3/ Далд /A51.4/ Төрөлхийн тэмбүү /A50.0/ Заг хүйтэн: Хүндэрсэн /A54.1/ Хүндрээгүй /A54.2/ Трихомониаз /A59.0/ Шээс бэлгийн замын хламид /A56.0/ Шээс бэлгийн замын мөөгөнцөр /B37.3 эм, B37.4 эр/ Нянгийн гаралтай үтрээний үрэвсэл /N76/ Бэлгийн герпес /A60.0/ Микоплазм Уреаплазм Бэлгийн үү /A63.0/
Дугаар 12. Хам шинжийн оношлогоо	Бэлгийн шархлаа Шээсний сувгийн ялгадас Үтрээний ялгадас Хэвлийн доод хэсгийн өвдөлт Төмсөг хавдах Цавины булчирхай томрох Нярайн нүдний салстын үрэвсэл

Дугаар 13. Халдварын эх уурхай	Бэлгийн хавьтлаар: Биеэ үнэлэгч-1А Байнгын бэлгийн хавьтал-1В Тохиолдлын бэлгийн хавьтал-1В Цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлсэн-2 Эхээс хүүхдэд халдварласан-3 Тодорхой бус-4
Дугаар 14. Онош баталгаажилт	Энгийн хурдавчилсан сорил-1 PRP-2 ТРНА-3 ФХЭБУ/ELIZA/-4 Полимеразын гинжин урвал-5 Өсгөвөр-6 наац-7 Нойтон түрхэц-8
Дугаар 15. Мэдээлсэн эмчийн нэр	Тухайн БЗДХ-ын шинэ тохиолдлыг мэдээлсэн их эмч

**Эрүүл мэндийн маягт АМ-4- Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх маягтыг сүрьеэ өвчнийг бүртгэх мэдээлэх журмын дагуу бүртгэнэ.**

**Эрүүл мэндийн маягт АМ-5-Хорт хавдрыг мэдээлэх маягт**

Хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг мэдээлэх хугацаа, урсгал

Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвийн түвшинд

1. Өрх, сум (тосгон)-ын эмнэлэг, сум дундын эмнэлгийн статистикч бага эмч нь өрх, сум (тосгон)-ын үзлэгийн эмч нараас хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг “Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5”, хорт хавдрын шалтгаант нас баралтыг “Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7” мэдээг өдөр бүр авна.

2. Мэдээг долоо хоног, сараар нэгтгэн нэгтгэлийг сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгон аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн хавдрын тасаг, нэгжийн хавдар бүртгэгчид дараа сарын 1-нд цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн түвшинд

1. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын статистик мэдээллийн алба, нэгж нь хавдар бүртгэгчээс хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтын тохиолдлын тоон мэдээг авч дараа сарын 4-ны дотор ЗГХА-ЭМГазрын СМХэлтэст цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2. Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн хавдрын тасгийн хавдар бүртгэгч нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, хувийн эмнэлэг, лабораториос улирал бүрийн сүүлийн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа улирлын эхний сарын 2-ны дотор “Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5” “Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7” -г цаасан болон цахим хэлбэрээр мэдээллийг хүлээж авна.

3. “Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5”, “Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7” маягтын өгөгдлийг ЭМЯ-наас зөвшөөрөгдсөн программд хавдар бүртгэгч шивж мэдээний санд мэдээллийн давхардлыг шалган, мэдээний санг үүсгэнэ.

4. Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн хавдрын тасгийн хавдар бүртгэгч хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтын цаасан болон цахим мэдээний санг улирлаар нэгтгэн дараа улирлын эхний сарын 10-ны дотор цахим хэлбэрээр, 20-ны дотор цаасан хэлбэрээр ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэлд хүргүүлнэ.

5. Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн хавдрын тасгийн хавдар бүртгэгч хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтын жилийн тайлан (Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-303 )-г дараа жилийн 1-р сарын 15-ны дотор ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэлд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүд, хувийн эмнэлэг болон бусад эмнэлэг

1. Мэдээллийн мэргэжилтэн, статистикч нь үзлэгийн кабинет, эмчилгээ, оношлогооны эмч нараас хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг “Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5”,

хорт хавдрын шалтгаант нас баралтыг “Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7” маягтаар өдөр бүр хүлээн авна.

2. Сарын мэдээг өссөн дүнгээр улиралд нэгтгэн улирлын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа улирлын эхний сарын 5-ны дотор цахим болон цаасан хэлбэрээр ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэлд хүргүүлнэ.

Үндэсний түвшинд

1. ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэл нь мэдээний эх сурвалж байгууллагуудаас “Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5 ” хорт хавдрын шалтгаант нас баралтыг “Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7” маягтын цахим баазыг дараа улирлын эхний сарын 10-ны дотор, цаасан хэлбэрээр 20 ны дотор хүлээн авна.

2. ХСҮТ-ийн амбулатори, стационари хариуцсан статистикч их эмч нь үзлэгийн кабинет, эмчилгээ, оношлогооны эмч нараас хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг “Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5” хорт хавдрын шалтгаант нас баралтыг “Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7” маягтаар өдөр бүр хүлээн авч сар, улирлаар нэгтгэн улирлын сүүлийн сарын 30-д ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэлд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

3. ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэл нь хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтын мэдээний санг үндэсний түвшинд нэгтгэн, боловсруулалт, дүн шинжилгээ хийн ЗГХА-ЭМГазрын ЭМСХэлтэст улирал тутмын дараа сарын 20-ны дотор цахим хэлбэрээр мэдээлнэ.

4. ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэл нь хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтын жилийн тайланг (Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-303) нэгтгэн жил бүрийн 2-р сарын 15-ны дотор ЗГХА-ЭМГазрын ЭМСХэлтэст цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

### **Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5 хөтлөх зааварчилгаа**

Асуумж	Аргачлал-Тодорхойлолт - Жишээ
<b>I. Хувь хүний тухай мэдээлэл</b>	
Дугаар 1-3: Өвчтний ургийн овог, эцэг эхийн нэр, нэр	Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээг үндэслэн тод гаргацтай, татлахгүйгээр үнэн зөв бичнэ
Дугаар 4: Өвчтний регистрийн дугаар	Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ.  Анхаарах зүйл: РД гэсэн 10 нүд бүхий хүснэгтийн эхний 2 нүдэнд үсгийг том үсгээр дармалаар, сүүлийн 8 нүдэнд цифрийг нүд тус бүрт гаргацтай тод бичнэ.  Жишээ нь:

	А	Ю	7	8	1	2	2	9	1	3								
Дугаар 5: Өвчтөний нас	<p>Нас гэсэн 3 нүд бүхийн хүснэгтэд насыг бичихдээ төрсөн он сарыг үндэслэн насыг тооцоолж эхний нүдэнд зуутын орон, дунд нүдэнд аравтын орон, сүүлийн нүдэнд нэгжийн орон байхаар тохируулж бичнэ. Жишээ нь: насыг тооцоход 3 настай гэж гарсан бол</p> <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <tr> <td>0</td> <td>0</td> <td>3</td> </tr> </table> <p>гэж бичнэ. Хэрэв сар болон хоногтой бол нэгжийн оронг 0 болгож хүснэгтийн гадна тоог тавиад сар, хоног аль нь болохыг бичнэ.</p> <p>Анхаарах зүйл: Өвчтөний насыг мэдэх боломжгүй, нотлох бичиг баримт огт байхгүй бол - хорт хавдрын онош тавигдсан он сар өдрөөр тооцоолно.</p>										0	0	3					
0	0	3																
Дугаар 6: Хүйс	Эрэгтэй- 1, Эмэгтэй бол 2-ийг дугуйлна																	
Дугаар 7: Боловсрол	<p>Боловсрол бага -1 /дунд сургуулийн 1- 4-р ангийг төгссөн /</p> <p>Боловсрол дунд-2 /дунд сургуулийн 5-11-р ангийг төгссөн/</p> <p>Боловсрол мэрэгжлийн-3 /Мэргэжлийн болон техникийн коллеж төгссөн/</p> <p>Боловсрол дээд-4 /Их дээд сургууль төгссөн/</p> <p>Боловсролгүй -5 /ямар нэгэн сургууль төгсөөгүй буюу сургуульд ороогүйг хамааруулна/</p>																	
Дугаар 8: Төрсөн он, сар, өдөр	<p>Асуултанд харгалзах 8 нүд бүхий хүснэгтэнд эхний 2 нүдэнд өдөр, дараагийн 2 нүдэнд сар, сүүлийн 4 нүдэнд оныг бүтнээр бичнэ. Төрсөн он сар өдрийг бичихдээ өвчтөний иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээг үндэслэн бичнэ. Жишээ: 1961 он 09 сар 17</p> <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <tr> <td>1</td> <td>7</td> <td>0</td> <td>9</td> <td>1</td> <td>9</td> <td>6</td> <td>1</td> </tr> </table> <p>Анхаарах зүйл:</p> <p>Төрсний гэрчилгээ аваагүй бол төрөлтийн түүхэн дэхь төрсөн он сар өдрийг бичнэ. Төрсөн он сарыг мэдэх боломжгүй тохиолдолд оныг мэдэж</p>										1	7	0	9	1	9	6	1
1	7	0	9	1	9	6	1											

	байвал сар өдрийг 01 сарын 01-ээр авна.		
Дугаар 9: Ажлын газар	<p>Өвчтөний хорт хавдрын онош батлагдах үед хийж гүйцэтгэж байгаа ажлын газрыг бичнэ. Харгалзах 2 нүдэнд ажлын газрын кодыг ЭМСайдын 34-р тушаалаар батлагдсан маягт бүртгэлийн эмхтгэл номын Хүснэгт №3-ийг ашиглана.</p> <p>Жишээ: Боловсролын салбарт ажилладаг бол</p> <table border="1" data-bbox="1016 499 1125 569"> <tr> <td>1</td> <td>6</td> </tr> </table> <p>гэж бичнэ.</p> <p>Анхааруулга: Ажлын газаргүй буюу аль нэг кодоод ороогүй ажлын газар бол 22-ыг сонгоно.</p>	1	6
1	6		
Дугаар 10: Албан тушаал	<p>Хорт хавдрын онош тавигдах үеийн албан тушаалыг бичнэ. Харгалзах 2 нүдэнд албан тушаалын кодыг доорхи жагсаалтыг ашиглан бичнэ.</p> <p>Ажилчин-1</p> <p>Албан хаагч-2</p> <p>Малчин-3</p> <p>Тэтгэвэрт-4</p> <p>Оюутан-5</p> <p>0-15 насны хүүхэд-6</p> <p>Групп болон бусад-7</p> <p>Ажилгүй-8</p> <p>Жишээ: Их эмч бол албан тушаалыг албан хаагчаар авна.</p> <table border="1" data-bbox="1016 1543 1125 1612"> <tr> <td>0</td> <td>2</td> </tr> </table> <p>гэж кодлон бичнэ</p>	0	2
0	2		
Дугаар 11: Мэргэжил	<p>Өвчний амьдралынхаа ихэнх хугацаанд ажиллаж өнгөрүүлсэн болон тухайн мэргэжилээр нарийвчлан сурч ажилласан мэргэжлийг бичнэ. Харгалзах 2 нүдэнд доорхи кодуудаас сонгон бичнэ. ЭМСайдын 34-р тушаалаар батлагдсан маягт бүртгэлийн эмхтгэл номын Хүснэгт №4-ийг ашиглана.</p>		

	<p>Жишээ: мэргэжил багш бол</p> <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <tr> <td style="padding: 2px 10px;">0</td> <td style="padding: 2px 10px;">4</td> </tr> </table> <p>гэж бичнэ.</p>	0	4				
0	4						
Дугаар 12: Гэрлэлтийн байдал	Гэрлэсэн бол-1, Гэрлээгүй бол -2, тодорхойгүй бол – 3-ийн аль тохирохыг сонгон дугуйлна.						
<p>Дугаар 13: Одоогийн оршин суугаа хаяг</p> <p>Холбогдох утас:</p>	<p>Өвчтөний иргэний үнэмлэхийг үндэслэн аймаг, хот, сум, дүүрэг, хороо, хаалганы дугаар зэргийг гаргацтай тод бичнэ. Харгалзах 6 нүд бүхий хүснэгтэнд ЭМСайдын 34-р тушаалаар батлагдсан маягт бүртгэлийн эмхэтгэл номын Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн ангилал Хүснэгт №1-ийг ашиглан кодыг сонгон эхний 2 нүдэнд аймаг, хотын, дунд 2 нүдэнд сум, дүүргийн, сүүлийн 2 нүдэнд баг, хорооны кодыг бичнэ.</p> <p>Жишээ: Хөвсгөл аймгийн рашаант сум 1-р хороо гэсэн бол</p> <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <tr> <td style="padding: 2px 10px;">1</td> <td style="padding: 2px 10px;">7</td> <td style="padding: 2px 10px;">1</td> <td style="padding: 2px 10px;">1</td> <td style="padding: 2px 10px;">0</td> <td style="padding: 2px 10px;">1</td> </tr> </table> <p>гэж бичнэ.</p> <p>Холбогдох утас: өвчтөнтэй холбоо барих ар гэрийнхэний, өвчтөний өөрийн утасны дугаарыг нэг бүрчлэн бичнэ.</p>	1	7	1	1	0	1
1	7	1	1	0	1		
Дугаар 14: Хорт хавдар оношилсон Эрүүл Мэндийн Байгууллага	Хорт хавдрыг оношилсон Эрүүл Мэндийн Байгууллагыг сонгон дугуйлна.						
<b>II. Хорт хавдрын мэдээлэл</b>							
Дугаар 15: Хавдрыг оношилсон огноо	Хавдрыг оношлосон шинжилгээ ба бусад үндэслэлийн дагуу хавдрын онош батлагдсан хамгийн эхний он, сар, өдрийг тооцон тавина.						
Дугаар 16 : Өвчтөний одоогийн байдал	<p>Хорт хавдар оношлогдох үед тухайн хүний байдал</p> <p>Амьд-1, Нас барсан-2, Тодорхойгүй-3 –ийн аль тохирохыг сонгон дугуйлна.</p> <p>Нас барсан огноог нас баралтын гэрчилгээг үндэслэн бичнэ.</p>						
Дугаар 17 : Анхдагч хавдрын	Хүний биеийн эрхтэн системийн аль хэсэгт хавдар байрлаж байгааг тодорхой заасан						

байрлалын онош	оношыг дэлгэрэнгүй бичнэ. Өөрөөр хэлбэл Өвчний олон улсын ангилал - Хавдар судлалыг ашиглан анхдагч хавдрын байрлалын оношийг бичмэлээр тавина.								
Дугаар 18: Олон улсын өвчний ангилал-хавдар судлал-3	Олон улсын өвчний ангилал-хавдар судлал-3 тавина. Жишээ: Ходоодны их биеийн хэсгийг хамарсан хорт хавдар C16.3 гэж кодлоно. Өвчний олон улсын ангилал - Хавдар судлал цусны хорт хавдрын / лейкеми/ C42 <table border="1" data-bbox="922 571 1182 640"> <tr> <td>C</td> <td>1</td> <td>6</td> <td>.</td> <td>3</td> </tr> </table>	C	1	6	.	3			
C	1	6	.	3					
Дугаар 19: Морфологийн онош	Эд, эсийн шинжилгээний дүгнэлтээс хавдрын эсийн төрөл, төлөв байдлыг дэлгэрэнгүй бичнэ								
Дугаар 19.1: Хавдрын төлөв	Эд, эсийн шинжилгээний дүгнэлтээс хавдрын эсийн төлөв байдлыг үндэслэн аль тохирохыг дугуйлна.								
Дугаар 19.2: Эсийн ялгарал	Эд, эсийн шинжилгээний дүгнэлтээс хавдрын эсийн ялгаралыг сонгон тохирохыг дугуйлна.								
Дугаар 19.3: Лимфома, лейкемийн эсийн ялгарал	Цусны хавдруудын үед эсийн шинжилгээний дүгнэлтийг үндэслэн аль тохирохыг дугуйлна.								
Дугаар 20. Хавдрын бүтэц зүйн оношийн код	<b>М</b> үсгээр эхэлсэн 8 нүд бүхий хүснэгтэнд Олон улсын өвчний ангилал-хавдар судлал-3 номыг ашиглан хавдрын бүтэц зүйн оношыг кодоор бичнэ.  Эхний нүдэнд <b>М</b> үсэг, дараагийн 4 нүдэнд хавдрын эсийн төрөл, 6 дах нүдэнд ташуу зураас, 7 дахь нүдэнд хавдрын эсийн төлөв, 8 дах нүдэнд хавдрын эсийн ялгаралын кодуудыг бичнэ.  Жишээ нь: Аденокарцинома- хортой, бага ялгаралтай бол <table border="1" data-bbox="824 1591 1432 1661"> <tr> <td><b>М</b></td> <td>8</td> <td>1</td> <td>4</td> <td>0</td> <td>/</td> <td>3</td> <td>3</td> </tr> </table>	<b>М</b>	8	1	4	0	/	3	3
<b>М</b>	8	1	4	0	/	3	3		
Дугаар 21. Анхдагч олон байрлалын хавдар мөн эсэх	Анхдагч ганц байрлалын хавдар -1  Анхдагч олон байрлалын хавдрын нэг тохиолдол-2  Тодорхойгүй -3								

<p>Дугаар 21.1 Хос эрхтний хавдар мөн эсэх:</p>	<p>Баруун -1 Зүүн -2 Нэг талыг хамарсан боловч ялгаж тусгаагүй -3 Хоёр талыг хамарсан - 4 Хос эрхтэн бус -5</p>
<p>Дугаар 22. Хавдрыг оношлосон шинжилгээ ба үндэслэл</p>	<p>Бичил харуурын болон бичил харуурын бус хүснэгтээс аль тохирохыг дугуйлна</p>
<p>Дугаар 23. Оношлогдох үеийн хавдрын үе шат /Олон улсын TNM ангилалыг баримтлан тавина/</p>	<p><b>T- нь анхдагч хавдрын хэмжээ /тархалт/</b> T-is Байран өмөн Tо- Анхдагч хавдар тодорхойлогдохгүй T1,T2,T3,T4-Анхдагч хавдрын тархалтыг тодорхойлно <b>N- Хавдар орчмын тунгалагийн булчирхай</b> No- Тунгалагийн булчирхайг гэмтээсэн шинж тэмдэггүй. N1,N2, N3- Тунгалагийн булчирхайг хир зэрэг гэмтээснийг илэрхийлнэ. Nx- Тунгалагийн булчирхай гэмтсэнийг тогтоох боломжгүй. <b>M- Эрхтэнд үсэрхийлэлтэй эсэхийг харуулна</b> Mo- Алсын эрхтэнд үсэрхийлэлийн шинж тэмдэггүй. M1- Алсын эрхтэнд үсэрхийлэлтэй. Mx- Алсын эрхтэнд үсэрхийлэл байгаа эсэхийг тогтоох боломжгүй</p>
<p>Дугаар 24. Хавдрын эмнэл зүйн үе шат</p>	<p>I, II, III, IV Ромбо тоог ашиглан хавдрыг эмнэл зүйгээр нь үе шатаар ангилна.</p>
<p>Дугаар 25. Хийгдсэн эмчилгээ</p>	<p>Хавдрын онош батлагдсан үеэс эхлэн эхний курс эмчилгээний төлөвлөгөө болон хийсэн эмчилгээг эмчилгээний хүснэгтээс аль тохирохыг сонгон харгалзах тоог дугуйлна.</p>

<p>Дугаар 26-26.1. Хийгдсэн мэс заслын нэр, мэс засал хийсэн эмнэлэг, эмч</p>	<p>Мэс заслын нэрийг дэлгэрэнгүй гаргацтай тод бичнэ.</p> <p>Мэс заслын үйлдлийн кодыг ICD-9-CM- Үйлдлийн Олон Улсын ангилал 9 - III ботийг ашиглана.</p>						
<p><b>III. Мэдээний эх сурвалж:</b> /Хорт хавдрын шинэ тохиолдол нь шүүх эмнэлэг, эмгэг судлалын шинжилгээгээр батлагдсан тохиолдолд мөн бөглөнө/</p>							
<p>Дугаар 27-27.1-4.Мэдээлсэн байгууллагын нэр, мэдээлэгдсэн баримтын дугаар, шинжилгээний дүгнэлт</p>	<p>Хорт хавдрыг оношилсон лаборатори, эмгэг судлалын төв, шүүх эмнэлгээс мэдээлэгдэж байгаа тохиолдол байгууллагын нэр, баримтын дугаар, шинжилгээний дүгнэлтийг дэлгэрэнгүй бичиж АМ-5 маягтын</p> <p><u>I. Хувь хүний мэдээллийн хэсгийг заавал бөглөнө.</u></p> <p>Хорт хавдрыг мэдээлж байгаа бусад эрүүл мэндийн байгууллагууд байгууллагынхаа нэрийг бичмэлээр бичин эрүүл мэндийн сайдын 34 тоот тушаалд заагдсан кодыг нүдэнд бичнэ.</p> <p>Жишээ нь: ХСҮТ мэдээлэгдсэн бол:</p> <table border="1" data-bbox="1084 957 1386 1024"> <tr> <td>2</td> <td>0</td> <td>0</td> <td>2</td> <td>1</td> <td>1</td> </tr> </table> <p>20- Улаанбаатар хот</p> <p>02- Баянзүрх дүүрэг</p> <p>11- ХСҮТ</p>	2	0	0	2	1	1
2	0	0	2	1	1		
<p>Дугаар 28. Бусад эх сурвалж</p>	<p>Эмнэлгийн бус мэдээний эх сурвалж байгууллагуудаас мэдээлэгдэх тохиолдолд тухай оныг тавин 99 тоогоор кодлоно</p>						
<p>Дугаар 29. Мэдээлсэн эмчийн нэр</p>	<p>Тухайн хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг мэдээлсэн их эмч</p>						
<p>Дугаар 30. Хүлээн авсан бүртгэлийн ажилтан</p>	<p>Аймаг, дүүргийн хавдрын бүртгэлийн ажилтан уг маягтыг хүлээн аваад бүрэн хөтлөгдсөн эсэхийг шалгаж мэдээлэл бүрэн болсон тохиолдолд мэдээлнэ</p>						

**Эрүүл мэндийн маягт АМ-6- Халдварт бус өвчлөлийг бүртгэх хуудас /зөвхөн цахимаар бүртгэнэ./**

Халдварт бус өвчлөлийг бүртгэх хуудас бичих үндсэн материал нь “Эмчийн үзлэгийн бүртгэлийн маягт АМ-1 А, Б болно. Энэхүү бүртгэлийн маягтаас хүн амын халдварт бус

өвчлөлийн тайлан гарна. Үзлэгийн эмч өвчлөл бүртгэсэн тохиолдол бүрт уг хуудсыг бичиж хөтлөх ба бичихгүй тохиолдол нь:

1. Онош бүрэн тогтоогдоогүй
2. Халдварт өвчин (Халдварт өвчнийг мэдээлэх хуудас-AM-2)
3. Хуучин өвчлөлийг тухайн онд анх эмнэлэгт хандсан тохиолдолд бүртгээд тухайн өвчнөөр давтан ирсэн тохиолдолд

Тухайн маягтыг үнэн зөв хөтөлсөн эсэхэд статистикч их, бага эмч нар хяналт тавьж програмд шивж оруулна. /Health-info 3.0/

Осол гэмтлийн өвчлөл бүртгэгдсэн тохиолдолд шалтгааныг заавал тодорхойлж V01-Y98 аль нь болохыг тогтоож шифрлэнэ.

### **Эрүүл мэндийн маягт AM-7- Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ хөтлөх заавар**

Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээг нас барсан хэлбэр, хаана нас барсныг харгалзахгүйгээр үйлчлэх нутаг дэвсгэрт нас барсан бүх тохиолдолд бичнэ. Гэрчилгээг иргэний бүртгэл мэдээллийн төвд бүртгүүлэхээр 2 хувь бичиж 1 хувийг нас барагчийн ар гэр, төрөл төрөгсдөд олгож, нөгөө хувийг нь эмнэлгийн статистик мэдээллийн тасагт хүлээлгэн өгнө. Статистик мэдээллийн тасагт статистикч их эмч бичлэг, кодлолтын үнэн зөвийг шалгаж, компьютерт шивнэ. Компьютерт шивсэн энэхүү анхан шатны бүртгэлийн маягтаас хүн амын нас баралтын тайлан насны ангилал, нас баралтын хэлбэрээр, нас барсан газраар гаргана. Гэрчилгээг заавал их эмч хөтөлнө. Багийн бага эмчийн салбарт гэрчилгээг бага эмч бичиж нас баралтын шалтгааныг заавал сумын эрүүл мэндийн төвийн их эмчээр хянуулна. Нас баралтын үндсэн шалтгааныг тогтоохдоо нас барагчийг урьд нь эмчилж байсан эмнэлэг, өрхийн эмчийн хяналтыг үндэслэж эсвэл задлан шинжилгээ хийсний үндсэн дээр бичнэ. Аймаг хотын болон сумын эрүүл мэндийн төвд хэвтэж эмчлэгдэж байгаад нас барагсад гадны шалтгаанаар нас барсан байж болох сэжигтэй бүх тохиолдолд заавал задлан шинжилгээ хийсний үндсэн дээр уг гэрчилгээг бичнэ. Гадны шалтгаант нас баралтын үндсэн оношийг ӨОУА 10-ын ХХ бүлгээр кодлоно. Гэрчилгээг бөглөхдөө асуултын дагуух харалдаа хэсэгт байгаа шифрийг чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Эмчийн зурж тэмдэглэсэн шифрийг шууд компьютерт оруулж шивнэ.

Хорт хавдар болон ХДХВ/ДОХ-ын шалтгаанаар нас барсан тохиолдолд оношилогдсноос хойш амьдарсан хугацааг жил, сар, хоногоор тооцож бичнэ.

### **Нас баралтын шалтгаан**

Дэлхийн эрүүл мэндийн байгууллаас нас баралтын гэрчилгээнд бичигдэх нас баралтын шалтгааныг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

“үхэлд хүргэсэн эсвэл үхэлд хүрэхэд нь дэмжлэг үзүүлсэн бүх л өвчин, эмгэг, гэмтэл ба энэ гэмтлийг бий болгосон ослын нөхцөл байдал, хүчирхийллийг бүгдийг оруулна” гэж заасан. Энэ тодорхойлолтын зорилго нь холбогдох бүх мэдээллийг нь тайланд оруулах явдал бөгөөд гэрчилгээ олгож байгаа эмч зарим шалтгааныг нь хасах эсвэл сонголт хийх ёсгүй. Зүрхний эсвэл амьсгалын дутагдал гэх мэтээр нас баралтын шалтгааныг тодорхойлохгүй.

## **Нас баралтын үндсэн шалтгааныг тэмдэглэх**

Нас баралтын гол шалтгааныг дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:

“а) нас баралтад хүргэсэн эмгэг нөхцөл байдлыг үүсгэсэн өвчин эсвэл гэмтэл, эсвэл б) маш хүнд үхлийн гэмтэл үүсгэсэн осол эсвэл хүчирхийллийн нөхцөл байдал” гэж тодорхойлсон.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын чуулганаас дээрх зарчмуудыг улс орнуудад хэрэглэхийг зөвлөсөн. Эмч, эмнэлгийн ажилтны үүрэг бол нас барсан тухай гэрчилгээ бичихдээ үхэлд шууд хүргэсэн эмгэг нөхцөл байдал ба энэ шалтгааныг үүсэхэд нь нөлөөлсөн өмнөх нөхцөл байдлуудыг нь оруулах явдал юм.

Нас барсан тухай гэрчилгээ нь 2 ба түүнээс олон шалтгаан бичигдсэн тохиолдолд гол шалтгааныг нь сонгох үйл явцад дэмжлэг үзүүлэх зорилготойгоор загварчлагдсан. Энэ гэрчилгээний 1-р хэсэг нь үхэлд шууд хүргэсэн эмгэг нөхцөл байдлуудыг, 2-р хэсэг нь шууд холбоогүй боловч дэмжлэг үзүүлсэн нөхцлүүдийг харуулна.

Зарим тохиолдолд ӨОУА нь хүснэгтэн мэдээлэлд бичигдэх гол шалтгааныг илэрхийлэхдээ урьдал шалтгааныг хавсруулах боломжийг олгодог. Жишээ нь нийлмэл тохиолдлыг илэрхийлэх эсвэл гэрчилгээнд бичигдсэнээс өөр илүү чухал ач холбогдолтой тархвар зүйн шалтгаан байж болно.

Тийм учраас дараагийн алхам бол дээрх тохиолдолд дараах дүрмүүдийг баримтлана.

Урьдал шалтгаан нь осол гэмтэл эсвэл 19-р бүлэгт ангилагдсан гадаад шалтгаан байвал тухайн байдлыг үүсгэсэн нөхцлийг хүснэгтэн мэдээлэлд бичиж оруулах нас баралтын гол шалтгаан гэж үзэн V01-Y89 хүртэлх кодоос сонгон кодлоно. Тухайн гэмтэл эсвэл гадаад шалтгааны кодыг нэмэлтээр авч болно.

### ***Дүрэм А***

#### ***Зөнөгрөл ба бусад тодорхойгүй нөхцөл байдал***

Сонгосон шалтгаан нь тодорхойгүй нөхцөл байдал байх ба гэрчилгээнд өөр төрлийн ангилагдсан шалтгаан бүртгэгдсэн байвал нас баралтын шалтгааныг дахин сонгоно. Дахин сонголт хийхдээ тодорхойгүй нөхцөл байдал нь кодлоход нөлөө үзүүлэхгүй л бол түүнийг гэрчилгээнд бичигдээгүй байсан мэтээр үзнэ.

Дараах нөхцөл байдлуудыг тодорхойгүй гэж үзнэ. Үүнд: I46.9 буюу тодорхойгүй шалтгаанаар зүрх зогсох, I95.9 буюу шалтгаан нь тодорхойгүй даралт багасах, I99 буюу цусны эргэлтийн тогтолцооны бусад ба тодорхойгүй эмгэг, J96.0 буюу амьсгалын цочмог дутмагшил, J96.9 буюу шалтгаан нь тодорхойгүй амьсгалын дутмагшил, P28.5 буюу нярайн амьсгалын дутмагшил, R00-R94 ба R96-R99 буюу өөр бүлэгт ангилаагүй шинж тэмдэг, зовиур, эмнэлзүйн ба лабораторийн хэвийн бус үзүүлэлтүүд орно. R95 буюу нярай гэнэт эндэх хамшинжийг эмгэг гэж тодорхойлсон нөхцөл байдалд хамааруулж үзэхгүй.

### ***Дүрэм В***

#### ***Ач холбогдол багатай нөхцөл байдал***

Нас баралтын шалтгаан гэж сонгосон нөхцөл байдал нь тиймч ач холбогдолтой бус харин түүнээс илүү хэмжээгээр үхэлд нөлөөлсөн нөхцөл байдал гэрчилгээнд бичигдсэн бол сонголтыг дахин хийнэ. Дахин сонголт хийхдээ ач холбогдол багатай нөхцөл байдал нь гэрчилгээнд тэмдэглэгдээгүй байсан мэтээр үзнэ. Хэрэв үхэл нь ач холбогдол багатай нөхцөл

байдлыг эмчлэх эмчилгээний сөрөг үр дагавраас шалтгаалсан байвал үр дагаврыг нь шалтгаан гэж үзнэ

### ***Дүрэм С Холбоос***

Нас баралтын сонгосон шалтгаан нь гэрчилгээнд бичигдсэн нэг ба олон нөхцөл байдалтай холбогдож байвал хооронд нь холбож кодлоно. Холбож кодлохдоо өөр нөхцөл байдлаас шалтгаалан үүссэн нэг л нөхцөл байдлыг авч үзэх бөгөөд учир шалтгааны холбоосыг зөв олсон байх хэрэгтэй. Холбоос хийхэд зөрчилтэй асуудал гарч ирвэл анхны сонгосон шалтгааныг гэрчилгээнд бичигдээгүй байсан мэтээр үзэж, сонголтыг хийнэ. Боломжтой бол нэгээс олон холбоос хийж болно.

### ***Дүрэм D Өвөрмөц байдал***

Нас баралтын шалтгаан гэж сонгосон нөхцөл нь ерөнхий нэр томъёогоор илэрхийлэгдсэн бөгөөд гэрчилгээнд энэ нөхцөл байдлыг илүү нарийн тодорхойлсон нэр томъёо бичигдсэн байвал илүү мэдээлэл өгөх нэр томъёо нь сонгож авна. Ерөнхий нэр томъёо нь тэмдэг нэр байх тохиолдолд энэ дүрмийг ихэвчлэн хэрэглэдэг.

### ***Дүрэм E Өвчний эрт ба төгсгөлийн шат***

Нас баралтын сонгосон шалтгаан нь өвчний эрт үеийг илэрхийлж байгаад гэрчилгээнд түүнээс дараа үе шатны тухай нэр томъёо бичигдсэн байвал хамгийн сүүлийн үе шатаар нь шалтгааныг сонгож авна. Ямар нэгэн өвөрмөц заавар өгөөгүй тохиолдолд “цочмог” хэлбэрээс болсон “архаг” нөхцөл байдлыг шалтгаан гэж сонгож авахгүй.

### ***Дүрэм F Үр дагаврын категорууд***

Нас баралтын шалтгаан гэж сонгосон шалтгаан нь ямар нэгэн өвчний үр дагаврын категорийн эхний нөхцөл байдал байгаад үхэл нь энэ үр дагаврын категоруудад байгаа бусад нөхцөл байдлаас улбаалсан бол үр дагаврын категорийн дугаараар кодлоно.

Дараах категорууд нь үр дагаврын категорууд юм: B90-B94, E64.-, E68, G09, I69.-, O97, T90-T98, Y85-Y89

### ***Эрүүл мэндийн маягт AM-8- Эмнэлгийн магадлагаа бүртгэлийн маягтыг хөтлөх заавар***

Эмнэлгийн магадлагаа маягтыг амбулаторийн эмчлэгч эмч олгоно. Тогтмол хаяг, ажлын газар, албан тушаал, мэргэжлийг загвар маягтын дагуу бичиж тэмдэглэнэ. Эмчлэгч эмч магадлагаа олгох болсон шалтгааныг тодруулж /өвчтэй байсан, өвчтөн асрамжилсан, хөл хоригдсон, хичээлээс биеийн эрүүл мэндийн байдлаас чөлөөлөгдөх/ магадлагааг ерөнхий эмчээр баталгаажуулж олгоно. Сунгалтыг 3 өдрөөр 3 удаа олгох ба энэ тохиолдолд эмчлэгч эмч тэмдэг, гарын үсгээр баталгаажуулна.

### ***Эрүүл мэндийн маягт AM-9A, 9B- Эмийн жорын бүртгэлийн маягтыг хөтлөх заавар***

Эмийн жорыг Монгол улсын Стандартчилал, Хэмжил зүйн үндсэний төвөөс баталсан “Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376;2004 стандартанд заасны дагуу бичнэ.

Үүнд:

1. Энгийн эмийн жор 100\*160мм хэмжээтэй хэвлэмэл маягт дээр бичнэ.
2. Мансууруулах эмийн жорын хэвлэмэл маягтыг нэгдсэн дугаартайгаар хэвлэж, төрийн захиргааны холбогдох төв байгууллага тэмдэг дарж баталгаажуулсан байна.
3. Мансууруулах эмийн жорын маягтыг жор бичих дүрмийг баримтална.

### ***Өвчтөн илгээх хуудас эрүүл мэндийн маягт АМ-13 А***

13А- маягтыг өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч дараагийн шатлалд шилжүүлэх шаардлагатай хүмүүст олгоно.

Ажлын газар, албан тушаал, мэргэжлийг шифрлэхдээ салбарын үндсэн ангилалын дагуу шифрлэнэ.

Дараагийн шатлалд эмнэлэгт явуулж буй үндэслэлд онош тодруулах болон эмчилгээ хийлгэх шаардлагатай эсэхээ тэмдэглэж, анхдагч шатлалд хийгдсэн эмчилгээ, шинжилгээг амбулаторийн маягтанд дэлгэрэнгүй бичнэ.

13Б-маягтыг эмчлүүлсэн газраас эмнэлэгээс өвчтөн илгээх тохиолдолд олгоно. Хийлгэсэн эмчилгээ, шинжилгээг амбулаторийн маягтанд хавсаргаж явуулна. Бүртгэлийн код нь Эрүүл мэндийн бүртгэлийн маягт АМ-13А маягтын бүртгэлийн кодтой адил байна.

### ***Эрүүл мэндийн маягт АМ-14- Жирэмсэн эмэгтэйчүүдийн бүртгэлийг хөтлөх заавар***

Уг маягтыг өрхийн болон эмэгтэйчүүдийн хяналтын эмч жирэмсэн эмэгтэйд хөтөлнө. Жирэмсэн эмэгтэй хяналтанд орсон өдрөөс эхлэн жирэмслэлт төгсөж тайланд тусгагдсаны дараа хаагдаж, архивлагдана. АМ-14 маягтыг үндэслэн ЭМТ101.8-10 тайлан гарна.

Жирэмсний хугацаа гэсэн хэсэгт хэрэв шилжиж ирсэн бол тухайн өрхийн эмчийн хяналтанд орох үеийн анхны жирэмсний хугацааг тавина.

Сүүлийн биений юмны хугацаагаар төрөх хугацааг тооцож тавина. Өмнөх төрөлтийн тухай мэдээлэл болон хяналтаас гарсан тухай мэдээллийг эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ӨЭ-1 маягтан дээр байгаа мэдээллээр бүртгэнэ.

***Эрүүл мэндийн маягт АМ-15- Жирэмсэн эмэгтэйн хяналтын хөтөч маягтыг хяналтын эмч болон эх баригч бага эмч хөтлөнө.***

### ***Эрүүл мэндийн маягт АМ-16- Солилцох хуудас бүртгэлийг маягтыг хөтлөх заавар***

Өрхийн эмч, эмэгтэйчүүдийн хяналтын эмч жирэмсний 33-34 долоо хоног тээсэн жирэмсэн эхэд олгоно. Солилцох хуудсанд байгаа жирэмслэлттэй холбоотой мэдээллийг эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ӨЭ-1 маягтаас хуулж авах ба тус маягттай хавсаргаж явуулна.

Уг маягтын А хэсэгт эхийн тухай тодорхой хариулж бичээд, А хэсгийн ар талд шинжилгээний хариу гэсэн хэсэгт жирэмсэн эмэгтэй хяналтанд байх хугацаанд хийсэн шинжилгээ болон биед гарсан өөрчлөлт эмгэгийг бичиж тэмдэглэнэ.

Маягтын Б хэсэгт төрөх тасагт хийгдсэн бүх зүйлийг асуултын дагуу хариулж бичээд төрсөн эхэд өгч гаргах ба өрхийн эмч (хяналтын) хүлээн авч төрсний дараах амралтыг тооцож, уг эмэгтэйн цаашдын жирэмслэлтийг төлөвлөн картанд хавсарган хадгална.

Жирэмсэн эх, солилцох хуудасны А хэсгийг төрөх үедээ харъяаллын төрөх газар авч ирнэ.

Эмнэлгийн ажилтан, жирэмсэн эхийг төрөхөөр ирэх үед солилцох хуудасны А хэсгийг төрөлтийн түүхэнд нааж хавсаргах ба эхийг төрөөд гарах үед маягтын А хэсэг төрөлтийн түүхэнд үлдэнэ.

Маягтын Б хэсэгт төрөх тасагт хийгдсэн бүх зүйлийг асуултын дагуу хариулж бичээд төрсөн эхэд өгч гаргах ба өрхийн эмч (хяналтын) хүлээн авч төрсний дараах амралтыг тооцож, уг эмэгтэйн цаашдын жирэмслэлтийг төлөвлөн картанд хавсарган хадгална.

**Эрүүл мэндийн маягт АМ-17- Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлийг мэдээлэх маягтыг хөтлөх заавар**

**Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлийг мэдээлэх маягт бөглөх зааварчилгаа**

Асуумж	Аргачлал-Тодорхойлолт - Жишээ										
<i>Ерөнхий асуулга</i>	Ерөнхий асуулгын зорилго нь эхийн талаарх ерөнхий мэдээллийг үнэн зөв, бодитой цуглуулахад оршино.										
<i>Асуулт 1-2: Эхийн нэр</i>	Эхийн иргэний бүртгэлээс баталгаажсан иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээг үндэслэн овог, нэрийг тод гаргацтай, татлахгүй, үнэн, зөв бичнэ.										
<i>Асуулт 3: Регистрийн дугаар</i>	Эхийн регистрийн дугаарыг бөглөхдөө өвчтний иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ. Регистрийн дугаар гэсэн 10 нүд бүхий хүснэгтийн эхний 2 нүдэнд үсгийг том үсгээр, сүүлийн 8 нүдэнд цифрийг тус бүрт гаргацтай бичнэ. <i>Жишээ: Эхийн регистрийн дугаар</i> <table border="1" data-bbox="600 1312 1169 1354"> <tr> <td>А</td><td>Н</td><td>8</td><td>6</td><td>0</td><td>2</td><td>2</td><td>4</td><td>6</td><td>5</td> </tr> </table>	А	Н	8	6	0	2	2	4	6	5
А	Н	8	6	0	2	2	4	6	5		
<i>Асуулт 4: Байнгын оршин суудаг хаяг</i>	Эхийн иргэний үнэмлэхийг үндэслэн аймаг/хот, сум/дүүрэг, баг/хороо зэргийг гаргацтай бичнэ.										
<b>Эхийн эрүүл мэндийн асуулга</b>											
<i>Асуулт 1: Эхийн жирэмсэн, төрөх, төрсний дараах үе</i>	Жишээ: Эхийн <u>жирэмсэн</u> , төрөх, төрсний дараах үед эх хүндэрсэн эсвэл эндсэн эсэхийн аль болохыг сонгож дугуйлна. Эхийн хүндэрсэн болон эндсэн үеийг тодруулахдаа (жирэмсэн, төрөх, төрсний дараах) 1, 44, 45-р асуултууд хоорондоо утгын уялдаатай бөглөгдөхийг анхаарна уу.										
<i>Асуулт 2: Эхийн хүндэрсэн, эндсэн газар</i>	Эх хаана хүндэрсэн эсвэл эндсэн болохыг сонгоно. Сонгосон асуултад хариулагдахгүй бол 2.5-ыг дугуйлан, хүндэрсэн эсвэл эндсэн газрыг тодорхой бичнэ.										
<i>Асуулт 3: Эхийн нас</i>	Нас гэсэн 2 нүд бүхий хүснэгтэд эхийн төрсөн он, сарыг үндэслэн насыг тооцоолж бүтэн насаар бичнэ. Жишээ: 21 настай эх бол Нас <u>21</u> гэж бичнэ.										

Асуулт 4: Ам бүл	Ам бүлийн тоог эхийн жирэмсний хяналтын карт, өвчний түүх, төрөлтийн түүхийн паспортын хэсгээс харж үнэн зөв бөглөнө. Жишээ: 3 ам бүлтэй бол <u>3</u> гэж бичнэ.
Асуулт 5: Гэр бүлийн байдал	Маягтын кодыг ашиглан гэрлэлтийн байдлыг тэмдэглэнэ. Гэрлэсэн/тусдаа гэдэгт гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй тусдаа амьдарч байгаа хүмүүсийг оруулна. Гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч иргэний бүртгэл мэдээллийн төвд бүртгүүлж гэр бүлээ батлуулаагүй хүмүүсийг хамтран амьдрагч гэж кодлоно. Тодорхойгүй гэх хариултыг эхийн ар гэрийн байдлын талаар мэдээлэл авах боломжгүй үед сонгоно.
Асуулт 6: Эхийн боловсрол	Боловсролын түвшинг асуултын кодыг ашиглан тэмдэглэнэ. Боловсролгүй гэдэгт эх ямар нэгэн сургууль төгсөөгүй буюу сургуульд ороогүйг хамааруулна. Тодорхойгүй гэдэг сонголтыг тухайн эхийн боловсролын талаар мэдээлэл авах боломжгүй үед хэрэглэнэ.
Асуулт 7: Нийгмийн байдал	Нийгмийн байдлыг сонгохдоо тохирох хариултын доогуур зурна, дээрх хариултын алинд нь ч орохгүй бол бусад гэсэн хариултын доогуур зурж, тодорхой бичнэ үү.
Асуулт 8: Эхийн эмнэлэгт хэвтсэн хугацаа он, сар, өдөр, цаг, минут	Эхийн эмнэлэгт хэвтсэн хугацааг он, сар, өдөр, цаг, минутаар нь бичнэ. Үүнийг эхийн өвчний түүх, төрөлтийн түүхээс авч тэмдэглэнэ. Жишээ: 2014 оны 1 сарын 5-ны 22 цаг 8 минут гэж бичнэ.
Асуулт 9: Эхийн эмнэлэгт хэвтэх үеийн биеийн байдал	Эхийн эмнэлэгт хэвтэх үеийн биеийн байдалд тохирох хариултын доогуур зурна. Эмэгтэй нь эмч очиход эндсэн эсвэл биеийн байдлыг үнэлэх боломжгүй тохиолдол гарвал бусад гэсэн сонголтыг зурж, хариултыг тодорхой бичнэ.
Асуулт 10: Эмнэлэгт хэвтэх үеийн онош	Эмнэлэгт хэвтэх үеийн оношийг хүлээн авсан эмчийн урьдчилсан оношоор (үндсэн онош, хүндрэл, дагалдах онош) бичнэ. Оношийг гаргацтай бичих ба ӨОУА-10 гэдгийн ард оношийн кодыг бичиж өгнө.
Асуулт 11-13: Эхийн жин, өндөр, цусны даралт	Эхийг хүлээн авсан эмчийн анхны үзлэгийн биеийн жин, өндөр, цусны даралт, судасны цохилтын тоог бичиж тэмдэглэнэ.
Асуулт 14: Хийгдсэн шинжилгээ	Эмнэлэгт хэвтэх үед доорх шинжилгээ хийгдсэн бол тийм-1, хийгдээгүй бол үгүй-2 гэсэн хариултыг дугуйлна. Дээрх шинжилгээнээс өөр шинжилгээ хийгдсэн байвал бусад гэсэн хэсэгт дэлгэрэнгүй бичиж тэмдэглэнэ.
Асуулт 15: Жирэмслэлтийн тоо	Жирэмслэлтийн тоог бөглөхдөө жирэмсний хяналтын хөтчөөс харж, одоогийн жирэмслэлтийг оролцуулан нийт жирэмслэлтийн тоог бичнэ.
Асуулт 16: Өмнөх төрөлтийн тоо	Өмнөх төрөлтийн тоонд одоогийн жирэмсний төгсгөлийг оруулахгүйгээр нийт хэдэн удаа төрж байсан тоог бичнэ. Ихэр бол нэг төрөлтөнд тооцно. Жирэмсний хяналтын хөтчөөс харж тэмдэглэнэ.

<p>Асуулт 17: Өмнөх жирэмслэлт хэдэн онд байсан бэ?</p>	<p>Энэ жирэмслэлтээс өмнө хэдэн онд жирэмсэлсэн болохыг бичнэ.</p>
<p>Асуулт 18: Өмнөх жирэмсний төгсгөл</p>	<p>Өмнөх жирэмсний төгсгөлийг сонгон дугуйлна.</p>
<p>Асуулт 19: Өмнөх жирэмсэн, төрөлт, төрсний дараа болон үр хөндөлттэй холбоотой ямар нэгэн хүндрэл байсан уу?</p>	<p>Өмнөх жирэмсэн, төрөлт, төрсний дараах болон үр хөндөлттэй холбоотой ямар нэгэн хүндрэл байсан бол тийм-1, байгаагүй бол үгүй-2 гэж тэмдэглэнэ.</p>
<p>Асуулт 20: Жирэмсний хяналтанд орсон эсэх</p>	<p>Жирэмсний хяналтанд орсон бол тийм-1, ороогүй бол үгүй-2 гэж тэмдэглэнэ. Түүнчлэн, жирэмсний хяналтанд орсон бол 21-р асуултанд хариулж, цааш үргэлжлүүлэн хариулах ба жирэмсний хяналтанд ороогүй бол 26-р асуулт руу шилжиж, хариулна.</p>
<p>Асуулт 21: Жирэмсний хяналтанд анх орсон хугацаа</p>	<p>Жирэмсний хяналтанд анх орсон хугацааг долоо хоногоор тооцож тэмдэглэнэ. Жишээ: 8 долоо хоногтой хяналтанд орсон бол 8 гэж тэмдэглэнэ.</p>
<p>Асуулт 22: Нийт хэдэн удаа үзүүлсэн</p>	<p>Жирэмсний хяналтанд нийт хэдэн удаа үзүүлсэн тоог бичнэ. Жишээ: 6 удаа хяналтандаа үзүүлсэн бол 6 гэж тэмдэглэнэ.</p>
<p>Асуулт 23: Жирэмсний хяналтанд байсан газар</p>	<p>Жирэмсний хяналтанд байсан газрыг кодын дагуу сонгоно.</p>
<p>Асуулт 24: Жирэмсний хяналтын эмчийн мэргэжлийн түвшин</p>	<p>Жирэмсний хяналтын эмчийн мэргэжлийн түвшинг кодын дагуу сонгоно.</p>
<p>Асуулт 25: Жирэмсэн үед жирэмсэн, төрөлт, төрсний дараах үеийн тухай эрүүл мэндийн хичээл сургалтанд оролцсон эсэх</p>	<p>Жирэмсэн үед жирэмсэн, төрөлт, төрсний дараах үеийн тухай эрүүл мэндийн хичээл сургалтанд оролцсон бол тийм-1, оролцоогүй бол үгүй-2 гэж тэмдэглэнэ.</p>
<p>Асуулт 26: Энэ жирэмсний үе дэх хавсарсан өвчин</p>	<p>Эхэд жирэмсэнтэй хавсарсан эрхтэн тогтолцооны эмгэг байвал тохирох хариултын кодыг сонгоно. Нэгээс олон хариулт сонгож болно. Эхэд тохиолдсон эрхтэн тогтолцооны эмгэг дээрх хариултад тохирохгүй байвал бусад гэсэн хариултыг сонгоод, эмгэгийн нэрийг тодорхой бичнэ. Мөн халдварт ба шимэгчит зарим өвчин гэсэн хариултыг сонгосон бол тодорхой бичнэ.</p>
<p>Асуулт 27: Одоогийн жирэмсний хүндрэл</p>	<p>Одоогийн жирэмсний явцад тохиолдсон хүндрэлийг тохирох хариултын кодоос сонгоно. Нэгээс олон хариулт сонгож болно. Эхэд тохиолдсон жирэмсний хүндрэл дээрх хариултад тохирохгүй байвал бусад гэсэн хариултыг сонгоод, хүндрэлийг тодорхой бичнэ.</p>

<p><i>Асуулт 28: Жирэмсэн үед тусламж үзүүлсэн газар</i></p>	<p>Эхэд жирэмсэн үед тусламж үзүүлсэн газрыг өгөгдсөн кодоос сонгож тэмдэглэнэ. Эхийн жирэмсний хугацаанаас үл харгалзан эх хүндэрч эмнэлэгт хэвтэн эмчлэгдэхэд түүний төрөх хугацаа болоогүй тохиолдолд 28-р асуулт дангаараа, төрсөн бол 29-р асуулт давхар бөглөгдөнө.</p>
<p><i>Асуулт 29: Эхэд төрөлтийн тусламж үзүүлсэн газар</i></p>	<p>Эхэд төрөлтийн тусламж үзүүлсэн газрыг өгөгдсөн кодоос сонгож тэмдэглэнэ. Дээрх хариултад тохирохгүй байвал бусад гэсэн хариултыг сонгоод, тодорхой бичнэ.</p>
<p><i>Асуулт 30: Төрөлт удирдсан хүн</i></p>	<p>Эхийг төрөх үед төрөлтийг удирдаж төрүүлсэн хүнийг кодын дагуу сонгож тэмдэглэнэ.</p>
<p><i>Асуулт 31: Эхийн жирэмсний хугацаа (долоо хоногоор)</i></p>	<p>Эхийн биеийн байдал хүндрэх, нас барах үеийн жирэмсний хугацаа эсвэл төрөх, үр хөндүүлэх үеийн жирэмсний хугацааг долоо хоногоор бичнэ.</p>
<p><i>Асуулт 32: Одоогийн жирэмсний төгсгөл</i></p>	<p>Эхийн одоогийн жирэмсний төгсгөлийг өгөгдсөн кодоос сонгоно. Хэрэв эх төрөөгүй бол шалтгааныг дэлгэрэнгүй бичнэ.</p>
<p><i>Асуулт 33: Төрсөн, үр хөндүүлсэн, зулбасан, мэс засал хийлгэсэн өдөр</i></p>	<p>Эхийн төрсөн, үр хөндүүлсэн, зулбасан, мэс засал хийлгэсэн эсэхийг доогуур нь зурж, он, сар, өдрийг бичнэ. Жишээ: Эх 2014 оны 3 сарын 16-нд төрсөн бол <u>Төрсөн</u>, үр хөндүүлсэн, зулбасан, мэс засал хийлгэсэн: <u>2014 он 03 сар 16 өдөр</u> гэж тэмдэглэнэ.</p>
<p><i>Асуулт 34: Төрөлтийн хэлбэр</i></p>	<p>Төрөлтийн хэлбэрийг хариултын дагуу кодлож тэмдэглэнэ.</p>
<p><i>Асуулт 35: Умай агшаах тариа хэрэглэсэн эсэх</i></p>	<p>Эхийг төрөх үед умай агшаах тариа хэрэглэсэн бол <i>тийм-1</i>, хэрэглээгүй бол <i>үгүй-2</i> гэж тэмдэглээд 37-р асуулт руу шилжинэ.</p>
<p><i>Асуулт 36: Төрөлтийн үед умай агшаах тариаг хэзээ хэрэглэсэн</i></p>	<p>Умай агшаах тариаг төрөлтийн хэд дүгээр үед хэрэглэснийг өгөгдсөн кодыг ашиглан тэмдэглэнэ. Олон хариулт сонгож болно.</p>
<p><i>Асуулт 37: Үр хөндөлтийн хэлбэр</i></p>	<p>Үр хөндөлтийн хэлбэрийг хариултын дагуу кодлож тэмдэглэнэ.</p>
<p><i>Асуулт 38: Мэс засал хийгдсэн эсэх</i></p>	<p>Эхэд мэс засал хийгдсэн бол <i>тийм-1</i>, хийгдээгүй бол <i>үгүй-2</i> кодыг сонгоно. Хэрэв эхэд мэс засал хийгдээгүй бол 41-р асуултаас эхлэн хариулна.</p>
<p><i>Асуулт 39: Мэс засал хийх болсон заалт</i></p>	<p>Эхэд мэс засал хийгдсэн бол мэс заслын заалтыг кодоос сонгож тэмдэглэнэ. Кодолсоноос бусад заалтаар эхэд мэс засал хийгдсэн байвал бусад гэсэн хариултыг сонгож, заалтыг дэлгэрэнгүй бичнэ.</p>
<p><i>Асуулт 40: Төрөх үеийн мэс ажилбар, мэс заслын тусламж</i></p>	<p>Эхийг төрөх үед мэс ажилбар, мэс засал хийгдсэн бол кодоос сонгож тэмдэглэнэ. Хэрэв жагсаалтанд байхгүй мэс ажилбар, мэс засал хийгдсэн бол бусад гэсэн кодыг сонгон хариултыг дэлгэрэнгүй бичнэ.</p>
<p><i>Асуулт 41: Эх цус алдсан эсэх</i></p>	<p>Эх цус алдсан бол <i>тийм-1</i>, цус алдаагүй бол <i>үгүй-2</i> кодыг сонгоно. Тийм хариултыг сонгосон бол 42, 43-р асуултыг бөглөнө. Үгүй хариултыг сонгосон бол 44-р асуулт руу шилжинэ.</p>

<p>Асуулт 42-43: Алдсан, юүлсэн цусны хэмжээ (мл-р)</p>	<p>Эх цус алдсан бол алдсан болон сэлбэсэн цусны хэмжээг мл-ээр бичнэ. Жишээ: 1800 мл цус алдсан, 1200 мл цус юүлсэн бол Алдсан цусны хэмжээ (мл-р): <u>1800 мл</u>. Юүлсэн цусны хэмжээ (мл-р): <u>1200 мл</u> гэж тэмдэглэнэ.</p>
<p>Асуулт 44: Эхийн ноцтой хүндэрсэн, эндсэн үе</p>	<p>Эхийн ноцтой хүндэрсэн, эндсэн үеийн талаарх мэдээг код ашиглан хариулна. Хэрэв хариултад тохирохгүй бол бусад гэсэн хариултыг сонгож, тодорхой бичнэ.</p>
<p>Асуулт 45: Төрөх, төрсний дараах үеийн хүндрэл</p>	<p>Төрөх, төрсний дараах үеийн хүндрэл тохиолдвол хариултыг кодоос сонгож тэмдэглэнэ. Хэрэв жагсааснаас бусад хүндрэл тохиолдвол бусад гэсэн кодыг сонгож, хүндрэлийг нэрлэж бичнэ.</p>
<p>Асуулт 46: Цус алдалтын шалтгаан</p>	<p>Эхэд цус алдах хүндрэл тохиолдсон бол цус алдсан шалтгааныг тодруулах зорилгоор тохирох хариултын кодыг сонгоно. Хэрэв хариултад тохирохгүй бол бусад гэсэн хариултыг сонгож цус алдалтын шалтгааныг тодорхой бичнэ.</p>
<p>Асуулт 47: Халдвар</p>	<p>Эхэд халдварын хүндрэл тохиолдсон бол халдварын шалтгааныг тодруулах зорилгоор тохирох хариултын кодыг сонгоно. Хэрэв хариултад тохирохгүй бол бусад гэсэн хариултыг сонгож халдварын шалтгааныг тодорхой бичнэ.</p>
<p>Асуулт 48: Эх хүндэрсэн тохиолдолд ямар нэгэн эрхтэн системийн үйл ажиллагааны алдагдал байсан эсэх</p>	<p>Эхэд ямар нэгэн эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны алдагдал байсан бол тийм-1, байгаагүй бол үгүй-2 гэсэн кодыг сонгоно. Тийм гэсэн хариулт сонгосон бол 49-р асуултаас эхлэн цааш хариулна. Үгүй гэж хариулсан бол 56-р асуултаас эхлэн хариулна.</p>
<p>Асуулт 49-55: Эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны алдагдал</p>	<p>Эхэд ямар нэгэн эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны алдагдал байсан бол хариултад тохирох кодыг сонгоно уу.</p>
<p>Асуулт 56: Клиникийн төгсгөлийн онош (үндсэн онош, хүндрэл, дагалдах онош)</p>	<p>Клиникийн төгсгөлийн оношийг (үндсэн онош, хүндрэл, дагалдах онош) дэлгэрэнгүй бичиж оруулахаас гадна ӨОУА-10-аар кодлож бичнэ.</p>
<p>Асуулт 57: Эмнэлгээс гарсан, шилжсэн, нас барсан</p>	<p>Эх эмнэлгээс гарсан, шилжсэн, нас барсан тухай зохих хариултын доогуур зурна. Шилжсэн гэж зурсан бол 58-р асуултанд хариулна.</p>
<p>Асуулт 58: Эмэгтэй дээд шатлалын аль нэг эмнэлэгт шилжсэн</p>	<p>Тухайн эмнэлэгт хүндэрсэн эхийг дээд шатлалын эмнэлэг рүү шилжүүлсэн бол тийм-1, шилжүүлээгүй бол үгүй-2 гэж тэмдэглэнэ.</p>
<p>Асуулт 59: Эмнэлгээс гарсан, шилжсэн эсвэл нас барсан бол хугацааг он, сар, өдөр, цаг, минутаар бичнэ</p>	<p>Эх 2013 оны 2 сарын 13-ны 14 цаг 20 минутад эмнэлгээс гарсан бол... Эмнэлгээс <u>гарсан</u>, шилжсэн, нас барсан <u>2013 он 02 сар 13 өдөр 14 цаг 20 минут</u> гэж тэмдэглэнэ.</p>
<p>Асуулт 60: Ор хоног</p>	<p>Эх эмнэлгээс гарах, шилжих, нас барах үеийн хугацааг буюу ор хоногийг хоног, цаг, минутаар нь бичнэ. Жишээ: <u>Ор хоног: 2 хоног 6 цаг 00 минут</u> гэж тэмдэглэнэ.</p>

Асуулт 61: Эмгэг анатомийн шинжилгээнд орсон эсэх	Эх эндэж эмгэг анатомийн шинжилгээнд <i>орсон бол орсон-1, ороогүй бол ороогүй-2</i> гэж хариулаад 65-р асуулт руу шилжинэ.
Асуулт 62: Эмгэг судлалын шинжилгээний онош (үндсэн онош, хүндрэл, дагалдах онош)	Эмгэг судлалын шинжилгээний оношийг (үндсэн онош, хүндрэл, дагалдах онош) дэлгэрэнгүй бичиж оруулахаас гадна ӨОУА-10-аар кодлож бичнэ.
Асуулт 63: Онош тохирсон эсэх	Клиникийн онош нь эмгэг судлалын шинжилгээний оноштой тохирсон эсэхийг код ашиглан сонгож тэмдэглэнэ.
Асуулт 64: Тохироогүй бол	Онош тохироогүй бол зөрсөн оношийн төрлөөр сонголт хийнэ.
Асуулт 65: Эх барихын шалтгаантай эсэх	Эхийн ноцтой хүндрэл, эхийн эндэгдэл <i>эх барихын шууд шалтгаантай бол тийм-1, шууд бус шалтгаантай бол үгүй-2</i> гэж тэмдэглэнэ.
Асуулт 66: Хожимдол (сонгоно уу)	Эх ноцтой хүндэрсэн эсвэл эндсэн үед хожимдол байсан бол 1, 2, 3-р хожимдлуудын дугаараас сонгон тэмдэглэгээг хийнэ. Нэг эхэд хэдэн ч хожимдол тохиолдсон байж болно.
Асуулт 67: Нярайн хүйс	Нярайн хүйсийг мэдээлэхдээ <i>хүү бол-1, охин бол-2</i> гэсэн кодыг сонгоно.
Асуулт 68: Биеийн жин.....гр, өндөр.....см	Нярайг үзсэн эмчийн анхны үзлэгийн биеийн жин, өндрийн хэмжээг бичиж тэмдэглэнэ.
Асуулт 69: Нярайн байдал: амьд, амьгүй, нас барсан (зур)	Нярайн төрөх үеийн байдлыг (амьд, амьгүй, амьд төрөөд нас барсан) тохирох хариултын доогуур зурна.
Асуулт 70: Апгарын үнэлгээ	Амьд төрсөн нярайд Апгарын оноог төрсний дараах 1 минутын байдлаар тэмдэглэнэ.
Асуулт 71: 5 минутын дараах Апгарын үнэлгээ	Амьд төрсөн нярайд Апгарын оноог төрсний дараах 5 минутын байдлаар тэмдэглэнэ.
Асуулт 72: Гэрийн төрөлт бол	Эх гэртээ төрсөн бол эмч дуудсан хугацаа, төрсөн хугацаа, төрөөд эмнэлэгт хэвтүүлсэн хугацаа, эмч очсон хугацаа зэргийг он, сар, өдөр, цаг, минутаар бичнэ.
Мэдээлсэн: Мэдээлсэн огноо Аймаг/хот Сум/дүүргийн Эмнэлгийн нэр Эмчийн нэр Албан тушаал	<u>2014</u> он <u>04</u> сар <u>03</u> өдөр <u>12</u> цаг <u>20</u> минут <u>Аймаг/хот</u> : <u>Баян-Өлгий</u> <u>Сум/дүүрэг</u> : <u>Цэнгэл</u> Эмнэлгийн нэр: <u>Цэнгэл сумын эмнэлэг</u> Эмчийн нэр: <u>Д.Наран</u> Албан тушаал: <u>Эх барих эмэгтэйчүүдийн эмч</u>

### **Эрүүл мэндийн маягт АМ-18- Үр хөндөлтийн түүхийн бүртгэлийн маягтыг хөтлөх заавар**

Улсын болон хувийн эмнэлэгт үр хөндөх үед хөтөлнө. Үр хөндөлтийг амбулаториор болон стационариор хийсэн аль ч тохиолдолд уг маягтыг бүртгэнэ. Хүндэрсэн тохиолдолд цаас нааж үргэлжлүүлэн бичнэ.

Маягтын асуусан асуултаас гадна зайлшгүй шаардлагатай асуултыг анамнезаар авч тэмдэглэнэ. /Одоогийн үр хөндүүлж буй шалтгааныг /

### **ҮР ХӨНДӨЛТИЙН БҮРТГЭЛ (АМ-19)**

Улсын болон хувийн эмнэлэгт үр хөндсөн тохиолдол бүрд хөтөлнө. Үр хөндүүлсэн эмэгтэйн боловсрол болон нийгмийн байдал гэсэн баганд тухайн хүнд тохирох кодыг бичнэ. Үр хөндөх үед гарсан хүндрэл бүрийг (+)-ээр тэмдэглэнэ.

**Эрүүл мэндийн маягт АМ-20 Амбулаториор эмчлүүлэгсдийн картыг** их эмч, эх баригч бага эмч хөтлөнө.

**Эрүүл мэндийн маягт АМ-21(А-Б) Шинжилгээнд явуулах бичиг, АМ-22(А-М) Лабораторийн шинжилгээний хуудсууд, АМ-23 Лабораторийн шинжилгээний бүртгэл маягтуудыг их эмч, сувилагч, лаборант нар хөтлөнө.**

**Эрүүл мэндийн маягт АМ-24- Үйл оношийн кабинетийн шинжилгээний бүртгэлийн маягтыг хөтлөх заавар**

Энэхүү бүртгэлийг үйл онош зүйн тасаг /ЭХО, рентген, зүрхний болон тархины цахилгаан бичлэг, компьютер гэх мэт/ кабинетуудад хөтөлнө. Эмчлүүлэгч амбулаториор үйлчлүүлж байгаа тохиолдолд уг эмчлүүлэгчийн ЭМД-ын дугаараар төлбөрийн хэлбэр/даатгал, хувиас/ болох даатгалын нэхэмжлэлээр төлөгдөнө. Явуулсан эмчийн оношийг үндэслэн гарсан илэрсэн өөрчлөлт, дүгнэлт хэсэгт онош баталгаажилт буюу гарсан өөрчлөлт онцлогийг тэмдэглэнэ. Мөн рентген зураг болон биопси шинжилгээний өөрчлөлтийг амбулаторын карт АМ-20 маяганд нааж өөрчлөлтийг дэлгэрэнгүй бичнэ.

**Эрүүл мэндийн маягт АМ-25А,Б - Сэргээн засах эмчилгээний карт, бүртгэлийг хөтлөх заавар**

Сэргээх эмчилгээний картыг нөхөн сэргээх амбулаторийн тасагт хөтөлнө. Энэхүү картыг мэргэжлийн эмч бусад тасаг нэгжээс илгээсэн эмчийн оношийг үндэслэн өвчтөнд олгох ба эмчилгээний төрөл, аль эрхтэнд ямар хугацаагаар хийх заалтыг дэлгэрэнгүй бичнэ.

**Сайжирсан-** Эмчилгээний үр дүнд сувилуулагчийн биеийн байдал эмчийн үнэлгээгээр анх эмчилгээ эхэлснээс дээрдсэн тохиолдлыг хэлнэ.

**Хэвэндээ-** Эмчилгээний хугацаанд сувилуулагчийн биеийн байдал эмчийн үнэлгээгээр анх эмчилгээ эхэлснээс сайжирсан үр дүн гараагүй тохиолдлыг хэлнэ.

Эрүүл мэндийн маягт АМ-25Б- Нөхөн сэргээх эмчилгээний бүртгэлийн маягтыг АМ-25А маягтыг үндэслэн бүртгэл хийж нөхөн сэргээх амбулаторийн тасгийн эмч сувилагч хөтөлнө. Эмчилгээний нэр, төрлөөр ялгаж эмчилгээний төрөл хэсэгт бүртгэл хийх ба 1 өвчтөн хэдэн төрлийн ч эмчилгээний төрөлд хамрагдаж давхардаж бичигдэж болно. Эмч тухайн төрлийн эмчилгээг хэдэн удаа хийх заалтыг “Эмчилгээ хийх удаа” гэсэн хэсэгт бичих ба эмчилгээ хийсэн өдрүүдээр тооцож нийт хийсэн эмчилгээг сувилагч тэмдэглэл хөтөлнө.

Маягтыг загвар маягтын дагуу гаргацтай зөв бичнэ.

## **Эрүүл мэндийн маягт АМ-26А,Б-Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдагчдын бүртгэлийн маягтыг хөтлөх заавар**

Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдагчдын бүртгэлийг Хавдар судлалын үндэсний төвийн хөнгөвчлөх эмчилгээний тасгийн их эмч болон аймаг, дүүргийн хавдрын кабинетийн их эмч, хөнгөвчлөх тусламжийн багийн эмч, хувийн болон буяны хосписуудын их эмч нар ямар нэгэн өвчний хүндрэлийн улмаас хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлсэн өвчтөн бүрт хөтөлнө. Эрүүл мэндийн бүртгэлийн маягт АМ-26А маягтыг амбулаториор болон гэрээр үйлчлүүлсэн тохиолдолд бүртгэнэ. АМ-26Б маягтыг стационараар эмчлүүлэгсдэд хөтөлнө.

Маягтыг загвар маягтын дагуу гаргацтай зөв бичнэ.

Тогтмол хаяг-Өвчтний оршин суугаа хаягийг иргэний үнэмлэхийг үндэслэн дэлгэрэнгүй бичнэ.

Үнэгүй олгосон эм-Тухайн байгууллагаас хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх үед хэрэглэгдсэн үнэгүй олгох заалттай эмийн хэмжээг бичнэ.

Тайлбар гэсэн хэсэгт онцгой анхаарах дэглэм, хяналтын талаархи мэдээллийг үлдээнэ.

Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдагчдын бүртгэлийг хөтөлсөн эмч, ажилтан уг хуудсыг өөрийн харьяа эрүүл мэндийн байгууллагын статистик мэдээллийн албанд хүлээлгэн өгнө.

### **Зүү төөнө, засал эмчилгээний карт АМ-29А**

Амбулаторт хөтлөгдөх АМ-29А маягтыг эмчилгээ үзүүлж буй их эмч хөтөлнө. Эмнэлгийн нэрний хэсэгт тухайн эрүүл мэндийн байгууллага нэр, кодоор бичиж тэмдэглэнэ. Маягтын I талын 1-7 дугаар асуултанд эмчлүүлэгчийн ерөнхий мэдээллийг бичиж тэмдэглэн эмчлэгч эмч гарын үсэг зурж баталгаажуулна. Маягтын II хэсэгт эмчилгээ хийлгэсэн байдал, хэдэн удаа, ямар эмчилгээ хийлгэснийг бичиж тэмдэглэн өдөр бүр эмчилгээ хийсэн эмч гарын үсэг зурж баталгаажуулна. Эмчилгээ дууссаны дараа тухайн эмчлүүлэгчийн биеийн байдал ямар болсон талаар үр дүнгийн хэсэгт доогуур нь зурж бөглөнө.

### **Дэвтээлгэ засал эмчилгээний засал АМ-29Б**

Амбулаторт хөтлөгдөх АМ-29Б маягтыг эмчилгээ үзүүлж буй их эмч хөтөлнө. Эмнэлгийн нэрний хэсэгт тухайн эрүүл мэндийн байгууллага нэр, кодоор бичиж тэмдэглэнэ. Эмчлүүлэгчийн нэр, нас, хүйс, эмчилгээ эхэлсэн он сар болон дууссан он сарыг бичиж тэмдэглэн, үндсэн оношийг тавьж, эмчилгээний төрлийг сонгон гарын үсэг зурж баталгаажуулна.

### **Бариа засал эмчилгээний карт АМ-29В**

Бариа засал эмчилгээний карт АМ-29В маягтыг эмчилгээ үзүүлж буй их эмч хөтөлнө. Эмнэлгийн нэрний хэсэгт тухайн эрүүл мэндийн байгууллага нэр, кодоор бичиж тэмдэглэнэ. Маягтын I хэсэгт эмчлүүлэгчийн нэр, нас, хүйс, эмчилгээ эхэлсэн он сар болон дууссан он сарыг бичиж тэмдэглэн, үндсэн оношийг тавьж, барианы төрөл, хэсэгчилсэн барианы төрлийг тэмдэглэж гарын үсэг зурж баталгаажуулна. Маягтын II хэсэгт барианы төрөл, он, сар, өдөр,

ямар эрхтэнд хийгдэж байгаа, хэдэн удаа, нэг удаа хийхэд үргэлжилсэн хугацааг тэмдэглэж гарын үсэг зурж баталгаажуулна.

### **Хатгах засал эмчилгээний карт АМ-29Г**

Хатгах засал эмчилгээний карт АМ-29Г эмчилгээ үзүүлж буй их эмч хөтөлнө. Эмнэлгийн нэр, кодыг асуултын харгалзах хэсэгт бөглөнө. Өвчтөний ерөнхий мэдээлэл овог, нэр, нас, хүйсийг тэмдэглэнэ. Эмчилгээ эхэлсэн болон дууссан он сарыг тэмдэглэнэ. Үндсэн оношыг ӨОУА-10-аар бичиж тэмдэглэнэ. Эмчилгээний төрөл, талбай, байрлалыг харгалзах хэсэгт бичнэ. Хүндрэл гарсан тохиолдолд гарсан хүндрэл хэсэгт бичиж тэмдэглэнэ. Өвчтөн хатгах засал хийхийг зөвшөөрсөн бол өвчтөний нэр хэсэгт өвчтөний нэрийг бичиж баталгаажуулна. Эмчилгээ хийсэн их эмч мөн овог, нэр тавьж баталгаажуулна.

### **Настны эрүүл мэндийн бүртгэл АМ-28 маягт**

Настанд эрүүл мэндийн анхан шатны байгууллага болох өрх, сумын эрүүл мэндийн төв өөрийн харъяалалд оршин суудаг 55, түүнээс дээш насны эмэгтэй, 60, түүнээс дээш насны эрэгтэйг хамруулна. АМ-28 маягтыг үндэслэн ЭМТ 101.6.1-2 тайлнууд гарна.

Настны өдөр тутмын бие даах чадварын болон багаж хэрэгсэлтэй ажиллах чадвар үнэлгээг Эрүүл мэндийн Сайдын 2010 оны 5 дугаар сарын 31-ны 180 тоот тушаалаар батлагдсан “Настны эрүүл мэндийн үнэлгээний удирдамж”-аар батлагдсан сорилуудаар үнэлнэ.

**Настны өдөр тутмын бие даах чадварын үнэлгээ:** 10-12 оноо-хэвийн, 6-9 оноо –алдагдсан, 0-5 оноо- хараат гэж тодорхойлно.

**Настны багаж хэрэгсэлтэй ажиллах чадварын үнэлгээ:** 14-16 оноо –хэвийн, 10-13 оноо – алдагдсан, 6-9 оноо-хараат гэж тодорхойлно.

**Настны танин мэдэхүйн чадварыг үнэлэх хураангуй сорил:** Хэвийн-24-30 оноо, үл мэдэг танин мэдэхүйн чадвар буурсан 23-18 оноо, хүнд хэлбэрээр танин мэдэхүйн чадвар буурсан- 17 оноо гэж тодорхойлно.

**Хоол тэжээлийн байдлыг үнэлэх хураангуйлсан асуумж:** 12-14 оноо-хоол тэжээлийн байдал хэвийн, 8-11 оноо-хоол тэжээлийн дуталд хүрэх эрсдэлтэй, 0-7 оноо-хоол тэжээлийн дуталтай

**Биеийн жингийн индекс:** Эмч настны биеийн жингийн индексийг тооцоод 18.5-24кг/м.кв-туранхай-, Хэвийн -18.5-24кг/м.кв, Илүүдэл жинтэй-25-29кг/м.кв, Тарган-30кг/м.кв< гэж тодорхойлно.

**Эрүүл мэндийн бүлэг:** Настны эрүүл мэндийн байдлыг тодорхойлж ЭМТ-101.1 маягтад тодорхойлсны дагуу тооцож гаргана.

**Сэтгэцийн болон зан төрхийн эмгэг:** Настанд өвчний олон улсын 10-р ангиллын 5-р бүлэгт хамаарах өвчин эмгэг бүртгэгдсэн тохиолдолд бичнэ.

**Насны доройтол:** Настанд өвчний олон улсын 10-р ангиллын R54 кодоод хамаарагдах шинж тэмдэг илэрсэн тохиолдолд бичнэ.

**Зүү төөнө, засал эмчилгээний карт AM29A, Дэвтээлгэ засал эмчилгээний карт AM-29Б, Бариа засал эмчилгээний карт AM29В, Хатгах засал эмчилгээний карт AM29Г маягт**

### **Зүү төөнө, засал эмчилгээний карт AM-29A**

Амбулаторит хөтлөгдөх AM-29A маягтыг эмчилгээ үзүүлж буй их эмч хөтөлнө. Эмнэлгийн нэрний хэсэгт тухайн эрүүл мэндийн байгууллага нэр, кодоор бичиж тэмдэглэнэ. Маягтын I талын 1-7 дугаар асуултанд эмчлүүлэгчийн ерөнхий мэдээллийг бичиж тэмдэглэн эмчлэгч эмч гарын үсэг зурж баталгаажуулна. Маягтын II хэсэгт эмчилгээ хийлгэсэн байдал, хэдэн удаа, ямар эмчилгээ хийлгэснийг бичиж тэмдэглэн өдөр бүр эмчилгээ хийсэн эмч гарын үсэг зурж баталгаажуулна. Эмчилгээ дууссаны дараа тухайн эмчлүүлэгчийн биеийн байдал ямар болсон талаар үр дүнгийн хэсэгт доогуур нь зурж бөглөнө.

### **Дэвтээлгэ засал эмчилгээни засал AM-29Б**

Амбулаторит хөтлөгдөх AM-29Б маягтыг эмчилгээ үзүүлж буй их эмч хөтөлнө. Эмнэлгийн нэрний хэсэгт тухайн эрүүл мэндийн байгууллага нэр, кодоор бичиж тэмдэглэнэ. Эмчлүүлэгчийн нэр, нас, хүйс, эмчилгээ эхэлсэн он сар болон дууссан он сарыг бичиж тэмдэглэн, үндсэн оношийг тавьж, эмчилгээний төрлийг сонгон гарын үсэг зурж баталгаажуулна.

**Дэвтээлгэ засал** гэдэг нь биеийн гадна талаас байгаль, амьтан ургамлын гаралтай зүйлийг ашиглан орох, шавших, түрхэх, ороож боох, утах зэргээр өвчнийг анагаадаг уламжлалт зөөлөн заслын нэг төрөл юм.

### **Бариа засал эмчилгээний карт AM-29В**

Бариа засал эмчилгээний карт AM-29В маягтыг эмчилгээ үзүүлж буй их эмч хөтөлнө. Эмнэлгийн нэрний хэсэгт тухайн эрүүл мэндийн байгууллага нэр, кодоор бичиж тэмдэглэнэ. Маягтын I хэсэгт эмчлүүлэгчийн нэр, нас, хүйс, эмчилгээ эхэлсэн он сар болон дууссан он сарыг бичиж тэмдэглэн, үндсэн оношийг тавьж, барианы төрөл, хэсэгчилсэн барианы төрлийг тэмдэглэж гарын үсэг зурж баталгаажуулна. Маягтын II хэсэгт барианы төрөл, он, сар, өдөр, ямар эрхтэнд хийгдэж байгаа, хэдэн удаа, нэг удаа хийхэд үргэлжилсэн хугацааг тэмдэглэж гарын үсэг зурж баталгаажуулна.

### **Хатгах засал эмчилгээний карт AM-29Г**

Хатгах засал эмчилгээний карт AM-29Г эмчилгээ хийсэн их эмч хөтөлнө. Эмнэлгийн нэр, кодыг асуултын харгалзах хэсэгт бөглөнө. Өвчтөний ерөнхий мэдээлэл овог, нэр, нас, хүйсийг тэмдэглэнэ. Эмчилгээ эхэлсэн болон дууссан он сарыг тэмдэглэнэ. Үндсэн оношыг /ӨОУА-10/-аар бичиж тэмдэглэнэ. Эмчилгээний төрөл, талбай, байрлалыг харгалзах хэсэгт бичнэ. Хүндрэл гарсан тохиолдолд гарсан хүндрэл хэсэгт бичиж тэмдэглэнэ. Өвчтөн хатгах засал хийхийг зөвшөөрсөн бол өвчтөний нэр хэсэгт өвчтөний нэрийг бичиж баталгаажуулна. Эмчилгээ хийсэн их эмч мөн овог, нэр тавьж баталгаажуулна.

### **Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийн маягтууд**

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 3 сарын 29-ний өдрийн 95 тоот тушаалын дагуу үзлэгийг хийж бүртгэлийг маягтын дагуу их эмч хөтлөнө.

“Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн үзлэгийн маягт” ХБӨЭИМ-1

“Чихрийн шижин хэв шинж 2 өвчний эрт илрүүлгийн үзлэгийн маягт” ХБӨЭИМ-2

“Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгийн маягт” СМУ-2, “Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгийн маягт” СМХ -2 Анхдаг шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулан хийж байгаа бөгөөд 450 дугаар тушаалаар шинээр батлагдсан.

## **Осол гэмтлийн өвчлөл, нас баралттай холбоотой нэр томьёо**

### *1. Осол гэмтэл*

Гадны хүчин зүйлийн урт болон богино хугацааны үйлчлэл, нөлөөллөөр хүний бие махбодын бүтэц, үйл ажиллагаа, эрүүл мэндэд учрах хохирол буюу эмгэгшлийг хэлнэ. Гадны хүчин зүйл нь механик, туяа, халуун, хүйтэн, гэрэл, цахилгаан, даралт буюу физикийн, химийн гэх мэт олон төрлөөс бүрдэнэ. Осол гэмтлийг түүний үйлдсэн хэлбэрээр нь санамсаргүй болон санаатай тохиолдол гэж ангилдаг.

### *2. Осол гэмтлийн шинэ тохиолдол*

Тухайн тайлангийн жилд тухайн осол гэмтлийн шалтгаанаар эмнэлэгт анх удаа хандаж тусламж авсан болон эмнэлэгт тусламж авч чадалгүй газар дээрээ нас барсан тохиолдлыг хэлнэ. Хэрэв тухайн хүн тухайн тайлангийн жилд дахин өөр шалтгаанаар шинэ осол гэмтэлд өртсөн бол мөн шинэ тохиолдлоор бүртгэнэ.

Осол гэмтлийн шалтгаант нас баралт нь осол гэмтлийн шинэ тохиолдол мөн бөгөөд тухайн гэмтлийн улмаас аль 1 эрүүл мэндийн байгууллагад бүртгэгдээгүй бол түүнийг шинэ тохиолдлоор бүртгэнэ. Жишээ нь: зам тээврийн ослын үед машинд 5 хүн байсны 2 нь нас барсан, 3 нь гэмтсэн бол 5-уулаа шинэ тохиолдолд бүртгэгдэнэ.

### *3. Нэг удаагийн тохиолдол*

Гэмтсэн хүн бүрийг тусад нь бүртгэх ба жишээ нь нэг удаагийн зам тээврийн ослоор хамт гэмтсэн гурван хүнийг гурван тохиолдолд бүртгэнэ.

### *4. Санамсаргүй осол гэмтэл*

Санамсаргүй осол гэмтэл гэж зориудын бус, болгоомжгүй үйлдлээс үүссэн осол гэмтлийн тохиолдлыг хэлнэ. Тухайлбал: Зам тээврийн осол, халитарч унах, гал түймэр, хордлого, живэх, бүтэх гэх мэт

#### *4.1. Зам тээврийн осол*

Нийтийн зам, харгуй дээр тээврийн хэрэгслийн оролцоотойгоор гарах гэмтэл, золгүй тохиолдлыг зам тээврийн осол гэнэ. ( ДЭМБ )

#### *4.2. Түлэгдэлт*

Түлэгдэлт буюу дулааны өндөр хэмээс шалтгаалах осол гэмтэл гэдэг нь халуун шингэн (шалзлах), халуун хатуу биет (хавьталтын түлэгдэлт) эсвэл галын (галын түлэгдэлт) улмаас хүний арьсны бүх эсвэл аль нэг давхрагын эд эс гэмтэхийг хэлдэг. Мөн хэт ягаан туяа, цацраг, цахилгаан, химийн бодис, хорт бодисоор амьсгалснаас шалтгаалж, уушиг гэмтэх зэргийг түлэгдэлтэд оруулна.

#### *4.3. Живэх*

Живэлт гэж шингэн зүйл амьсгалын замын бүх эсвэл аль нэг хэсэгт орохыг хэлнэ.

#### *4.4. Унах*

Уналт гэдэг нь хүн газарт, шалан дээр зэрэг ижил түвшинд эсвэл аль нэг түвшнээс доош унаж, бэртэхийг хэлнэ.

#### 4.5. Хордох

Хордолт гэж хорт бодисын нөлөөгөөр үүсэж байгаа үйл ажиллагааны өөрчлөлтийг хэлнэ.

### 5. Санаатай үйлдэгдсэн осол гэмтэл

Зориудаар бусдын болон өөрийнхөө биед халдах, хүчирхийлэх, амь насыг хохироох, амиа хорлох зорилгоор үйлдэгдсэн осол гэмтлийг хэлнэ.

Үүнд: хүн хоорондын зодоон, аллага, халдлага, бэлгийн хүчирхийлэл, амиа хорлох болон амиа хорлохыг завдах оролдлогууд орно. Сэдэл нь санаатайгаар үйлдэгдсэн байна.

#### 5.1. Хүчирхийлэл

Биеийн хүч болон бусад давуу байдлаа зориудаар ашиглан бусдыг айлган сүрдүүлэх, бодит байдлаар хүчирхийлэх, нийгэм болон хэсэг бүлэгт эрүүл мэнд болон сэтгэл санааны хор хохирол, гэмтэл учруулах, хоцрогдол, үгүйрэл, хоосрол, үхэл зэргийг үүсгэх ба үүсгэхийг завдахыг хэлнэ.

#### 5.2. Бэлгийн хүчирхийлэл

Тухайн эрэгтэй болон эмэгтэйн хүслийг харгалзахгүйгээр биеийн хүчээр бэлгийн харьцаанд орохыг шаардах, бэлгийн ажил хийх болон бэлгийн ажил хийхийг завдахыг бэлгийн хүчирхийлэл гэнэ. Үүнд тухайн нөхцөл байдлыг ойлгох чадваргүй хүн, бэлгийн харьцаанд орохыг татгалзсан хүн, бэлгийн харьцааг хүсэхгүй (өвчтэй, тахир дүтуу, эмийн болон архины нөлөөнд байгаа, айж сүрдсэн шахалт дарамтанд орсны улмаас) хүнтэй бэлгийн харьцаанд орох болон оролдлого хийхийг хамруулна.

#### 5.3. Алан хядах үйл ажиллагаа

Хууль бус байдлаар, хүчээр хувь хүн болон эд хөрөнгийн эсрэг айлган сүрдүүлэх, хүчлэн албадах, энгийн ард иргэд, хүн амын тодорхой хэсэг бүлгийн эсрэг тодорхой зорилгоор хийх хүчирхийллийг хэлнэ.

#### 5.4. Өөрийгөө гэмтээх

Зориудаар өөрийн эрүүл мэнд, бие махбодод хор хохирол учруулсан болон учруулахыг завдсан үйлдлийг хэлнэ.

#### 5.5. Амиа хорлох

Гэмтээх, хордуулах, боймлох зэргээр тухайн этгээд өөрийнхөө үхэх зорилгыг илэрхий байдлаар эсвэл далд хэлбэрээр ямар нэгэн нотолгоотойгоор үйлдэхийг хэлнэ.

#### 5.6. Амиа хорлох оролдлого

Өөрийгөө гэмтээх, хөнөөх үйлдлийг илэрхий болон далд хэлбэрээр тодорхой түвшинд гүйцэтгэж, үхэлд хүрэлгүйгээр амиа хорлохыг завдсан оролдлогыг хэлнэ. Олон улсын ангиллаар амиа хорлоход галт зэвсэг, өндрөөс зориудаар унах, өөрийгөө дүүжлэх, эмийн болон химийн бодисыг хэрэглэх зэрэг үйлдлээр өөрийгөө егүүтгэх оролдлогууд хамаарна.

## **Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас АМ-33**

### **ЕРӨНХИЙ ЗААВАР:**

1. Осол гэмтлийн улмаас эмнэлэгт үзүүлсэн шинэ тохиолдол бүрт энэхүү “Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудсыг хөтлөх буюу давтан үзлэгт уг маягтыг бөглөхгүй.

2. Ижил гэмтлээс давтан ирэх тохиолдлыг давхар бүртгэхгүй бөгөөд жишээ нь түлэгдсэн хүн эмчилгээнд давтан ирэх тохиолдолд шинээр тандалтын хуудас бөглөх ёсгүй. Ямарваа нэг хүний шинэ гэмтлийг шинэ тохиолдолд бүртгэх ба жишээ нь өвчтөн эхний долоо хоногт өндрөөс унах, дараагийн долоо хоногт нохойд хазуулсан тохиолдолд тус тусад нь шинэ тохиолдолд тооцно.
3. Хэрэв нэг хүн осол гэмтлийн 2 шалтгаанаар гэмтсэн бол үндсэн шалтгааныг нь л бөглөх буюу Б-2 дээр давхцуулж бичихгүй.
  1. Жишээ нь: хэн нэгэн хүн галаар түлж гэмтээсэн бол Б-2-ийн хүчирхийлэл гэсэн шалтгааныг бөглөөд Г7 дээр / галаар түлэх/ ашигласан зүйлсийг тэмдэглэнэ.
4. Маягтыг бөглөхдөө асуултын дагуух харалдаа хэсэгт байгаа номерийг чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ.  
Эмчийн зурж тэмдэглэсэн шифрийг шууд компьютерт шивж оруулах тул асуумж бүрийг алгасалгүй бөглөсөн байх ёстой.
5. Маягтуудыг өдөр тутам статистикч бага эмч нар хянаж, бүрэн бөглөгдөөгүй тохиолдолд тухайн маягтыг бөглөсөн эмчид эргэн хандаж бөглүүлнэ.
6. Энэхүү маягтын асуумж бүр дээр байгаа бусад гэсэн нүдийг бөглөх тохиолдолд заавал тодорхой бичнэ.
7. Зам тээврийн осол, хүчирхийлэл, амиа хорлохыг завдсанаас бусад шалтгаантай осол гэмтэлд өртсөн бол Б-2 хэсэг дээр аль шалтгаан нь гэдгийг сонгож бөглөөд харин В, Г, Д хэсгийг бөглөхгүй.
8. Энэхүү маягтын В хэсгийг зам тээврийн осолд өртсөн тохиолдолд л бөглөх буюу энэ тохиолдолд Г, Д хэсгийг бөглөхгүй.
9. Маягтын Г хэсгийг хүчирхийлэлд өртсөн тохиолдолд л бөглөх буюу энэ тохиолдолд В, Д хэсгийг бөглөхгүй.
10. Маягтын Д хэсгийг амиа хорлохыг завдсан тохиолдолд л бөглөх буюу энэ тохиолдолд В, Г хэсгийг бөглөхгүй.

**АСУУМЖИЙГ ХӨТЛӨХ ЗААВАР:**

"Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас"-ыг үзлэг хийсэн эмч осол гэмтлийн **шинэ тохиолдол** бүрт хөтөлнө. Өвчтний биеийн байдалд тохируулан эрэмбэлэн ангиллын А, В, С, D зэргийн аль нэгийг сонгон дугуйлна.

А. Паспортын хэсэг							
Асуумж	Тодорхойлолт, жишээ:						
A1. Эмнэлгийн нэр	<p>Эмнэлгийн нэрийг бичихдээ эмнэлгийн нэр гэсэн 6 нүдний эхний 2 нүдэнд аймаг хотын, дараагийн 2 нүдэнд сум, дүүргийн, сүүлийн 2 нүдэнд эмнэлгийн шифрийг тус тус бичнэ.</p> <p>Жишээ нь: Баянхонгор аймгийн Галуут сумын эмнэлэг</p> <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <tr> <td>0</td> <td>3</td> <td>1</td> <td>1</td> <td>0</td> <td>3</td> </tr> </table>	0	3	1	1	0	3
0	3	1	1	0	3		

A2. Эцэг /эх/-ийн нэр	Осол гэмтэлд өртсөн хүний эцэг /эх/ -ийн нэрийг бичнэ			
A3. Нэр	Осол гэмтэлд өртсөн хүний өөрийн нэрийг бичнэ.			
A4. Регистрийн дугаар	Гэмтсэн хүний регистрийн дугаарыг бичих ба хүснэгтийн эхний 2 нүдэнд үсэг, дараагийн 8 нүд тус бүрт нэг цифр байхаар тохируулж бичнэ.			
A5. Нас	Насыг кодлохдоо нүд тус бүрд нэг цифр бичнэ. 1 нас хүрээгүй хүүхдийн насыг сараар, нярай хүүхдийг өдрөөр бичиж шифрийн ар талд сар, өдрийн аль нь болохыг тодотгож бичнэ. Тухайлбал: 11 настай гэвэл: 11 нас, харин 11 сартай гэвэл 11 сар, 11 өдөртэй гэвэл 11өдөр гэнэ. Жишээ нь. 11 сартай гэх <table border="1" style="display: inline-table; vertical-align: middle;"><tr><td style="width: 20px; text-align: center;">1</td><td style="width: 20px; text-align: center;">1</td><td style="width: 40px; text-align: center;">сар</td></tr></table> мэт.	1	1	сар
1	1	сар		
A6. Хүйс	Хүйсийг тэмдэглэхдээ хүйс эрэгтэй бол-1, эмэгтэй бол-2, хэрэв тухайн хүн огт мэдэхгүй эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу-99 гэж зохих нүдэнд бөглөнө.			
A7. Тогтмол хаяг	Тогтмол хаяг гэсэн нүдэнд тухайн хүний байнга оршин суугаа газрын засаг захиргааны нэгжийн харъяалалаар бичнэ. Эхлээд аймаг /хотын/, дараа нь сум, /дүүргийн/, сүүлд нь хороо /багийг/, гудамж /байрны/, хаалганы дугаарыг бичнэ Жишээ нь: Архангай аймгийн, Ихтамир сумын, 1-р баг, тайхрын 2-р гудамж 12 тоот			
A8. Утасны дугаар	Гэмтсэн хүний утасны дугаар болон ар гэртэй нь холбоо барих утасны дугаарыг бичнэ.			
A9. Ажлын газар, албан тушаал	Гэмтсэн хүний ажлын газар, албан тушаал, мэргэжлийг бичнэ.			
A10. Боловсрол	Гэмтсэн хүний боловсролыг бөглөхдөө бага-1, дунд-2, мэргэжил-техникийн- 3, дээд - 4, боловсролгүй-5 гэж харалдаа зохих нүдэнд бөглөнө.			
A11. Эмнэлэгт яаж ирсэн	Гэмтсэн хүн эмнэлэгт яаж ирснийг зохих кодыг дугуйлж бүртгэнэ. Өөрөө ирсэн бол-1, түргэнээр ирсэн бол-2, хариулах боломжгүй тохиолдолд бусад-98 гэсэн хэсгийг дугуйлж, юугаар ирснийг заавал тодорхой бичнэ. Жишээ нь: Гэмтсэн хүн таксигаар эмнэлэгт хүргэгдсэн <table border="1" style="display: inline-table; vertical-align: middle;"><tr><td style="width: 100px;">Бусад <b><u>такси</u></b></td><td style="width: 40px; text-align: center;">98</td></tr></table>	Бусад <b><u>такси</u></b>	98	
Бусад <b><u>такси</u></b>	98			
A12. Согтууруулах ундаа хэрэглэсэн эсэх	Гэмтэх үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн байсан бол-1, хэрэглээгүй бол-2 гэж нүдэнд тэмдэглэнэ.			
A13. Мансууруулах бодис хэрэглэсэн эсэх	Гэмтэх үедээ мансууруулах бодис хэрэглэсэн байсан бол-1, хэрэглээгүй бол-2 гэж нүдэнд тэмдэглэнэ.			

<p>A14. Өөр эмнэлэгт хандсан эсэх</p>	<p>Гэмтсэн хүн тухайн гэмтлээрээ аль нэгэн эмнэлэгт хандсан бол ямар эмнэлэгт хандсаныг тодруулж тохирох нүдэнд тэмдэглэнэ. Үүнд:          Өрхийн Эрүүл мэндийн төв-1          Сум, тосгон, сум дундын эмнэлэг-2          Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг-3          Бүсийн оношлогоо, эмчилгээний төв-4          Төрөлжсөн нарийн мэргэжлийн төв-5          Бусад -98</p>						
<p>A15. Гэмтсэн хугацаа</p>	<p>Гэмтэл авсан он, сар, өдөр, цаг, минутыг бөглөхдөө эхний 1 нүдэнд оныг, 2-р нүдэнд сарыг, 3-р нүдэнд өдрийг, 4-р нүдэнд цагийг, 5-р нүдэнд минутыг тус тус бичнэ.          Жишээ нь: Гэмтсэн хүн 2011 оны 7 сарын 6-ны 24 цаг 5 минутанд гэмтсэн гэх мэт.</p> <table border="1" data-bbox="912 596 1265 663"> <tr> <td>11</td> <td>07</td> <td>06</td> <td>24</td> <td>05</td> </tr> </table>	11	07	06	24	05	
11	07	06	24	05			
<p>A16. Үзүүлсэн хугацаа</p>	<p>Энэ гэмтлээр эмнэлэгт хандсан он, сар, өдөр, цаг, минутыг бөглөхдөө эхний 1 нүдэнд оныг, 2-р нүдэнд сарыг, 3-р нүдэнд өдрийг, 4-р нүдэнд цагийг, 5-р нүдэнд минутыг тус тус бичнэ. Жишээ нь: Гэмтсэн хүн 2011 оны 7 сарын 6-ны 16 цаг 35 минутанд үзүүлсэн гэх мэт.</p> <table border="1" data-bbox="927 850 1279 917"> <tr> <td>11</td> <td>07</td> <td>06</td> <td>16</td> <td>35</td> </tr> </table>	11	07	06	16	35	
11	07	06	16	35			
<p>A17. Осол болсон цэгийн нэр, байршил</p>	<p>Осол хаана болсон цэгийн нэрийг бөглөхдөө тухайн осол болсон дүүрэг, хороо, осол болсон газрын нэрийг дэлгэрэнгүй бичнэ. Жишээ нь: <b>Гурвалжингийн тойрог</b></p>						
<p><b>Б. Осол гэмтлийн талаарх үндсэн мэдээллийн хэсэг</b></p>							
<p>Асуумж</p>	<p>Тодорхойлолт, жишээ</p>						
<p>Б1. Осол гарах үеийн байршил</p>	<p>Осол гарах үеийн байршлыг бөглөхдөө /1-11, 98-99-р дугаараас сонгож/ зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Дурьдсанаас бусад газар гэмтсэн бол-98 гэсэн нүдийг бөглөөд хаана гэмтсэнийг тодорхой бичнэ. Хэрэв осол гарсан газрыг тухайн хүн огт мэдэхгүй эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу-99 гэж нүдэнд тэмдэглэнэ.          Жишээ нь: Гэмтсэн хүн гудамжинд хальтирч унасан гэх мэт.</p> <table border="1" data-bbox="745 1467 1256 1747"> <tr> <td>Биеийн тамир, спортын талбай</td> <td>3</td> </tr> <tr> <td>Гудамж, зам</td> <td>4</td> </tr> <tr> <td>Худалдаа үйлчилгээний газар</td> <td>5</td> </tr> </table>	Биеийн тамир, спортын талбай	3	Гудамж, зам	4	Худалдаа үйлчилгээний газар	5
Биеийн тамир, спортын талбай	3						
Гудамж, зам	4						
Худалдаа үйлчилгээний газар	5						
<p>Б2. Осол гэмтлийн шалтгаан</p>	<p>Осолд хүргэсэн шалтгааныг бөглөхдөө зөвхөн үндсэн 1 шалтгааныг зохих нүдний харалдаа хэсэгт тэмдэглэнэ.          Жишээ нь: Хамтран амьдрагч нь зодож, халуун усаар түлсэн гэх мэт.</p>						

	<table border="1"> <tr> <td>Зам тээврийн осол</td> <td>1</td> </tr> <tr> <td>Хүчирхийлэл</td> <td>2</td> </tr> <tr> <td>Амиа хорлохыг завдах</td> <td>3</td> </tr> </table>	Зам тээврийн осол	1	Хүчирхийлэл	2	Амиа хорлохыг завдах	3
Зам тээврийн осол	1						
Хүчирхийлэл	2						
Амиа хорлохыг завдах	3						
	<p>Харин дурдсанаас бусад шалтгааны улмаас гэмтсэн бол-98 гэсэн нүдийг бөглөөд ямар гэмтлийн шалтгаантайг тодорхой бичнэ. Хэрэв осол гэмтлийн шалтгааны талаар тухайн хүн огт мэдэхгүй байх эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу 99 гэж нүдэнд тэмдэглэнэ.</p>						

**Нэмэлт мэдээлэл / В, Г, Д /**

<u>Нэмэлт мэдээлэл / В, Г, Д /</u>	<p>Үүнд зам тээврийн осол, амиа хорлохыг завдах болон хүчирхийлэл зэрэг гэмтлийн онцгой тэргүүлэх шалтгаан бүхий зүйлсийг агуулах ба гэмтэлтэй хамааралтай цаашдын нэмэлт мэдээллийг багтаасан болно.</p>
------------------------------------	---

<p>В. Зам тээврийн осол В1. Зам тээврийн хэрэгслийн төрөл</p>	<p>Осол гарах үед тухайн хүн ямар тээврийн хэрэгслээр зорчиж байсныг бөглөхдөө /1-9-р дугаараас сонгож/ зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Жишээ нь: Морь унаж яваад гэмтсэн гэх мэт</p> <table border="1"> <tr> <td>Нийтийн тээврийн хэрэгсэл</td> <td>6</td> </tr> <tr> <td>Морь</td> <td>7</td> </tr> </table>	Нийтийн тээврийн хэрэгсэл	6	Морь	7
Нийтийн тээврийн хэрэгсэл	6				
Морь	7				

<p>В2. Ослын үед замын хөдөлгөөнд хэрхэн оролцож байсан бэ</p>	<p>Ослын үед тухайн хүн ямар байдлаар хөдөлгөөнд оролцож байсныг тодруулж бөглөхдөө /1-5, 98-99-р дугаараас сонгож/ зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Хэрэв мориноос унаж гэмтсэн бол уралдааны мориноос унасан уу, энгийн мориноос унасан эсэхийг тодруулж бөглөнө. Дурьдсанаас бусад байдлаар замын хөдөлгөөнд оролцож байсан бол-98 гэсэн нүдийг бөглөөд замын хөдөлгөөнд өөр ямар байдлаар оролцож байсныг тодорхой бичнэ. Хэрэв тухайн хүн огт мэдэхгүй байх эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу 99 гэж нүдэнд тэмдэглэнэ.</p> <p>Жишээ нь: Хурдан мориноос унаж гэмтсэн гэх мэт.</p> <table border="1"> <tr> <td>Зорчигч</td> <td>3</td> </tr> <tr> <td>Уралдааны морь унаач</td> <td>4</td> </tr> <tr> <td>Энгийн морь унагч</td> <td>5</td> </tr> </table>	Зорчигч	3	Уралдааны морь унаач	4	Энгийн морь унагч	5
Зорчигч	3						
Уралдааны морь унаач	4						
Энгийн морь унагч	5						

<p>В3. Зам тээврийн ослын үед ямар зүйлтэй мөргөлдсөн</p>	<p>Гэмтсэн хүн зам тээврийн ослын үед ямар зүйлтэй мөргөлдсөнийг тодруулж бөглөхдөө /1-5, 98-99-р дугаараас сонгож/ зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Дурьдсанаас өөр бусад ямар нэгэн зүйлтэй мөргөлдсөн бол-98 гэсэн нүдийг бөглөнө. Хэрэв тухайн хүн</p>
---	---

	<p>огт мэдэхгүй эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу-99 гэж нүдэнд тэмдэглэнэ.</p> <p>Жишээ нь: Машинтай хажуугийн хашлага</p> <table border="1" data-bbox="812 237 1193 474"> <tr> <td>Хөдөлгөөнгүй зүйл</td> <td>4</td> </tr> <tr> <td>Мөргөлдөөгүй /онхолдох/</td> <td>5</td> </tr> </table> <p>явж байгаад замын мөргөсөн гэх мэт.</p>	Хөдөлгөөнгүй зүйл	4	Мөргөлдөөгүй /онхолдох/	5		
Хөдөлгөөнгүй зүйл	4						
Мөргөлдөөгүй /онхолдох/	5						
<p>В4. Осол гарах үед хамгаалалтын бүс хэрэглэсэн эсэх</p>	<p>Гэмтсэн хүн осол гарах үед хамгаалалтын бүс хэрэглэсэн эсэхийг зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог дугуйлан зурж тэмдэглэнэ.</p> <p>Жишээ нь: Машин жолоодож байх үедээ хамгаалалтын бүс хэрэглээгүй гэх мэт</p> <table border="1" data-bbox="846 682 1157 898"> <tr> <th colspan="2">Хамгаалалтын бүс</th> </tr> <tr> <td>Тийм</td> <td>1</td> </tr> <tr> <td>Үгүй</td> <td>2</td> </tr> </table>	Хамгаалалтын бүс		Тийм	1	Үгүй	2
Хамгаалалтын бүс							
Тийм	1						
Үгүй	2						
<p>В5. Осол гарах үед хамгаалалтын малгай хэрэглэсэн эсэх</p>	<p>Гэмтсэн хүн осол гарах үед хамгаалалтын малгай хэрэглэсэн эсэхийг зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог дугуйлан зурж тэмдэглэнэ.</p> <p>Жишээ нь: Мотоциклоор зорчиж явах үедээ хамгаалалтын малгай хэрэглээгүй гэх мэт.</p> <table border="1" data-bbox="836 1056 1256 1272"> <tr> <th colspan="2">Хамгаалалтын малгай</th> </tr> <tr> <td>Тийм</td> <td>1</td> </tr> <tr> <td>Үгүй</td> <td>2</td> </tr> </table>	Хамгаалалтын малгай		Тийм	1	Үгүй	2
Хамгаалалтын малгай							
Тийм	1						
Үгүй	2						
<p>В6. Зам тээврийн осолд хичнээн хүн өртсөн</p>	<p>Зам тээврийн осолд өртөгсөдийн тоог бөглөхдөө тухайн үед хичнээн хүн осолд өртсөнийг тохирох нүдэнд бөглөнө.</p> <p>Жишээ нь: Зам тээврийн ослын үед 5 хүн гэмтсэн гэх мэт</p> <table border="1" data-bbox="467 1472 1292 1604"> <tr> <td><b>Зам тээврийн осолд өртөгсдийн тоо</b></td> <td>1</td> <td>2</td> <td>3</td> <td>4_өөс дээш</td> </tr> </table>	<b>Зам тээврийн осолд өртөгсдийн тоо</b>	1	2	3	4_өөс дээш	
<b>Зам тээврийн осолд өртөгсдийн тоо</b>	1	2	3	4_өөс дээш			
<p>Г. Хүн хоорондын хүчирхийллийн мэдээлэл Г1. Хүчирхийллийн хэлбэр</p>	<p>Хүчирхийлэл үүсгэсэн хэлбэрийг тодруулж бөглөхдөө /1-6, 98-99-р дугаараас сонгож/ зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Дурьдсанаас бусад хэлбэрийн хүчирхийллээр үйлдэгдсэн бол -98 гэсэн нүдийг бөглөөд ямар хэлбэрийн хүчирхийлэлд өртсөнийг тодорхой бичнэ. Хэрэв тухайн хүн огт мэдэхгүй байх эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй-99 гэж тэмдэглэнэ.</p> <p>Жишээ нь: Эрүүлжүүлэхийн байранд цагдаад зодуулсан гэх мэт.</p>						

	<table border="1"> <tr> <td>Эдийн засгийн хэлбэр</td> <td>4</td> </tr> <tr> <td>Хууль хяналтын байгууллагын дарамт</td> <td>5</td> </tr> <tr> <td>Хар тамхитай холбоотой</td> <td>6</td> </tr> </table>	Эдийн засгийн хэлбэр	4	Хууль хяналтын байгууллагын дарамт	5	Хар тамхитай холбоотой	6		
Эдийн засгийн хэлбэр	4								
Хууль хяналтын байгууллагын дарамт	5								
Хар тамхитай холбоотой	6								
Г2. Хүчирхийлэлд хэрэглэсэн зүйл, арга	<p>Хүчирхийлэлд өртөх үед хүчирхийлэгчийн ашигласан зүйлийг бөглөхдөө /1-12, 98-99-р дугаараас сонгож/ зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Дурьдсанаас бусад зүйлийг ашигласан бол-98 гэсэн нүдийг бөглөөд ямар зүйлс ашигласныг тодорхой бичнэ.Хэрэв тухайн хүн огт мэдэхгүй эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу-99 гэж нүдэнд тэмдэглэнэ.</p> <p>Жишээ нь: Хүчирхийлэх үедээ халуун зүйлээр түлсэн гэх мэт.</p> <table border="1"> <tr> <td>Галт зэвсэг,буугаар/Х93-95/</td> <td>3</td> </tr> <tr> <td>Тэсрэх дэлбэрэх зүйлээр халдах /Х96/</td> <td>4</td> </tr> <tr> <td>Утаа, гал дөлөөр түлэх /Х98/</td> <td>5</td> </tr> </table>	Галт зэвсэг,буугаар/Х93-95/	3	Тэсрэх дэлбэрэх зүйлээр халдах /Х96/	4	Утаа, гал дөлөөр түлэх /Х98/	5		
Галт зэвсэг,буугаар/Х93-95/	3								
Тэсрэх дэлбэрэх зүйлээр халдах /Х96/	4								
Утаа, гал дөлөөр түлэх /Х98/	5								
Г3. Хүчирхийлэлд хэдэн хүн оролцсон	<p>Хэдэн хүчирхийлэгч оролцсоныг бөглөхдөө зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж бөглөнө.</p> <p>Жишээ нь: Нөхөртөө зодуулсан гэх мэт.</p> <table border="1"> <tr> <td colspan="2"><b>Г3 Хэдэн хүчирхийлэгч оролцсон бэ?</b></td> </tr> <tr> <td>нэг</td> <td>1</td> </tr> <tr> <td>хоёр</td> <td>2</td> </tr> <tr> <td>гурав</td> <td>3</td> </tr> </table>	<b>Г3 Хэдэн хүчирхийлэгч оролцсон бэ?</b>		нэг	1	хоёр	2	гурав	3
<b>Г3 Хэдэн хүчирхийлэгч оролцсон бэ?</b>									
нэг	1								
хоёр	2								
гурав	3								
Г4. Хүчирхийлэл үзүүлэгчийн хүйс	<p>Гол хүчирхийлэгчийн хүйсийг тэмдэглэхдээ хүйс эрэгтэй бол-1, эмэгтэй бол-2, хэрэв тухайн хүн огт мэдэхгүй эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу-99 гэж зохих нүдэнд бөглөнө.</p>								
Г5. Хүчирхийлэгч хохирогч хоорондын холбоо	<p>Хүчирхийллийн хохирогч болон хохироогч хоёрын хоорондын холбоо хамаарлыг бөглөхдөө /1-7, 98-99-р дугаараас сонгож/ зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Дурьдсанаас бусад холбоо хамаарал байгаа бол-98 гэсэн нүдийг бөглөөд ямар хамааралтайг тодорхой бичнэ. Хэрэв тухайн хүн огт мэдэхгүй эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу-99 гэж нүдэнд тэмдэглэнэ.</p> <p>Жишээ нь: Хойд эцэг нь зодсон гэх мэт.</p>								

	<table border="1" data-bbox="760 205 1242 403"> <tr> <td data-bbox="760 205 1133 331">Эх эцэг</td> <td data-bbox="1133 205 1242 331" style="text-align: center;">2</td> </tr> <tr> <td data-bbox="760 331 1133 403">Бусад хамаатан</td> <td data-bbox="1133 331 1242 403" style="text-align: center;">3</td> </tr> </table>	Эх эцэг	2	Бусад хамаатан	3		
Эх эцэг	2						
Бусад хамаатан	3						
<p>Д. Амиа хорлох, санаатай өөрийгөө гэмтээх осол гэмтлийн мэдээлэл</p> <p>Д1. Амиа хорлоход хүргэсэн хэлбэр</p>	<p>Амиа хорлохыг завдах үедээ хэрэглэсэн арга, зүйлсийг бөглөхдөө /1-20, 98-99-р дугаараас сонгож/ зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Дурьдсанаас бусад зүйлийг ашигласан бол-98 гэсэн нүдийг бөглөөд ямар зүйлс ашигласныг тодорхой бичнэ. Хэрэв тухайн хүн огт мэдэхгүй эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу-99 гэж нүдэнд тэмдэглэнэ.</p> <p>Жишээ нь: өөрийгөө шилээр зүссэн гэх мэт.</p> <table border="1" data-bbox="727 772 1138 976"> <tr> <td data-bbox="727 772 1068 842">Иртэй зүйлээр</td> <td data-bbox="1068 772 1138 842" style="text-align: center;">6</td> </tr> <tr> <td data-bbox="727 842 1068 911">Мохоо зүйлээр</td> <td data-bbox="1068 842 1138 911" style="text-align: center;">7</td> </tr> <tr> <td data-bbox="727 911 1068 976">Өндрөөс үсрэх /Х80/</td> <td data-bbox="1068 911 1138 976" style="text-align: center;">8</td> </tr> </table>	Иртэй зүйлээр	6	Мохоо зүйлээр	7	Өндрөөс үсрэх /Х80/	8
Иртэй зүйлээр	6						
Мохоо зүйлээр	7						
Өндрөөс үсрэх /Х80/	8						
<p>Д2. Өөрийгөө гэмтээхдээ хэрэглэсэн зүйл</p>	<p>Өөрийгөө гэмтээх, амиа хорлоход нөлөөлсөн хүчин зүйлсийг бөглөхдөө /1-8, 98- 99-р дугаараас сонгож/ зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Дурьдсанаас бусад холбоо хамаарал байгаа бол-98 гэсэн нүдийг бөглөөд ямар хамааралтайг тодорхой бичнэ. Хэрэв тухайн хүн огт мэдэхгүй эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу-99 гэж нүдэнд тэмдэглэнэ.</p> <p>Жишээ нь: Шашин шүтлэгтэй холбоотой өндрөөс унасан гэх мэт.</p> <table border="1" data-bbox="701 1356 1330 1558"> <tr> <td data-bbox="701 1356 1219 1425">Гэр бүлийн гишүүд маргалдах</td> <td data-bbox="1219 1356 1330 1425" style="text-align: center;">7</td> </tr> <tr> <td data-bbox="701 1425 1219 1495">Ажлын байрны дарамт</td> <td data-bbox="1219 1425 1330 1495" style="text-align: center;">8</td> </tr> <tr> <td data-bbox="701 1495 1219 1558">Бусад ___ <i>шашин шүтлэг</i></td> <td data-bbox="1219 1495 1330 1558" style="text-align: center;">98</td> </tr> </table>	Гэр бүлийн гишүүд маргалдах	7	Ажлын байрны дарамт	8	Бусад ___ <i>шашин шүтлэг</i>	98
Гэр бүлийн гишүүд маргалдах	7						
Ажлын байрны дарамт	8						
Бусад ___ <i>шашин шүтлэг</i>	98						
<p>Е. Осол гэмтлийн талаарх тусгай тэмдэглэл</p> <p>Е1. Тусгай тэмдэглэл</p>	<p>Осол гэмтлийн талаарх тусгай тэмдэглэлийг бөглөхдөө_тухайн осол гэмтлийн талаарх онцгой, өвөрмөц тохиолдлын дүр зургийг дэлгэрэнгүй бичнэ.</p> <p>Жишээ нь: Нохойд хазуулж гэмтсэн тохиолдолд эзэнтэй эсвэл гудамжны нохойд хазуулсан эсэхийг тодруулж бичих гэх мэт гэмтэл тус бүрт нэмэлт мэдээллийг тэмдэглэнэ.</p>						
<p>Е2. Гэмтлийн онош</p>	<p>Гэмтлийн оношийн хэсгийг бөглөхдөө эмч клиникийн үндсэн оношийг дэлгэрэнгүй, бүрэн гүйцэд, гаргацтай бичнэ.</p>						

Е3. Шилжүүлсэн хэлбэр	Гэмтсэн хүнийг эмнэлгийн аль хэсэг рүү шилжүүлснийг бөглөхдөө зохих нүдийг дугуйлна. Жишээ нь: Тасаг руу бол-1, Дүүргийн ЭМТ рүү бол-5
Е4. Авсан арга хэмжээ	Гэмтсэн хүнд авсан арга хэмжээг бөглөхдөө үзлэгийн эмчийн хийсэн эмчилгээний болон оношлогооны бүхий л үйлдлийг тэмдэглэнэ.
Е5. Эмчийн гарын үсэг	Эмчийн гарын үсгийг бөглөхдөө маягт бөглөсөн эмч гарын үсгээ зурж, хувийн тамга тэмдгээ дарж баталгаажуулна.

### Түлэгдлийн шалтгаантай осол гэмтлийг бүртгэх нэмэлт хуудас СТ-34

“Түлэгдэлтийн шалтгаант осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх нэмэлт хуудас” маягтыг түлэгдэлтийн улмаас **хэвтэн эмчлүүлж буй тохиолдол** бүрт эмчлэгч эмч хөтөлнө.

А. Паспортын хэсэг							
Асуумж	Тодорхойлолт, жишээ						
A1. Эмнэлгийн нэр	Эмнэлгийн нэрийг бичихдээ эмнэлгийн нэр гэсэн 6 нүдний эхний 2 нүдэнд аймаг хотын, дараагийн 2 нүдэнд сум, дүүргийн, сүүлийн 2 нүдэнд эмнэлгийн шифрийг тус тус бичнэ. Жишээ нь: Баянхонгор аймгийн Галуут сумын эмнэлэг <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <tr> <td>0</td> <td>3</td> <td>1</td> <td>1</td> <td>0</td> <td>3</td> </tr> </table>	0	3	1	1	0	3
0	3	1	1	0	3		
A2. Эцэг /эх/-ийн нэр	Осол гэмтэлд өртсөн хүний эцэг /эх/ -ийн нэрийг бичнэ						
A3. Нэр	Осол гэмтэлд өртсөн хүний өөрийн нэрийг бичнэ.						
A4. Регистрийн дугаар	Гэмтсэн хүний регистрийн дугаарыг бичих ба хүснэгтийн эхний 2 нүдэнд үсэг, дараагийн 8 нүд тус бүрт нэг цифр байхаар тохируулж бичнэ.						
A5. Нас	Насыг кодлохдоо нүд тус бүрд нэг цифр бичнэ. 1 нас хүрээгүй хүүхдийн насыг сараар, нярай хүүхдийг өдрөөр бичиж шифрийн ар талд сар, өдрийн аль нь болохыг тодотгож бичнэ. Тухайлбал: 11 настай гэвэл: 11 нас, харин 11 сартай гэвэл 11 сар, 11 өдөртэй гэвэл 11өдөр гэнэ. Жишээ нь. 11 сартай <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <tr> <td>1</td> <td>1</td> <td>сар</td> </tr> </table> гэх мэт.	1	1	сар			
1	1	сар					
A6. Хүйс	Хүйсийг тэмдэглэхдээ хүйс эрэгтэй бол-1, эмэгтэй бол-2, хэрэв тухайн хүн огт мэдэхгүй эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу-99 гэж зохих нүдэнд бөглөнө.						
A7. Тогтмол хаяг	Тогтмол хаяг гэсэн нүдэнд тухайн хүний байнга оршин суугаа газрын засаг захиргааны нэгжийн харъяалалаар бичнэ. Эхлээд аймаг /хотын/, дараа нь сум, /дүүргийн/, сүүлд нь хороо /багийг/, гудамж /байрны/, хаалганы дугаарыг бичнэ Жишээ нь: Архангай аймгийн, Ихтамир сумын, 1-р баг, тайхрын 2-р гудамж 12 тоот						

А8. Утасны дугаар	Гэмтсэн хүний утасны дугаар болон ар гэртэй нь холбоо барих утасны дугаарыг бичнэ.					
А9. Ажлын газар, албан тушаал	Гэмтсэн хүний ажлын газар, албан тушаал, мэргэжлийг бичнэ.					
А10. Боловсрол	Гэмтсэн хүний боловсролыг бөглөхдөө бага-1, дунд-2, мэргэжил-техникийн-3, дээд - 4, боловсролгүй-5 гэж харалдаа зохих нүдэнд бөглөнө.					
А11. Асран хамгаалагч /сахиур/	Түлэгдсэн үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэж байхдаа сахиулсан сахиурын мэдээлэл орно. Жишээ нь: Эцэг эх нь сахисан бол-1, хэрвээ заасан жагсаалтад дурдаагүй сахиуртай бол бусад-98 гээд тайлбарыг бичнэ. Жнь: өвөө нь гэх мэт					
А12. Түлэгдэх үед хэнтэй хамт байсан бэ?	10 наснаас доош настай үйлчлүүлэгч бол түлэгдэж гэмтэх үедээ хэнтэй хамт байсныг тохирох кодоор тэмдэглэнэ. Жишээ нь: ганцаараа байсан бол-1, эцэг эхийн хамт байсан бол-2 гэх мэт					
А13. Түлэгдэлд өртсөн хүний тоо	Эмнэлгийн тусламж авч буй уг түлэгдлийн шалтгаантай осол гэмтэлд хэдэн хүн өртсөн бэ гэдгийг тодруулж бичнэ. Жишээ нь: Нэг хүн өртсөн бол-1 гэх мэт					
А14. Түлэгдсэн он сар өдөр	Гэмтэл авсан он, сар, өдөр, цаг, минутыг бөглөхдөө эхний 1 нүдэнд оныг, 2-р нүдэнд сарыг, 3-р нүдэнд өдрийг, 4-р нүдэнд цагийг, 5-р нүдэнд минутыг тус тус бичнэ. Жишээ нь: Гэмтсэн хүн 2011 оны 7 сарын 6-ны 24 цаг 5 минутанд гэмтсэн гэх мэт. <table border="1" data-bbox="925 982 1279 1050"> <tr> <td>11</td> <td>07</td> <td>06</td> <td>24</td> <td>05</td> </tr> </table>	11	07	06	24	05
11	07	06	24	05		
А15. Эмнэлэгт үзүүлсэн он сар өдөр	Энэ гэмтлээр эмнэлэгт хандсан он, сар, өдөр, цаг, минутыг бөглөхдөө эхний 1 нүдэнд оныг, 2-р нүдэнд сарыг, 3-р нүдэнд өдрийг, 4-р нүдэнд цагийг, 5-р нүдэнд минутыг тус тус бичнэ. Жишээ нь: Гэмтсэн хүн 2011 оны 7 сарын 6-ны 16 цаг 35 минутанд үзүүлсэн гэх мэт. <table border="1" data-bbox="938 1239 1292 1306"> <tr> <td>11</td> <td>07</td> <td>06</td> <td>16</td> <td>35</td> </tr> </table>	11	07	06	16	35
11	07	06	16	35		
А16. Эмнэлэгт хэвтсэн он сар өдөр	Энэ гэмтлээр эмнэлэгт хандсан он, сар, өдөр, цаг, минутыг бөглөхдөө эхний 1 нүдэнд оныг, 2-р нүдэнд сарыг, 3-р нүдэнд өдрийг, 4-р нүдэнд цагийг, 5-р нүдэнд минутыг тус тус бичнэ. Жишээ нь: Гэмтсэн хүн 2011 оны 7 сарын 6-ны 16 цаг 35 минутанд үзүүлсэн гэх мэт. <table border="1" data-bbox="938 1491 1292 1558"> <tr> <td>11</td> <td>07</td> <td>06</td> <td>16</td> <td>35</td> </tr> </table>	11	07	06	16	35
11	07	06	16	35		
А17. Түлэгдэлд өртөхөд нөлөөлсөн хүчин зүйл	Түлэгдэлд өртөхөд нөлөөлсөн эрүүл мэндийн болоод бусад хүчин зүйлийг тодруулан тэмдэглэнэ. Жишээ нь түлэгдэх үедээ согтууруулах мансууруулах бодис хэрэглэсэн байсан бол-2 гэх мэт					
А18. Бусад эрхтний талаас хавсарсан гэмтэл	Түлэгдэж гэмтэх үед бусад эрхтэн тогтолцоонд давхар авсан гэмтэл байгаа бол энэ хэсэгт тодруулж бичнэ. Жишээ нь: Түлэгдэх үедээ давхар аль нэг ясны хугарал авсан бол-5 гэх мэт					

<p>A19. Осол болсон цэгийн нэр, байршил</p>	<p>Осол хаана болсон цэгийн нэрийг бөглөхдөө тухайн осол болсон дүүрэг, хороо, осол болсон газрын нэрийг дэлгэрэнгүй бичнэ.</p> <p>Жишээ нь:</p> <div style="border: 1px solid black; padding: 5px; margin-left: 200px;">СХД, 10 хороо, Гурвалжингийн тойрог</div>
<p><b>Б. Түлэгдлийн байршил тодорхойлох хэсэг</b></p>	
<p>Асуумж</p>	<p>Тодорхойлолт, жишээ</p>
<p>B1. Биеийн хэдэн хувь түлэгдсэн бэ?</p>	<p>Эмчлэгч эмч түлэгдлийн хувийг тодорхойлсон байдлаар энэ хэсэгт тэмдэглэнэ. Жишээ нь: Биеийн 15 хувь түлэгдсэн бол 15% гэх мэт</p>
<p>B2. Амьсгалын зам гэмтсэн эсэх</p>	<p>Амьсгалын зам гэмтсэн бол -1, гэмтээгүй бол-2 гэж тэмдэглэнэ.</p>
<p>B3-B7 Түлэгдлийн байршил</p>	<p>Түлэгдлийн байршлыг нарийвчлан тодорхойлж тэмдэглэнэ. Их бие, толгой хүзүү, гар, хөл, сарвууны хэсэгт байрлах түлэгдлийн байршлыг нарийн тодорхойлж бичнэ. Жишээ нь: өгзөг хэсэгт түлэгдсэн бол B3. Их бие гэсэн хэсгийн 4 гэсэн кодыг сонгоно.</p>
<p><b>В-Ж. Түлэгдлийн шалтгаан тодорхойлох хэсэг</b></p>	
<p>Асуумж</p>	<p>Тодорхойлолт, жишээ</p>
<p><b>В. Түлэгдсэн зүйл</b></p>	
<p>B1. Халуун гадаргуу</p>	<p>Ямар нэг халуун гадаргуунд хүрэлцэж түлэгдсэн тохиолдолд тодруулж тэмдэглэнэ. Жишээ нь: Хоол хийх хэрэгслийн халуун гадаргуунд хүрэлцэж түлэгдсэн бол-1 гм</p>
<p>B2. Халуун хий шингэн</p>	<p>Халуун шингэнд түлэгдсэн бол энэ хэсгийн бөглөх ба хоол хийх үйл ажиллагаатай холбоотой түлэгдсэн бол Г хэсгийг бөглөнө. Жишээ нь халуун ууранд түлэгдсэн бол-1, халуун хоолонд түлэгдсэн бол 2-ыг дугуйлаад Г хэсгийг дэлгэрүүлж тэмдэглэнэ.</p>
<p>B3. Цахилгааны түлэгдэл</p>	<p>Цахилгаанд түлэгдсэн үед тэмдэглэнэ. Жишээ нь өндөр хүчдэлд түлэгдсэн бол-3 гэх мэт</p>
<p>B4. Химийн түлэгдэл</p>	<p>Химийн бодист түлэгдсэн бол химийн бодис нь гэр ахуйн хэрэглээний эсвэл мэргэжлийн ажилтай холбоотой химийн бодис байсан эсэхийг тодорхойлж бичнэ. Гэр ахуйн бол-1 гэх мэт /уксус/</p>
<p>B5. Үрэлтийн түлэгдэл</p>	<p>Түлэх нөлөө бүхий бодисоор амьсгалах, арьс салстад хүрэлцэж түлэгдсэн үед энэ хэсэгт тэмдэглэнэ. Жишээ нь амьсгалын замын түлэх үйлчилгээтэй бодисоор амьсгалж түлэгдсэн бол-1 гэх мэт</p>
<p>B6-B8 хэсэг Галд түлэгдсэн түлэгдэл</p>	<p>Гэр ахуйн орчинд галд өртсөн үед энэ хэсгийг хөтлөнө. Жишээ нь хоол хийх үед гарсан галд өртсөн бол-1 гэх мэт Халаалтын хэрэгсэлтэй холбоотой</p>

В6. Гэр ахуйн орчинд галд өртөх	галд өртсөн бол Д, Гэрэлтүүлэх хэрэгсэлтэй холбоотой галд өртсөн бол Е, Санаатайгаар гаргасан галд өртсөн бол Ж хэсгийг дэлгэрүүлэн тэмдэглэнэ.
В7. Мэргэжлээс шалтгаалах галд өртөх	Ажил мэргэжилтэй холбоотой галд өртсөн тохиолдолд энэ хэсэгт тэмдэглэнэ. Жишээ нь Хоол үйлдвэрлэлийн үед гарсан галд өртсөн бол-1 гэх мэт
<b>Г. Хоол хийх, бэлтгэх үед түлэгдсэн тохиолдлыг тодруулах хэсэг</b>	
Г1. Хоол хийх, бэлтгэх үед юунд түлэгдсэн?	Хоол хийх бэлтгэх явцад түлэгдсэн бол юунд түлэгдсэнийг тодруулж тэмдэглэнэ. Жишээ нь: Халуун тогоонд түлэгдсэн бол-4 гэх мэт
Г2. Хоол бэлтгэх үйл явцтай холбоотой түлэгдэх үед болсон үйл явдал	Хоол бэлтгэх үйл явцтай холбоотой түлэгдэх үед болсон үйл явдлыг нарийвчлэн тодруулж тэмдэглэнэ. Жишээ нь дотор нь унаж түлэгдсэн бол-2 гэх мэт
Г3. Саванд байсан зүйл	Саванд байсан түлэгдэлтэд хүргэсэн бодисын тодруулж тэмдэглэнэ. Саванд халуун сүү байсан бол-1 гэх мэт
Г4. Хоол хийх талбайн өндөр	Хоол хийдэг зуух, цахилгаан зуух зэрэг нь хэр хэмжээний өндөрт байрладаг болохыг тодруулж бичнэ. Жишээ нь газар байдаг бол-1 гэх мэт
Г5. Хоол хийдэг газар нь амьдрах хэсгээс тусдаа эсэх	Хоол хийдэг хэсэг нь амьдрах хэсгээс тусдаа байрладаг эсэхийг тодруулж тэмдэглэнэ. Жишээ нь гэрт амьдардаг бол үгүй буюу-2, орон сууцанд амьдардаг галын өрөө тусдаа бол-1, гал тогоо зочны өрөө хамт бол-2 гэх мэт
<b>Д. Халаалтын хэрэгсэлтэй холбоотой түлэгдэлтийн үед тодруулах хэсэг</b>	
Д1. Гэрийн халаалтын улмаас гал гарах	Гэрийн халаалтын хэрэгсэлтэй холбоотой гал гарсан бол ямар үйл явцын улмаас гарсан болохыг тодруулж тэмдэглэнэ. Жишээ нь Халаалтын хэрэгсэл залгасан залгуур, утаснаас гал гарсан бол-4 гэх мэт
Д2. Халаалтын эх үүсвэр	Халаалтын хэрэгсэлд ашиглаж байсан галын эх үүсвэрийг тодруулж бичнэ. Жишээ нь Мод нүүрс түлж байсан бол-1, цахилгаан хэрэгслээс гарсан гал бол-5 гэх мэт
<b>Е. Гэрийн гэрэлтүүлгийн хэрэгсэлтэй холбоотой түлэгдэлтийн үед тодруулах хэсэг</b>	
Е1. Гэрийн гэрэлтүүлгийн улмаас гал гарах	Гэрийн гэрэлтүүлгийн хэрэгсэлтэй холбоотой гарсан галд өртсөн үед энэ хэсгийг тодруулан тэмдэглэнэ. Жишээ нь: Гэрэл болон лаа дэнлүүний орчимд байсан материалд галд авалцсан улмаас гарсан галд түлэгдсэн бол-1 гэх мэт
Е2. Гэрэлтүүлгийн хэрэгслийн төрөл	Гал гарах шалтгаан болсон гэрэлтүүлгийн хэрэгслийн төрлийг тодруулж бичнэ. Жишээ нь: Лаа байсан бол-1, цахилгаан хэрэгсэл байсан бол-2 гэх мэт

<b>Ж. Санаатай үйлдэл байсан тохиолдолд тодруулах хэсэг</b>	
Ж1. Санаатайгаар түлсэн шалтгаан	Санаатайгаар өөрийгөө болон бусдыг түлж гэмтээсэн тохиолдолд энэ хэсгийг тодруулан тэмдэглэнэ. Жишээ нь санаатайгаар өөрийгөө түлсэн бол-1, бусдыг түлсэн бол-2 гэх мэт
Ж2. Учир битүүлэг байдалтай түлэгдсэн тохиолдолд эмнэлзүйн шинж	Учир битүүлэг тохиолдлын үед Санаатай үйлдэл байх эмнэлзүйн шинж тэмдэг байгаа эсэхийг тодорхойлж тэмдэглэнэ. Өндөр магадлалтай бол-1, тодорхойлох боломжгүй бол мэдэхгүй-99 гэх мэт
Ж3. Санаатайгаар түлэгдэлтэд хүргэсэн шалтгааны эх үүсвэр	Гал гаргахад ашигласан зүйлийн эх үүсвэрийг тодорхойлон тэмдэглэнэ. Жишээ нь: Нүүрс бол-3, мод бол-7 гэх мэт
Түлэгдлийн шалтгаан	Түлэгдэлтэд хүргэсэн шалтгааныг өвчний олон улсын 10-р ангиллын дагуу үгээр бичих болон кодоор тэмдэглэнэ. Жишээ нь:Халуун хоол, цайнд түлэгдсэн бол Х10, Шатамхай биет шатахад түлэгдсэн бол Х04, Цахилгаан гүйдэл дамжуулах шугаманд өртөж түлэгдсэн бол W85 гэх мэт
Түлэгдлийн онош	Түлэгдсэн гэмтсэн өвчтний оношийн өвчний олон улсын 10-р ангиллын дагуу үгээр бичих болон кодоор тэмдэглэнэ. Их бие халууны ба химийн үйлчлэлээр түлэгдсэн бол Т21, бугуй сарвуу халууны ба химийн үйлчлэлээр түлэгдсэн Т23 гэх мэт
Авсан арга хэмжээ	Түлэгдэлтийн улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчид хийгдсэн эмчилгээний болон оношлогооны бүхий л үйлдлийг эмчлэгч эмч тэмдэглэнэ.

### **Хөдөлгөөн засал эмчилгээний хуудас AM-34**

Хөдөлгөөн засал эмчилгээний хуудсыг сэргээн засах эмчилгээний тасаг нэгжид хөдөлгөөн засалчийн мэргэжил эзэмшсэн мэргэжилтэн хөтөлнө.

1. Бүртгэлийн хэсэгт овог нэр, нас, хүйс, гэрийн хаяг, амьдралын нөхцөл /орон сууц, байшин, гэр г.м/, ажил эрхлэлт /ажил эрхэлдэг, группт, тэтгэвэрт г.м/, ажлын орчин нөхцөл /хүнд, хортой, хэвийн, мэргэжил, удаан суудаг, зогсоо ажилтай, хүнд юм өргөдөг г.м/-ээр хөдөлгөөний идэвхтэй байдлыг асууж бичнэ.
2. Өвчтөнд одоо байгаа зовуурь, өвчин үүссэн шалтгаан, MRI, CP, X-Ray шинжилгээний дүгнэлтийг бичнэ.
3. Үндсэн оношийг олон улсын өвчний Х ангиллын дагуу, хөдөлгөөн засалчийн оношийг олон улсын үйлийн ангиллын дагуу бичнэ
4. Өвчин эхэлсэн хугацаа, эмнэлэгт үзүүлсэн буюу хэвтсэн, хөдөлгөөн засал эмчилгээ эхэлсэн ба дууссан зэрэг огноог тэмдэглэнэ.

5. Үйлчлүүлэгчид өвдөлт байгаа эсэх, өвдөлтийн хүчийг баллаар, байрлалыг зурган дээр тэмдэглэнэ.
6. Өдөр тутмын үйл ажиллагааны чадвар /Modified Barthel Index/-ыг хүснэгт дэх асуултын дагуу бөглөнө. Үйлдлийг гүйцэтгэж чадна, чадахгүй, бүрэн бие даасан зэрэг үнэлгээгээр өдөр тутамд зайлшгүй хийгдэх үйл ажиллагаанууд /хувийн ариун цэвэр, усанд орох, хооллох г.м/ өөртөө үйлчлэх чадвар тус бүрийг үнэлж, нийт оноог 0-100 баллаар дүгнэнэ.
7. Төрх байдлын анализ: үйлчлүүлэгчийн зогсох байрлал, суух байрлалыг урдаас, хажуунаас, араас харсан байдлаар дүгнэнэ.
8. Алхааны анализ: үйлчлүүлэгчийг алхуулж үнэлнэ. Алхах чадваргүй бол тухайн байдал /тэргэнцэртэй г.м/-ыг бичнэ.
9. Үений далайц, булчингийн хүчний хэмжилтийг хийхдээ том, жижиг үе хэмжигч гонометрийн тусламжтайгаар хэвтээ ба суугаа байрлалд үеийг тогтвортой байдалд хөдөлгөөн тус бүрийг хийлгэж, градусаар хэмжиж, хүснэгтэнд тус бүрд нь тэмдэглэнэ.
10. Тухайн үйлчлүүлэгчийн хөдөлгөөний алдагдал, бие даах чадварын бэрхшээлүүдийг тодорхойлж жагсааж бичнэ.
11. Үйлчлүүлэгч эсвэл асран хамгаалагчтай нь ярилцан тухайн хүний хийж чадахыг хүсч байгаа үйлдэл, чадварыг сонгон бэрхшээлтэй асуудалд тохирсон эмчилгээний үр дүнд хүрэх урт болон богино хугацааны эмчилгээний зорилго, хугацааг тодорхойлж бичнэ.
12. Урт болон богино хугацааны зорилгодоо хүрэхийн тулд эмчилгээний төлөвлөгөө боловсруулна.

### **Хөдөлмөр засал эмчилгээний хуудас AM-35**

Хөдөлмөр засал эмчилгээний хуудсыг сэргээн засах эмчилгээний тасаг нэгжийн хөдөлмөр засалчийн мэргэжил эзэмшсэн мэргэжилтэн хөтөлнө.

1. Бүртгэлийн хэсэгт овог нэр, нас, хүйс, өвчний түүхийн дугаар бичнэ.
2. Оношийг олон улсын үйлийн ангилал /ICF/-ын дагуу бичнэ.
3. Өдөр тутмын үйл ажиллагааны чадвар /Modified Barthel Index/-ыг хүснэгт дэх асуултын дагуу бөглөнө. Үйлдлийг гүйцэтгэж чадна, чадахгүй, бүрэн бие даасан зэрэг үнэлгээгээр өдөр тутамд зайлшгүй хийгдэх үйл ажиллагаанууд /хувийн ариун цэвэр, усанд орох, хооллох г.м/ өөртөө үйлчлэх чадвар тус бүрийг үнэлж, нийт оноог 0-100 баллаар дүгнэнэ.
4. Үений далайц, булчингийн хүчний хэмжилтийг хийхдээ том, жижиг үе хэмжигч гонометрийн тусламжтайгаар хэвтээ ба суугаа байрлалд үеийг хөдөлгөөнгүй тогтвортой байдалд хөдөлгөөн тус бүрийг хийлгэж, градусаар хэмжиж, хүснэгтэнд тус бүрд нь тэмдэглэнэ.
5. Тухайн үйлчлүүлэгчийн биемахбод болон танин мэдэхүйн бэрхшээлүүдийг тодорхойлж жагсааж бичнэ.
7. Үйлчлүүлэгч эсвэл асран хамгаалагчтай нь ярилцан тухайн хүний хийж чадахыг хүсч байгаа үйлдэл, чадварыг сонгон бэрхшээлтэй асуудалд тохирсон эмчилгээний үр дүнд хүрэх урт болон ойрын хугацааны эмчилгээний зорилго, хугацааг тодорхойлж бичнэ.
8. Урт, ба ойрын хугацааны зорилгодоо хүрэхийн тулд эмчилгээний төлөвлөгөө боловсруулна.

Яаралтай тусламжийн хуудас хөтлөх ерөнхий аргачилал:

1. Яаралтай тусламжийн хуудсыг төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн яаралтай тусламжийн хэсгээр үйлчлүүлсэн хүн бүрд хөтлөнө.
2. Яаралтай тусламжийн хуудсыг 2 хувь үйлдэн нэг хэсгийг өвчтөн түүний ар гэрийнхэнд нэг хувийг нь тухайн эмнэлгийн авч архивлана.
3. Тухайн ЭМБ-ийн лого болон дардасийг хуудасны зүүн дээд буланд байрлуулна.
4. Хуудасны дугаарлалт дахин давтагдахгүй, өвчтөн хүлээн авсан бүртгэлийн дугаартай тохирч байх (жич: хуудасны дугаар тухайн жил буюу 2018 он, жилийн эхнээс нэг гэж тоологдоно. №-18/0001)
5. Ерөнхий мэдээллийн хэсэг.
  - a. Өвчтөний овог нэрийг бүрэн гүйцэт тод гаргацтай бичнэ.
  - b. Регистерийн дугаарыг заавал бичнэ. Тухайн хүн ухаангүй эсвэл гадаад иргэн байвал шалтгааныг бичнэ.
  - c. Эрүүл мэндийн даатгалын дэвтэрийг дугаарыг бүрэн гүйцэт бөглөнө.
  - d. Харьяалал болон хаягийн бүртгэлийг дэлгэрэнгүй бүртгэх
  - e. 72 цагийн дотор давтан үйлчлүүсэн тохиолдолд тохирох хэсгийг заавал бүртгэх
  - f. Осол гэмтлийн асуумжтай тохиолдолд цагдаад мэдэгдсэн эсэхийг тодруулж тэмдэглэл хөтөлсний дараа мэдэгдээгүй тохиолдолд заавал цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.
  - g. Осол гэмтлийн шалтгаан, газар, цаг хугацаа, анхны тусламж үзүүлсэн эсэх, үзүүлсэн хүний нэр албан тушаал, авсан арга хэмжээний талаар тэмдэглэлд тусгана.
  - h. Тухайн өвчтөний ирэх үеийн зовиурыг товч тодорхой бичнэ.
6. Анхны үзлэг: эрэмбэлэн ялгалтын мэргэжилтэн анхны үнэлгээг түргэн шуурхай бодиттой гарганэ.
7. Эрт сэрэмжлүүлэх үнэлгээ: тухайн үнэлгээг эрт сэрэмжлүүлэх үнэлгээний дагуу үнэлнэ.
8. Тархвар зүйн асуумжийг заавал гүйцэт бөглөнө.
9. Дээрхийг үнэн зөв бөглөсөн дохиолдолд эрэмбэлэн ялгалтын мэргэжилтэн баталгаажуулж нэрээ гаргацтай татлахгүй бичнэ.
10. Урьдчилсан оношыг тавьж ӨОУА-10-аар код тавьж гарын үсэн зурж баталгаажуулна.

## Стационарт хөтлөгдөх анхан шатны маягтуудын хөтлөх заавар

### Өвчний түүх СТ-1

**ТОДОРХОЙЛОЛТ:** Өвчний түүх хөтлөлт гэдэг нь эмчлүүлэгчид хийгдэж буй оношилгоо, эмчилгээний явц, үр дүнг тусгасан эрх зүйн баримт бичиг юм.

Өвчний түүхийн үндсэн хэсгийг хэвтэн эмчлүүлэх тасагтай бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад хөтлөх ба өвчний түүхийн нарийн мэргэжлийн эмчийн 12 хавсралтыг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын тухайн тасагт нэмэлтээр хөтлөнө.

### Өвчний түүх хөтлөхөд тавигдах ерөнхий шаардлага

1. Өвчний түүхийг **монгол хэл дээр**, нэг өнгийн бэхээр, гаргацтай бичнэ.
2. Эмнэлгийн мэргэжилтэн бүр нэрээ гаргацтай бичнэ.
3. Онош, нэр томъёог өвчний олон улсын ангилалаар, **англи- монгол** хэл дээр бичнэ.
4. Өвчний түүхэнд эмнэлгээс гарах, шилжих үеийн эпикриз, эмчлүүлэгчийн анамнез, бодит үзлэг, клиникийн урьдчилсан онош, клиникийн оношийн үндэслэл, өдөр тутмын үзлэг, өвчний явц үр дүн, эмчилгээний төлөвлөлт зэргийг тодорхой, ойлгомжтой үг хэллэгээр илэрхийлэн бичнэ.
5. Өдөр тутмын үзлэгийн тэмдэглэлд эмчлүүлэгчийн эмчилгээний үр дүнгийн өөрчлөлт, сайжиралт, эдгэрэлтийн болон хүндрэлийн динамик шалгууруудыг шинж тэмдэгээр, үзлэгээр, лабораторын үзүүлэлтээр оруулна.
6. Хөнгөн явцтай, урт хугацаагаар эмчлэгдэх өвчний үед 2 хоног тутамд үзлэгийн тэмдэглэл хөтөлж болно.
7. Хүнд эмчлүүлэгчийг үзлэг, оношилгоо, эмчилгээ хийсэн тухай бүрт тэмдэглэл хөтлөн цаг, минутыг заана.
8. Эмчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч заагдсан эмнэлгийн тусламж, үйлчилгээ, оношилгоо, эмчилгээнээс татгалзсан тохиолдолд бичгээр баталгаажуулна.
9. Тасгийн эрхлэгч нь төлөвлөгөөт журмаар хэвтсэн эмчлүүлэгчийг эмнэлэгт хэвтсэнээс хойш 2 өдрийн дотор, хүнд болон хүндэвтэр эмчлүүлэгчийг хэвтсэн өдөр нь үзнэ.
10. Тасгийн эрхлэгчийн тойрон үзлэгийг долоо хоногт 1-2 удаа хийж, өвчний түүхэнд үзлэг, эмнэлзүйн онош, оношийн үндэслэл, зөвлөгөө зэргийг тэмдэглэж, гарын үсгээр баталгаажуулна.
11. Зөвлөх эмч нарын үзлэгийн бичлэгт зөвлөх эмчийн мэргэжил, овог, нэр, үзлэг хийсэн өдөр, цаг, илэрсэн эмгэг өөрчлөлтүүд, эмнэл зүйн онош, зөвлөгөө зэргийг тусгана.
12. Эмч нарын хамтарсан үзлэгийн тэмдэглэлийг бичиж, оролцсон эмч бүрийн гарын үсгээр баталгаажуулах ба гарсан шийдвэрийг биелүүлнэ.
13. Резидент эмчийн гарын үсгийг эмчлэгч эмч баталгаажуулна.
14. Амь насанд эрсдэлтэй ажилбар хийхийн өмнө эмчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагчаас зөвшөөрөл авч, өвчний түүхэнд хавсаргана.
15. Өвчний түүхэнд хяналт-шинжилгээ, үнэлгээг жилд 2-оос доошгүй удаа хийх ба шаардлагатай үед түүвэрчилсэн хяналт шинжилгээ үнэлгээ хийнэ.
16. Өвчний түүхийн хуудас бүрийг статистикч эмч, бүртгэл мэдээллийн ажилтан дугаарлана.

### Бүртгэл:

- Энэ хэсгийг эмчлүүлэгч болон асран хамгаалагч, ар гэрийнхэнээс асуун бөглөх ба ажлын газар, албан тушаал, мэргэжил, гэрийн хаяг, хэвтэх үеийн оношийг ерөнхий шаардлагын дагуу гаргадахуйц, тодорхой бичнэ.

- Цусны бүлгийг тэмдэглэхдээ эмчлүүлэгчээс асуухаас гадна, цус сэлбэх эмчилгээ хийсэн тохиолдолд заавал баталгаажуулсан байна.

#### **Эмнэлгээс гарах, шилжих үеийн эпикриз:**

- Үндсэн онош, дагалдах оношийг ӨОУА-10, үйлдлийн оношийг ҮОУА-9-ийн дагуу англи-монгол хэл дээр гаргацтай бичин, хүндрэл, дагалдах өвчнийг тусгана.
- Эмчлэгч эмч солигдох, нэг тасгаас өөр тасагт шилжих бүрт шилжүүлэх дүгнэлт бичиж, гарын үсгээр баталгаажуулна.
- Өвчний төгсгөл, эмнэлгээс гарсан, шилжсэн, нас барсан байдлыг “√ “ тэмдэглэн, он сар, өдөр, ор хоног, эмчилгээний зардлыг тоогоор илэрхийлж, гаргацтай бичнэ.
- Эмнэлгээс гарах үеийн дүгнэлтэд хэвтэн эмчлүүлсэн өвчний түүхийг товч тусган, илэрч байсан шинж тэмдгүүдийн динамик, хийсэн эмчилгээ, түүний үр дүн, цаашид баримтлах дэглэм зэргийг өвчний түүх болон амбулаторын картанд /2 хувь/ бичиж эмчлэгч эмч, тасгийн эрхлэгч нар гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулна.
- Эмчлүүлэгч нас барсан тохиолдолд өвчний түүхэнд эмнэлзүйн төгсгөлийн дүгнэлтийг бичнэ. Төгсгөлийн дүгнэлтэнд өвчлөлийн түүх, шинж тэмдгүүдийн өөрчлөлт, оношилгооны зорилгоор хийгдсэн ажилбар, хийгдсэн эмчилгээ, нас барах үеийн эмнэл зүйн илрэлүүд, нас баралтын шалтгаан, эмнэл зүйн төгсгөлийн дэлгэрэнгүй онош зэргийг бичих ба нас барсан тухай гэрчилгээг хамт бичнэ.
- Эмчлэгч болон хянасан эмч гарын үсэг зурж баталгаажуулна.

#### **Эмчлүүлэгчийн анамнез:**

- Асуумжийг эмчлүүлэгч болон асран хамгаалагч, холбогдох хүнээс цуглуулна.
- Хэвтэх үеийн зовиурыг бичихдээ *гол, тулгуурлах, санаа авах* зовиуруудыг дараалуулан бичнэ.
- Өвчин эхэлсэн, сэдэрсэн огноо, явц, шинж тэмдэг, хэвтэхээс өмнө хийгдсэн эмчилгээний талаар тодорхой бичнэ.
- Эмчлүүлэгчийн амьдралын түүхэнд эмчлүүлэгчийн товч намтарыг тусган, өвчний оношилгоонд шаардагдах мэдээллийг тэмдэглэнэ.
- Мэс ажилбар, осол гэмтэл, удамшлын өвчний талаар тодорхой бичнэ.
- Бусад мэдээллийг асуумжийн дагуу “√ “ тэмдэглэнэ.

#### **Ерөнхий үзлэг:**

- Энэ хэсэгт асуумжийн дагуу “√ “ тэмдэглэнэ

#### **Бодит үзлэгийн хэсэг:**

- Өвчний түүх хөтлөх ерөнхий шаардлагын дагуу эрхтэн тогтолцооны үзлэгийг монгол хэл дээр, нэг өнгийн бэхээр, гаргацтай бичнэ.
- Өвчний онцлог, шалтгаанаас хамааран зарим эрхтэн тогтолцооны үзлэгийг илүү дэлгэрэнгүй хийж тэмдэглэл хөтөлнө.

#### **Клиникийн урьдчилсан онош:**

- Оношийг үндсэн, дагалдах гэсэн дарааллаар бичин, хүндрэлийг зааж өгнө.
- Энэ хэсэгт ялган оношлох эмгэгүүд ба хам шинжүүд, хийгдэх шинжилгээ, яаралтай хийгдэх эмчилгээг зааж өгөх ба эмч заавал гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

#### **Клиникийн оношийн үндэслэл:**

- Оношийн үндэслэлийг 3-5 хоногт багтаан бичиж, үндсэн ба дагалдах оношийг тавин, хүндрэлийг тусгана.
- Клиникийн оношийн үндэслэлийг зовиур, асуумж, бодит үзлэг, лабораторын шинжилгээ, үйл оношийн шинжилгээний гол дүгнэлтэд тулгуурлан гаргана.
- Эмчлүүлэгч нас барсан тохиолдолд эмнэлзүйн төгсгөлийн онош бичнэ. Эмнэл зүйн төгсгөлийн оношийг эмнэл зүйн шинж тэмдэг, явцын онцлогийг тусган үндсэн өвчин,

түүний хүндрэл, дагалдах өвчин гэж ялган өвчний олон улсын 10-р ангиллын дагуу бичсэн байна.

### **Эмчилгээ, хоол сувилгааны заалт**

- Эмчилгээ нь өвчний шалтгаан, эмгэг жам, шинж тэмдэгт чиглэсэн байна.
- Эмчилгээ, хоол, сувилгааны заалтыг үзлэгийн тэмдэгдэл хэсэгт бичих заалтыг өөрчлөх, хуудас эргүүлэх бүрт бичнэ.
- Жижүүр эмчийн заасан эмчилгээ нь зөвхөн тухайн жижүүрийн хугацаанд хүчинтэй байна. Уг эмчилгээг үргэлжлүүлэн хэрэглэх тохиолдолд эмчлэгч эмч дахин бичнэ.
- Эмийн олон улсын нэр, тун, тун хоорондын зай, хэрэглэх арга, давтамж, хугацааг тодорхой зааж бичнэ.
- Эм нэмсэн, хассан, өөрчилсөн тохиолдолд өдрийн тэмдэглэлд үндэслэлийг тусгана.
- Мэс ажилбар хийхдээ 16 хүртэлх насны хүүхдэд эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг авна.

### **Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх:**

- Эмчлүүлэгчид цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх үндэслэлийг эмнэлзүйн болон лабораторын үзүүлэлтэд тулгуурлан гаргаж, өвчний түүхэнд тэмдэглэн баримтжуулах холбогдох стандарт, удирдамжийг мөрдлөг болгоно.
- Цус, цусан бүтээгдэхүүн захиалах болох сэлбэсэн талаар зохих маягтуудыг бүрэн, гаргацтай хөтлөн, өвчний түүхэнд хавсаргана.
- Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоотой урвал хүндрэл, сөрөг урвал илэрсэн тохиолдолд мэдээлэх маягтуудыг бүрэн, гаргацтай бөглөн сэлбэсэн цус, цусан бүтээгдэхүүний үлдэгдэл, хувийн тохироо тодорхойлсон сорьц, урвал өгсний дараах сорьцны хамт цусны албанд хүргүүлнэ.

### **Хориглох зүйл**

- Өвчний түүхэнд баллах, дарах, **засах** зэрэг үйлдлийг хориглоно.
- Өвчний түүхийг эмчлэгч эмчээс өөр хүн бичихийг хориглоно.

### **Төрөлтийн түүх**

#### **Партограммийг хөтлөх заавар**

Партограммийг төрөлтийн идэвхтэй үе буюу умайн хүзүү 4 см нээгдсэн үеэс тэмдэглэж эхэлнэ.

Доорх зүйлийг партограмм дээр тэмдэглэнэ.

**Жирэмсэн эмэгтэйн тухай мэдээлэл:** нэр, нас, жирэмслэлт, төрөлтийн тоо, хүлээн авсан он, сар, өдөр, цаг, хором, ураг орчмын шингэн гарсан цагийг тэмдэглэнэ.

**Ургийн зүрхний цохилт:** хагас цаг тутамд тэмдэглэнэ.

**Ураг орчмын шингэний байдал:** Ураг орчмын шингэн гарсан тохиолдолд үтрээний үзлэг хийх бүрдээ шингэний өнгийг тэмдэглэнэ.

- Б: Ургийн шингэний бүрхүүл хальс бүтэн
- Х: Ураг орчмын шингэний бүрхүүл хальс урагдсан

- Т: Ураг орчмын шингэн тунгалаг
- З: Ураг орчмын шингэн зунгагны хольцтой
- Ц: Ураг орчмын шингэн цусны хольцтой

**Ургийн толгойн хэлбэржилт:**

- 1: + ясны ирмэгүүд хоорондоо дөнгөж нийлсэн байна.
- 2: ++ ясны ирмэгүүд зөрсөн байх ба хуруугаар дарахад зөрлөг нь багасна.
- 3: +++ ясны ирмэгүүд зөрж давхарласан, хуруугаар дарахад зөрлөг нь багасахгүй.

**Умайн хүзүүний нээгдэлт:** Үтрээний шинжилгээ хийх бүртумайн хүзүүний байдлыг үнэлж, хэрээсээр Х тэмдэглэнэ.

**Хянах шугам:**Умайн хүзүү 4 см ба түүнээс илүү нээгдэхэд эхэлж тэмдэглээд цагт 1 см –ээр нэмэгдэж бүрэн нээгдэх хүртэл зурагдана.

**Арга хэмжээний шугам:** Хянах шугамын баруун талд 4 цагийн зайтай параллель байрлана.

**Хэвлийг тэмтэрч ургийн толгойн доошлолтыг үнэлэхдээ:** Толгойг умдаг яснаас дээш тэмтрэгдэх байдлаас хамааруулж 5 барилд хуваадаг. Үтрээни йүзлэг бүрт тэмдэглэнэ. 0/5-д дух нь умдагны түвшинд байна.

**Цаг:** Хүлээн авснаас эхлэн цагийг тэмдэглэнэ.

**Хугацаа:** Хүлээн авснаас хойш /партограф хөтөлснөөс/ төрөлт үргэлжилж байгаа хугацаа.

**Базлалт:** Бүдүүвчийг хагас цаг тутамд, 10 хормын турш үзэж базлалтын тоог, үргэлжлэх хугацааг секундээр нь тэмдэглэж бөглөх.

- 20 секундээс бага: цэгчилж
- 20-40 секундын хооронд: ташуу зураасаар
- 40 секундээс их байх: бүрэн будна

**Окситоцин:** 30 хором тутамд 1 хормын турш дусч байгаа дуслын тоо, судсаар таригдаж буй шингэний доторх окситоцины нийт тун хэмжээг тэмдэглэнэ.

**Өгсөн эм:** Хэрэглэсэн эмийг тэмдэглэнэ.

**Судасны лугшилт:** 30 хором тутамд цэгээр /\*/ тэмдэглэнэ.

**Артерийн даралт:** 4 цаг тутамд /сумаар/ тэмдэглэнэ.

**Биеийн халуун:** 2 цаг тутам тэмдэглэнэ.

**Уураг, ацетоны хэмжээ:** Шээсний хэмжээ, бусад зүйлийг тэмдэглэнэ.

**Сувилагч, эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас СМ-1 Хавсралт 11, Сувилгааны тэмдэглэл СМ-2 Хавсралт 12, Өвдөлтийг хянах хуудас СМ-3 Хавсралт 13, Шингэний балансыг хянах хуудас СМ-4 Хавсралт 14**

1. “СТ-1А/Б Хавсралт 2 Өвчтөний амин үзүүлэлтийн хуудас”, “СМ-1 Хавсралт 11 Сувилагч эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас”, “СМ-2 Хавсралт 12: Сувилгааны тэмдэглэл,

сонгомлоор “СМ-4 Хавсралт 14: Шингэний баланс хянах хуудас”, “СМ-3 Хавсралт 13: Өвдөлт хянах хуудас”-ыг бүхэлд нь “Сувилгааны түүх” гэж нэрлэнэ.

2. Сувилгааны түүх нь сувилахуйн мэргэжлийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн тухайг баримтжуулан, нотолгоо болох үүднээс өвчний түүхийн хамт хадгалагдана.
3. СТ-1А/Б Хавсралт 2 Өвчтөний амин үзүүлэлтийн хуудас сувилах эрх бүхий сувилагч, хэвтэн эмчлүүлж буй хүүхэд, насанд хүрэгчдэд, “СМ-1; СМ-2; СМ-3; СМ-4” маягтыг эрчимт эмчилгээний тасгаас бусад хэвтэн эмчлүүлж байгаа насанд хүрэгчдэд хөтлөнө.
4. “СМ-1; СМ-2; СМ-3; СМ-4” маягтыг (хүүхдийн, эрчимт эмчилгээний) хэвтэн эмчлүүлэх тасаг болон хэвтэн эмчлүүлэхээс бусад тасаг, нэгж, амбулаторийн сувилахуйн тусламж, үйлчилгээнд хэрэглэх асуудлыг тухайн байгууллагын сувилгааны албаны шийдвэрийг үндэслэн бүтнээр болон сонгомол, хэсэгчилсэн байдлаар хөтөлж болно.
5. Сувилагч, сувилгааны түүхийг цэвэр, гаргацтай, нямбай хөтлөн, гарын үсгийг товчлохгүй бичих бөгөөд энэхүү үйл ажиллагаанд тасгийн ахлах сувилагч өдөр тутмын хяналт, үнэлгээг тавьж хэрэгжүүлнэ.
6. Сувилгааны түүхийг өвчний түүхтэй хамт байхаар хавтаст баримт үүсгэх боловч, сувилгааны түүхийн хэсгийг нь сувилагч шаардлагатай үед дангаар нь авч сувилах үйл ажиллагаанд хэрэглэх боломжтой байдлаар хэвлэсэн байна.

#### **Эмчлүүлэгчийн биеийн байдлыг сувилагч, анхлан үнэлэх.**

1. СТ-1А,Б Хавсралт 2 хуудсыг хүлээн авах, яаралтай тусламжийн тасгийн сувилагч эхэлж, цаашид тухайн ээлжинд ажиллаж буй өдрийн болон ээлжийн сувилагч үйлчлүүлэгчийг эмнэлгээс гарах хүртэл хөтөлнө.
2. СМ-1; СМ-2; СМ-3; СМ-4 хуудсыг эмчлүүлэгчийг эмнэлэгт хэвтсэний дараах 24 цагт багтаан хөтөлнө. Энэхүү 24 цагийн дотор ямар ээлжинд, ямар сувилагч эхний үнэлгээг өгөх тухай асуудлыг, сувилагчдын ажлын ачааллыг тэнцүүлэх дотоод зохицуулалтын зарчмаар, сувилгааны албаны дарга журамлана.
3. Эмчлүүлэгчийн биеийн байдлыг сувилагч анхлан үнэлснийг тасгийн ахлах сувилагч (арга зүйч) шалган баталгаажуулж, үнэлгээг хэдий хугацааны дараа дахин хийх шаардлагатайг СМ-1 хуудасны тусгай тэмдэглэл хэсэгт бичиж тэмдэглэнэ.
4. Цаашид ахлах сувилагчийн тэмдэглэлийг үндэслэн тухайн ээлжийн болон өдрийн сувилагч нар хөтөлнө.

#### **Хөтлөх заавар.**

##### **СТ-1А/Б Хавсралт 2 Өвчтөний амин үзүүлэлтийн хуудас**

1. Хуудсыг сувилагч, эмчлүүлэгчийн биеийн халуун, цусны даралт, судасны лугшилт, амьсгал хэвийн хэмжээндээ байгаа эсэхийг үзэж, амьсгалыг -хөх, биеийн халууныг -хар, судасны цохилтыг -улаан өнгийн балаар зохих хүснэгтэд бөглөнө.
2. Энэхүү хуудсанд цусны даралт, хоолны дугаар, биеийн жинг үзэж, өтгөн шингэний давтамжийг асууж тэмдэглэн, гарын үсэг зурж баталгаажуулна.
3. Хуудсыг ээлжийн сувилагч нар өдөр бүр хөтөлнө.

##### ***Сувилагч эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас (Маягт СМ-1)***

1. Хуудсыг хөтлөхдөө үйлчлүүлэгчийг аль болох түүнд эвтэйхэн байрлалд байлган асуух, ярилцах, биеийн байдлыг амьсгал, зүрх судасны хэсгээс эхлэн үнэлэх, бодит үзлэг хийх

хэлбэрээр хөтлөх ба үйлчлүүлэгчийн нэмэлтээр хэлсэн өгүүлэмжийг сонсч, тэмдэглэх байдлаар хөтөлнө.

2. Үнэлгээний асуулт бүрт тохирох хариултыг тус хуудасны ард буй \*зааврын дагуу тийм, үгүй, хамаарахгүй гэсэн тэмдэглэгээний аль нэгээс сонгон тэмдэглэнэ.

3. Эдгээр тэмдэглэгээний аль нэгийг тавиагүй, тэмдэглэгээ хийгдээгүй нүд үлдээж болохгүйг анхаарна.

4. Сувилагч, тухайн бүлэг асуудлыг үнэлж дуусаад (Жнь: амьсгал, зүрх судасны бүлэг) түүний ард буй сувилгааны асуудлуудаас тохирох нэг асуудлыг сонгон түүний дугаарыг үнэлгээний төгсгөлд буй бүлэг асуудлын (7) нэрний ард байрлах нүдэнд тэмдэглэнэ. Ж-нь: Ханиалгалт, цэртэй гэж үнэлсэн бол “Амьсгалын замын цэвэршилт алдагдсан” гэсэн асуудлыг сонгон “#3” тэмдгийг тохирох нүдэнд тавьж, сувилгааны тэмдэглэл(СМ-2)-ийн асуудлын дугаар мөрөнд оруулж, сувилах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж, дүгнэх зарчмаар ажиллана.

5. Үнэлгээний хэсгийн бүх үзүүлэлт хэвийн гэж үнэлсэн бол энэ хэсэг дээр сувилах төлөвлөгөө зохиох шаардлагагүй бөгөөд, харин өдөр тутам үзүүлсэн асаргаа, сувилгааны хэсэг болон бусад үзүүлсэн сувилахуйн тусламж, дараагийн ээлжийн сувилагч анхаарах асуудлыг заавал бичиж тэмдэглэнэ.

### **Сувилгааны тэмдэглэл (Маягт СМ-2)**

1. Сувилагч СМ-1 хуудас буюу үнэлгээг үндэслэн эмчлүүлэгчид хийсэн асаргаа сувилгаа, эмчийн заалтын дагуу хийсэн эмчилгээг тухайн үйлдлийг хийсэн тухай бүрт бичиж тэмдэглэх зорилготой.
2. Эмчлүүлэгчийн биеийн байдалд өгсөн үнэлгээ, гарсан асуудал бүрийн дагуу сувилахуйн тусламж үйлчилгээг “сувилах төлөвлөгөө” хэсэгт эмчлүүлэгчтэй харилцан ярилцаж, зөвшилцөж, төлөвлөх ба асаргаа сувилгааг хийсний дүнд өвчтөний биеийн байдалд гарсан гол үр дүн, дүгнэлт, тэмдэглэлийг “хэрэгжүүлэлт/ дүгнэлт” гэсэн хэсэгт бичиж гарын үсгээр баталгаажуулна.
3. Эмчлүүлэгчийн биеийн байдлаас /хүнд, хөнгөн/ шалтгаалан сувилгааны үнэлгээгээр илрүүлсэн асуудлыг бүрэн арилтал сувилагчийн авсан арга хэмжээ, үзүүлсэн асаргаа сувилгааг цаг алдалгүй бичиж, тэмдэглэнэ.

### **Сонгомолор хэрэглэх сувилгааны тэмдэглэлүүд**

1. Маягт СМ-4 Шингэний баланс хянах хуудас
2. Маягт СМ-3 Өвдөлтийг хянах хуудас /сонгомолор хэрэглэх/

1. Шингэний баланс хянах (СМ-4) хуудсыг хөтлөх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд сонгомолор биед орсон болон биеэс гарсан шингэний тэнцвэрт байдлыг хянах зорилгоор сувилагч нэг бүрчлэн хэмжиж тэмдэглэх буюу эсвэл асран халамжлагчид орсон гарсан шингэнийг хэрхэн хэмжих тухай зааж тэмдэглүүлнэ. Сувилагч хянаж, гарын үсэг зурж баталгаажуулна.
2. Өвдөлтийг хянах (СМ-3) хуудсыг өвдөлтийг үнэлэх, өвдөлтийг багасгах сувилгааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх зорилгоор их өвдөлттэй эмчлүүлэгчид сонгомолор авч хэрэглэнэ.

3. Эмчлүүлэгч өөрөө өвдөлтийн хүчийг тодорхойлж чадахгүй байгаа тохиолдолд нүүр царайны байдлаар харуулсан зургийг ашиглан тодорхойлж болно.
4. Хуудсыг сувилагч хөтлөн, баталгаажуулна.

### Гемодиализын хяналтын карт СТ-2-ыг гемодиализын тасаг нэгжид эмчлэгч эмч хөтлөнө.

Стандартаар эмчилгээнд орсон хүний тоо гэдэг нь Бөөрний өвчний төгсгөлийн шатанд орсон хүний эмчилгээний стандартаар 7 хоногт 12-15 цаг аппаратад орох заалттай. Энэ заалтын дагуу 7 хоногт 12-15 цагаар орсон хүнийг хэлнэ.

Стандарт бусаар орсон үйлчлүүлэгдийн тоо /багана 23/ гэдэг нь 7 хоногт 12 цагаас бага хугацаагаар орсон хүнийг хэлнэ.

Тухайн онд хийгдсэн нийт сеансын тоо гэдэг нь 1 өвчтөн 1 удаад диализын аппаратад 4 цаг орох ёстой. Өвчтөнийг 1 удаад 4 цагийн хугацаанд аппаратад оруулсан тоог бичнэ.

### “Төрөлхийн хөгжлийн гажгийг мэдээлэх хуудас” СТ-11 хөтлөх заавар

СТ-11 маягтыг аргачлал, жишээг ашиглан хөтөлнө.

Асуумж	Аргачлал-Тодорхойлолт - Жишээ
	<b>А. Ерөнхий мэдээлэл</b>
Асуулт 1: Мэдээлсэн он, сар, өдөр	Эмч мэдээлэх хуудсыг бөглөсөн хугацааг он, сар, өдөр, цаг, минутаар бичнэ. Жишээ: <u>2014</u> он <u>4</u> сар <u>8</u> өдөр <u>13</u> цаг <u>30</u> минут гэж тэмдэглэнэ.
Асуулт 2: Мэдээлсэн газар	Мэдээлсэн газрын талаар дэлгэрэнгүй бичнэ. Жишээ: Мэдээлсэн газар: Аймаг/хот: <u>Ховд</u> Сум/дүүрэг <u>Манхан</u> Эмнэлгийн нэр: <u>Сумын эрүүл мэндийн төв</u> Мэдээлсэн эмчийн нэр: <u>Дашийн Дэлгэрмаа</u>
	<b>Б. Эхийн талаарх мэдээлэл</b>
Асуулт 1: Эхийн регистрийн дугаар	Регистрийн дугаарыг бөглөхдөө тухайн нярайн эхийн иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ. Регистрийн дугаар гэсэн 10 нүд бүхий хүснэгтийн эхний 2 нүдэнд үсгийг том үсгээр, сүүлийн 8 нүдэнд цифрийг тус бүрт гаргацтай бичнэ. Жишээ: <u>А Н 8 6 0 2 2 4 6 5</u>
Асуулт 2: Төрөх үеийн эхийн нас	Төрөх үеийн эхийн нас гэсэн 2 нүд бүхий хүснэгтэд эхийн төрсөн оныг үндэслэн насыг тооцоолж бүтэн насаар бичнэ. Жишээ: <u>1985 онд төрсөн эх байвал 2014 оноос 1985-г хасаж 29</u> гэж тооцож бичнэ.
Асуулт 3: Байнгын оршин суудаг хаяг	Эх жирэмсэн үедээ оршин сууж байсан газрын хаягийг аймаг/хот, сум/дүүрэг, баг/хороо зэргээр гаргацтай бичнэ.

Асуулт 4: Хэд дэх төрөлт

Энэ төрөлт эхийн хэд дэх төрөлт болохыг өгөгдсөн кодоос сонгоно. Анх удаагаа төрж байгаа бол 1 дэх буюу 1 гэсэн кодыг, 2, 3, 4 дэх төрөлт бол 2-4 буюу 2 гэсэн кодыг 5 ба түүнээс дээшхи төрөлт бол 5 ба түүнээс дээш буюу 3 гэсэн кодыг, төрөлтийн талаар мэдээлэлгүй бол мэдээлэлгүй буюу 4 гэсэн кодыг сонгоно.

Асуулт 5: Өмнөх жирэмслэлтийн төгсгөл

Өмнөх жирэмслэлтийн тоог бичихдээ өмнө нь хэдэн удаа амьд хүүхэд төрүүлж байсан, хэдэн удаа амьгүй хүүхэд төрүүлж байсан, хэдэн удаа зулбаж, үр хөндүүлж байсан, хэдэн удаа өсөлтгүй, умайн гадуур жирэмсэлж байсан зэргийг тоогоор бичнэ.

Жишээ: 1. Зулбалт  2. Үр хөндөлт

3. Өсөлтгүй жирэмсэн

4. Умайн гаднах жирэмсэн

5. Амьгүй төрөлт  6. Амьд төрөлт

### В. Нярайн талаарх мэдээлэл

Асуулт 1: Хүүхдийн төрсөн он, сар, өдөр

Нярайн төрсөн он, сар, өдрийг тодорхой бичнэ. Жишээ: Нярай 2014 он 3 сар 16 өдөр гэж тэмдэглэнэ.

Асуулт 2: Төрөх үеийн тээлтийн нас

Нярайн төрөх үеийн тээлтийн насыг долоо хоног, хоногоор бичнэ. Тээлтийн насыг сүүлийн сарын тэмдгийн эхний өдрөөс эхлэн тооцно.

Жишээ:   долоо хоног  хоног

Асуулт 3: Төрөх үеийн жин

Нярайг үзсэн эмчийн анхны үзлэгийн биеийн жинг бичиж тэмдэглэнэ.

Асуулт 4: Хүйс

Нярайн хүйсийг эр-1, эм-2 гэж дугуйлна. Хүйс тодорхойгүй бол-3, мэдээлэлгүй бол-4 гэж сонгоно.

Асуулт 5: Хүүхэд ихэр эсэх:

Энэ төрөлтөөр ихэр хүүхэд төрсөн эсэхийг тийм-1, үгүй-2 гэж сонгоно. Ихэр хүүхэд төрсөн бол хэдэн ихэр төрснийг кодоос сонгоно: 2 ихэр бол-1, 3 ба түүнээс олон ихэр бол-2, хэдэн ихэр төрсөн талаар мэдээлэлгүй бол 3 гэж сонгоно. Ихэр хүүхэд төрсөн бол асуулт 6-д хариулна. Ихэр төрөөгүй бол асуулт 7 руу шилжинэ.

Асуулт 6: Ихэр хүүхэд бол хэдэн хүүхэд нь гажиг илэрсэн бэ?

Ихэр хүүхдийн хэдэн хүүхэд нь төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн болохыг өгөгдсөн кодоос сонгоно.

Асуулт 7: Хүүхэд амьдарсан эсэх

Төрөлхийн хөгжлийн гажигтай хүүхэд амьдарсан бол тийм-1, эндсэн бол үгүй-2 сонгоно. Эндсэн бол асуулт 8 руу шилжинэ. Хүүхэд амьдарсан бол асуулт 8-ыг алгасна.

Асуулт 8: Үгүй бол хүүхэд эндсэн нас

Хүүхэд эндэх үеийн насыг хоног цаг минутаар бичнэ. Жишээ: Хоног 03 цаг 1  минут

### Г. Оношилгоо

Асуулт 1: Оношилогдсон хугацаа

Төрөлхийн хөгжлийн гажиг анх оношилогдсон хугацааг тохирох кодоос сонгоно. Эхийн умайд пренаталь оношилгоогоор оношилогдсон бол асуулт 2, 3-т хариулна. Төрөх үед, төрсний дараа оношилогдсон бол асуулт 5 руу шилжинэ.

Асуулт 2: Пренаталь оношилгоогоор хөгжлийн

Пренаталь оношилгоогоор ургийн гажиг оношилогдох үеийн ургийн насыг долоо хоног, хоногоор бичнэ.

**гажиг оношилогдох үеийн ургийн нас**

Асуулт 3: Пренаталь оношилгооны шинжилгээгээр анх илэрсэн бол

Пренаталь оношилгооны шинжилгээнд эхогоор оношилогдсон бол жирэмсний ямар хугацаанд оношилогдсоныг тохирох кодоос сонгоно. Эхоноос бусад шинжилгээгээр оношилогдсон бол бусад гэсэн кодыг сонгож ямар шинжилгээ болохыг дэлгэрэнгүй бичнэ.

Асуулт 4: Задлан шинжилгээгээр оношилогдсон эсэх

Задлан шинжилгээгээр анх оношилогдсон бол тийм-1, оношилогдоогүй бол үгүй-2 кодыг дугуйлна. Тийм кодыг сонгосон бол оношилгоо хэсгийн асуулт 1, 2, 3-ыг бөглөхгүй орхино.

Асуулт 5: Оношилогдсон гажиг мэс заслын аргаар эмчлэгдэх боломжтой эсэх

Тухайн гажиг мэс заслын аргаар эмчлэгдэх боломжтой эсэхийг тохирох кодоос сонгоно. Эмчлэгдэх боломжтой бол тийм-1, эмчлэгдэх боломжгүй бол үгүй-2 гэж сонгоно.

Асуулт 6: Нярайд илэрсэн төрөлхийн хөгжлийн гажгийн хэлбэрийг эрхтэн, тогтолцоогоор нэг бүрчлэн оношийг бичнэ үү

Тухайн нярайд илэрсэн гажгийг эрхтэн тогтолцоо тус бүрээр дэлгэрэнгүй тоочиж бичнэ. Төрөлхийн бодисын солилцооны эмгэг байвал бусад төрөлхийн гажиг гэдэгт оношийг бичнэ.

Асуулт 7: Хүүхдийн зураг, лабораторийн ба дүрс оношилгооны нэмэлт материал дагалдсан эсэх

Хүүхдийн төрөлхийн хөгжлийн гажиг гэсэн оношийг батлах хүүхдийн зураг, шинжилгээ, оношилгооны нэмэлт материалыг маягтын хамт хавсарган явуулсан бол тийм-1, явуулаагүй бол үгүй-2 гэж дугуйлна.

Асуулт 8: Нярай ба ургийн кариотип тодорхойлох шинжилгээ хийсэн эсэх

Хромосомын гажиг байгаа тохиолдолд хромосомын гажгийг батлах кариотипийн шинжилгээ хийсэн бол тийм-1, хийгээгүй бол үгүй-2 гэж сонгоно. Кариотипийн шинжилгээ хийсэн бол тухайн кариотипийг тохирох зайд бичиж тэмдэглэнэ.

**Д. Нөлөөлөх хүчин зүйл**

Асуулт 1: Цусан төрлийн гэрлэлт

Эцэг, эх нь хоорондоо цусан төрлийн хамаатан эсэхийг кодоос сонгож дугуйлна.

Асуулт 2: Эцгийн нас

Эцгийн нас гэсэн 2 нүд бүхий хүснэгтэд эцгийн төрсөн оныг үндэслэн насыг тооцоолж бүтэн насаар бичнэ. Жишээ: 1980 онд эцэг нь төрсөн байвал 2014 оноос 1980-г хасаж 34 гэж тооцож 3 4 бичнэ.

Асуулт 3: Эцгийн эрхэлсэн ажил

Эцгийн эрхэлдэг ажлыг сонгохдоо тохирох хариултыг дугуйлна. Дээрх хариултын алинд нь ч орохгүй бол бусад гэсэн хариултыг дугуйлаад тодорхой бичнэ.

Асуулт 4: Эхийн боловсрол

Эхийн сурч төгссөн боловсролын хамгийн дээд зэргийг сонгоно. Сурч байгаагүй бол боловсролгүй, боловсролын талаар мэдээлэлгүй бол 6 гэсэн кодыг сонгоно.

Асуулт 5: Эхийн эрхэлсэн ажил

Эхийн эрхэлдэг ажлыг сонгохдоо тохирох хариултыг дугуйлна. Дээрх хариултын алинд нь ч орохгүй бол бусад гэсэн хариултыг дугуйлаад тодорхой бичнэ.

Асуулт 6: Эх нь жирэмсний эхний 16 долоо хоногийн дотор тамхи татсан эсэх

Эх жирэмсний эхний 16 долоо хоног буюу жирэмсний эхний 4 сар дотор тамхи татсан бол тийм-1, тамхи татаагүй бол үгүй-2 кодыг дугуйлна. Тамхи татсан бол өдөрт татсан тамхины тоог ширхэгээр сонгож дугуйлна.

Асуулт 7: Ойр дотны хамт амьдардаг хүмүүс нь эхийн

